

Б.Шүндэрцэцэг



ЧИМЭЭГҮЙ
ХАШГИРААН

Чимээгүй хашгираан
Зохиолч: Б.Шүүдэрцэцэг

ISBN: 978-99962-4-090-4

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Чимээгүй хашгираан

(тууж)

Чинбат зүүрмэглээд авчээ. Онгоцонд яваагаа ч мартаж, хажуудаа Чимгээг байгаа мэт санан гараа явуулан тэмтгээд суудлын бариулд хүрчихээд давхийн сэрэв. Онгоцны цонхоор өглөө эртийн Улаанбаатар угаан дунд тодрон харагдаад ирэв. Нисэхийн зурвас, ганц нэг онгоц торойх эл хульхан талбай. Тэр хүрээд ирлээ. Гэртээ ирлээ гэхээр эхнэрийнх нь тухай бодол орж ирэн, цээж хөндүүрлэн сэтгэлийн гүнд хаа нэгтээ чандын чанад нуугдсан эмзэг, далд шарх сэдрэх мэт хөндүүрлэв. Тэр тухай бодохгүй, хүйтэн цустай байхыг хичээн булзааруулах тусам санаанд дүр нь илхэн, сэтгэлд орон зай нь онгойн байх нь хэцүү. Онгоц аажуухан газардаж, нойрмог нүдэлсэн ч урт аяны зам амар жимэр дууссанд баярласан зорчигчид алга ташин хөгжилдөж буухад бэлтгэн хөдөлгөөнд орцгоов. Ямар нэгэн аяллын эцэст гэр рүүгээ яаран сэтгэл дэнслэх гэдэг эгэл хүний хувьд хичнээн хэмжээлшгүй аз жаргал байдгийг тэр энэхэн мөчид сэхээрэн хүнд санаа алдав. Түүнд яарах юм алга байлаа. Хэндээ ч гэж яарах вэ? гэж бодохоор сэтгэлд гуниг төрнө.

Чимгээ тэр хоёр суугаад ганцхан жил болж байсан юм уу даа. Ямар ч гэсэн охин нь дөнгөж хөлд орж байсан юм даг. Долоо хоногоор Москвад семинарт явах болоод сарын цалингаа урьдчилан авч рубль болгоод, эхнэр нь Их дэлгүүрийн өндөр үнэтээс шинэ костюм авч тэр нь томдчихоод явахын нь урьд шөнө Урт цагаанд хасуулаад авчирч байж билээ. Мань эр ч эхнэр охин хоёртоо бэлэг авах гэж долоо хоног хоолоо сойн бүсээ чангалж байгаад ирэхдээ ямар их баяр хөөр, хүлээлт, яарсан сэтгэлийн догдлол дунд бууж байлаа даа. Гэрийнхэндээ бэлэг авсаар байгаад ерөөс нимгэн даржин хэтэвчинд нь ганц ч зоос үлдээгүй санагддаг юм. Тэгсэн хэр нь дэлхийн талыг ачаад ирсэн мэт хичнээн агуу баяр сэтгэлийг нь дүүргэж байсныг тодхон санаж байв. Чимгээ нь тэгэхэд нөхрөө тосох гээд охиноо тэврээд онгоцны буудалд ирчихсэн байсан. Хөхөө өвлийн хүйтэнд хамаг мөнгөөрөө таксидаад шүү. Үнэхээр яруухан залуу насны дурсамж даа. Түүнээс хойш арван хэдхэн жил өнгөрсөн ч өнө холын дурдатгал мэт алсад санагдах нь юуных вэ? Хүн гэдэг тийм мартамхай амьтан юм уу? Одоо тэгтэл хэтэвч нь дүүрэн байлаа ч сэтгэл хов хоосон болчихоо юу даа.

Нэгэнт ар тийш яарах юмгүй тул хүмүүсийн сүүлхэнд ачаагаа аваад гар тээшний тэргэнд тавьж түрсээр хөлөө зөөн алхлав.

Бодсоноор нь онгоцны буудал дээр түүнийг жолооч нь тосч байлаа.

-За сайн явж ирэв үү даргаа?. Алив ачаагаа нааш нь.

-Сайн явлаа. Сайн сууж байв уу? Өөрийнхөө дуу хоолойд нэг л тиймхэн урамгүй өнгө байгааг мэдрээд сүүлийн өгүүлбэрийг хэлэхдээ зориуд чанга дуугарчихаад өөртөө дургүй нь хүрэв. Чимгээгийн хэлдгээр жүжиглэх гэж ядчих юм аа.

Ирэхгүй гэдгийг нь мэдсээр байсан хэр нь Чимгээг олон хүний дунд залуугийнх шигээ инээмсэглэн, үл мэдэгхэн ичингүйрсэндээ хацраа ягааруулан зогсч байгаасай гэж битүүхэн хүсч байснаа сая л мэдрэв. Тийм дүр төрхийг нь харалгүй, онгоцонд суух, буухдаа гагцхүү

жолоочоороо үдүүлж, угтуулдаг болсоор хэдэн оныг үдсэн ч юм бүү мэд. Хэрэв өнөөдөр түүнийг эхнэр нь тосоод зогсч байсан бол, аль эсвэл ачаагаа жолоочдоо өгөөд зогсох энэхэн агшинд утасдаад ганц аятайхан үг хэлсэн бол түүнийхээ дотно дууг сонсоод л сэтгэл нь хайлаад явчих байлаа. Тэр ядарчээ. Аяны урт зам, харь газрын хөл үймээн, ажил хэрэг, холбоо, сүлбээ, дээр нь ар гэрийн хэрүүл, тэмцэл, хамгаас дотны хүн нь атал хар элгийн мэт холдсоор буй эхнэр, ер юм бүхэнд сэтгэл нь туйлдаж гүйцэж. Үүнийг Чимгээ хэрэв ойлгодог сон бол....

Үнэтэй, шинэхэн, дунд гарын “Samsonite” чемоданыг нь жолооч хар хүн гар тээшний тэрэгнээс эвлэгхэн буулган тэрэгнийхээ арын ачааны чингэлэгт хийх зуур царай руу нь сэрэмжлэнгүй харахыг тэр анзаарав.

-Маргааш Герман явлаа. Чи минь юу захих вэ?

-Тэгж өөрийгөө зовоож яах нь вэ. Надад юу ч хэрэггүй.

-За боль доо. Хүний сэтгэл бодоход яадаг юм!

-Чамд сэтгэл гэж байдгийм уу? Тэр баарны хүүхнүүддээ новш авчрахгүй юу!

-Дура!

Урьд нь түүнээс “Чи өөрийгөө л аваад ирвэл хамгийн том бэлэг тэр” гэхийг нь сонсч баярладаг, тэгээд ирэхдээ тэр л дулаахан чин сэтгэлийн үгийг нь санан санан ямар нэг үнэт эдлэл, гоё чамин юм аваад урамтай ирдэг байсан сан.

Хаалга тасхийн хаагдаж тэр уурандаа үнсний саваа араас нь чулуудсан хойноо сая биеэ барих сэхээ орсон.

Тэр нэг хаалттай бааранд хоёр оросыг зугаацуулах гэж орсон нь ажлын эрх ашиг байсан шүү дээ. Юу гэдэг нэртэй ч билээ, аа тийм, “White lotus” гэсэн байх аа. Ажлын эрх ашиг гэдэг чинь гэр орныхоо төлөө, гадаадад сурдаг охиныхоо дараа жилийн төлбөрийг, Чимгээгийн ээжийн өөрөө хэлбэл хадам ээжийнхээ эмчилгээний мөнгийг, ер нь санаанд ороогүй байтал геометрийн прогрессоор өсөөд байдаг өрхийн элдэв зардлыг олох гэж яваа гэсэн үг гэдгийг яагаад эхнэр нь ойлгодоггүй юм бэ? Тэгээд яахав дээ, тэндхийн үйлчлэгч, тайчигч нүцгэн хүүхнүүдийн нэг нь ирээд л өвөр дээр нь суучихаа биз. Энүүхэндээ гэхэд тэр нь үнэхээр аятайхан амьтан байсан л даа. Тийм дэл сул хөнгөн явдалт хүүхнүүдийн дэргэд байхад аятайхан санагдах үе байдаг нь үнэн. Тэр хүүхний чанга гөлгөр арьстай гоолиг бие, цэл залуу насных нь өнгө жавхааг илтгэсэн цулцгардуу хацар, тунгалаг нүд, гялалзан сугсарсан задгай үс юм бүхэн нь нүд татаж, (нүд шүү, сэтгэл биш) байсан. Ний нуугүй хэлэхэд тэр бүсгүйн тунгалаг нүдний харц мөнгө зоосонд шунасан шуналын галаар гэрэлтэж байсан ч түүн шиг хүүхнүүдтэй байхад юунд ч сэтгэл чилээхийн зовлон байдаггүй! Эхнэртэйгээ бол зарим үед, дандаа биш л дээ, юу яривал уур нь хүрчих бол, өнөөдрийн болсон явдлын алийг нь цухуйлгахав, яажшуухан ая занд нь тааруулж аашлахав гэж болгоомжлон хагархай шилэн дээгүүр хөл нүцгэн явах шиг л юм болно. Нэг ёсондоо сэтгэлийн там гэсэн үг. Үнэндээ чилгэр чанга хөхөө гарган цээж нүцгэлсэн тэр хүүхэн өвөр

дээр нь суугаад зангиагаар нь оролдон наалинхайтахад, задгай үс нь цахилгаанжин ширхэг ширхэгээрээ нүүрийг нь гижигдээд үнэхээр таатай байсан ч өвөртөө оруулчихья гэсэн бодол төрөөгүйг бурхан гэрчилнэ дээ. Тэр бол зүгээр л нэг цаг зуурын зугаа байсан. Гэтэл эхнэр нь ороод ирсэн. Хүний гэргий, түүн шиг боловсролтой, өөрийгөө хүндэлдэг бүсгүйн байх ёсгүй газарт шүү. Хар цувны энгэр задгайлан үсээ хайш яйш ардаа шууж, нүд нь галзуурсан мэт гялалзаад зогсч байснаа “Шаар” гэнэ үү, юу гэнэв нэг тиймэрхүү үг хэлчихээд гүйгээд алга болсон нь түүний чухал ажлыг, түншүүдийнх нь зугаа цэнгэлийг, ер нь тэр үдшийг, тэр долоо хоногийг бүхэлд нь алга урвуулахын төдийд баллаж хаясан хэрэг. Ухаантайхан эхнэр байх гэдэг нь сүүлийн үед гадаад, дотоодод гарсан нийгмийн ухааны элдэв ном шагайх биш нөхрийнхөө сэтгэл гэдэг зузаан номыг ба бэ-гүй судлаад уруудахын нь цагт урмаар, өөдлөхийн нь цагт үнсэлтээр ч юм уу шагнахын нэр гэдгийг тэр яагаад ухаж ойлгодоггүй байна аа? Хэн нэг хорон санаатны чиглүүлсэн суманд оногдсон тэнэг туулай шиг хүний хатгаасанд ороод нөхрөө эрж тэр баларсан баараар гүйж, мөрдөж мөшгиж явахын оронд өнөөх гэгээн судруудаа эргүүлээд хүний гэргий шиг гэртээ тайван сууж байсан бол эр хүн л юм чинь улдаж унатлаа явж явж ядарч сульдаад халуун гал голомтондоо хэмээн тэмүүлсээр түүнийг гээд л очих байсан шүү дээ.

Жолооч нь хүртэл тэдний хэрүүл уруулд санаа зовон хулмагнаж байдаг. Ээ, хөөрхий Чимгээ минь дээ. Тэглээ гээд хэдэн өдөр дуугаа хураан, гадаад явахад нь хэрүүлээр үдэх хэрэг байсан гэж үү? Ер нь ингэхэд түүнийг тэр хаалттай, цөөхөн хүний жижиг хүрээнд үйлчилдэг тусгай бааранд байгааг эхнэр нь яаж мэдсэн хэрэг вэ? Хэн нэгнээс тэднийг хорлох гэж хэлсэн үгэнд хатгуулж яах гэж тийшээ очсон юм бол? Тэнэг тэнэг, бодолгүй бодолгүй гэхэд даанч дэндүү хэрэг. За тэгээд гэрийн хэрүүл яахав, тэгж байгаад учраа олох нь тодорхой. Харин хэн түүнийг эхнэртэй нь муудалцуулах гэж зориуд тэр бааранд суугааг нь хэлсэн байх вэ? Бодох л, сэтгэлээ чилээх л хэрэг.

Машин нь дөнгөж нисэхийн цагаан хаалганд хүрч явтал орлогч нь утасдав. Сайдын бие улам муудсан, маргааш гэхэд сайдын зөвлөлөөр оруулах асуудал бэлэн болсон зэргийг илтгэв. Тархи толгойноос нь гэрийнх нь хэрүүл, эхнэрээ өрөвдөх, өшрөх, хайрлах, харуусах сэтгэлийн хамаг л эгшгийг ийнхүү ажил хэргийн өршөөлгүй хүйтэн бодол хайр найргүй арчиж орхилоо...

Замын хажуугаар жирэлзэн өнгөрөх сурталчилгааны аварга самбаруудын зарим нь салбаран урагдаад дарцаг шиг далбаганан хийсэх нь хаврын салхитай бүүдгэр энэ өдрийн баргарыг улам нэмнэ. Засгийн газраар хэлэлцэх үндэсний хөтөлбөрийн төслийг өнөөдөр сайдын зөвлөлөөр хэлэлцэнэ. Сайд өвчтэй ч зөвлөл хуралдана. Гэхдээ хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр байхгүй, бас л нэг мөрөөдлийн хөтөлбөр. Ээлжит цаас үйлдвэрлэлийн дамжлагаар орох нэг бүтээгдэхүүн түүний хувьд тийм ч сонин биш байлаа. Сайд гадаадад эмчлүүлээд төдий л засал аваагүй ирж сайд нарын хоёрт хэвтээд лав хоёр долоо хонож байна. Сайд өвчтэйн сургаар Яаман дээгүүр ажил хийж байгаа хүн бараг байхгүй, компьютерээр хөзөр тоглон, утсаар ярьж, интернетээр сонин уншиж дургүй хүрсэн хүнээ доош нь хийсэн сэтгэгдэл бичсэн шиг цаг өнгөрөөж байгаа нь ойлгомжтой. Харин тэр? “Танай сайдын зам мөр шулуудсан шиг байна. Алтан хайрцгийг нь нээлгэвэл хойд зүгт хонин гүрвэл болж төрнө гэх байлгүй. Одоо чамайг л зүтгүүлнэ дээ. Алхах гишгэхээ хүртэл хянаж яв. Энэ бол эр хүнд олдоод байдаггүй боломж гэж бодоорой” гэсэн үгийг Гишүүнээс сонсоод нэг талаас хүн ёсны

хувьд амьд хүний суудалд санаархах нь эвгүй санагдан ширвээдсэн ч нөгөө талд сайдын суудал сэтгэлд нь гэрэлтээд ирсэн. Сайдын сэнтий гэдэг чинь Исмэл тайж Батмөнх хааны эзгүй сууринд ганцаараа сандайлж үзээд сэрүүн зүүдлэн тас тас хөхөрдөг шиг ойрын жилүүдэд мөрөөдөх ч аргагүй “тэнгэрийн умдаг” гэдэг шиг юм байсан биш үү? Сайдын суудал онгойж, тийшээ зүтгээд үзэхийг гишүүн сануулж байгаагийн дэргэд Чимгээтэй ам мурийсэн нь юу ч биш санагдан сэтгэл цэлмээд ирэхийгээ мэдрээд өөрийгөө хичнээн өөдгүй амьтан болсныг ойлгосон нь бас л цээжинд нэгэн хөндүүр бий болгож билээ. Яая гэхэв улстөр хэмээх шавар балчигт хөлөө нэг л дүрсэн бол тэндхийн өршөөлгүй хатуу дүрмээр эцсээ хүртэл тоглон, хүн чанар, эрүүл саруул сэтгэлгээг ор тас мартан хэн аргатай, хүчтэй нь дийлж сүргээ толгойлдог араатны ертөнцийн хуулиар өрсөлдөгчдөө хайр найргүй тас татан урагшлахаас өөр аргагүйгээс хойш.

Яармагийн гүүрээр гарч явтал хүүгээс нь мессэж ирэв. “Ээж Нүхтэд семинартай. Би эмээгийн байгаа. Хөргөгчинд хоол байгаа гэсэн” гэжээ. Энэ эхнэрийнх нь бол эсэргүүцлийн алхам байх нь. Нөхрөө харь холоос ирж байхад Нүхтэд семинардаад хөргөгчинд хөлдүү бууз тавьчихаад, өвчтэй эх дээрээ хүүгээ орхичихсон байдаг. Онгоцноос бумагц сайдын бие муу байгааг сонсоод далд түгшүүр нь амсхийгээд явчихсан сэтгэлийн амар амгалан нь түр мартагдаад байсан гэр орны хэрүүлийн хүйтэн салхинд хийсэн одов. Яг л сэлэмний хуучин шарх тэнгэр муухай аашилсан өдрөөр бүр нэг цаагуураа хоржоонтойгоор янгинан өвддөг шиг. “Чи албан тушаалын дон тусаад хүн биш болох нь ээ! Энгийн нэг дээд сургуулийн багш байхдаа чи хүн шиг хүн байсан даа.” гэж эхнэр нь ээлжит нэг хэрүүлийн үеэр хорсолтой хэлсэн нь сэтгэлд хадагдан үлджээ. Өөрийг нь “хүн биш болсны” төлөө эхнэр нь эсэргүүцэл зарлаад удаж байгаа юм. Гэхдээ даанч дэндүү юм. Ханилсан ханиа сайнтай муутай нь хайрлах сэтгэл гэж тэр хүнд үлдсэнгүй гэж үү?

Гэртээ очиж чемоданаа орхиод аяга цай ууж амсхийгээд ажил дээрээ очъё гэсэн бодлоо өөрчилж “Ажил руу...” гэж жолоочдоо зөөлхөн хэлэхдээ түрүүн онгоцны буудал дээр ширүүн сүртэй дуугаран сэтгэлийн хямралаа нуух гэж ядаж байснаа ч мартжээ. Жолооч нь дуугүйхэн толгой дохихдоо урдахь толиндoo өөрийнх нь царай руу хяламхийхийг Чинбат ажиглаад санаа алдав. Утас нь ядаргаатайгаар чичирхийлэн хамаг бодлыг нь сарниулчихав. Харвал нэг л танил дугаараас дохиж байна. Хэнийх болохыг санахаас ч төвөгшөөнө. Уут нь задарсан будаа мэт тал тал тийшээ асгарсан ухаан бодлоо эмхлэх хэрэгтэй байлаа. Өнөө орой нэгэн хүнд арван мянган доллар олж өгөх ёстой. УИХ-ын Х хэмээх нэгэн гишүүн л дээ. Түүнийг сайд болгох хөшүүргийг нь атгаж байгаа хүн. “Гадаадад сурдаг хүүхдийнх нь нэг жилийн төлбөрийг хийчихээрэй. Тэгвэл товчлуураа чиний төлөө дарчихна. Төрийн нарийн болоход чинь ч дэмжсэнийг мартаж болохгүй” гэж өөрийнх нь ивээгч гишүүн явахынх нь урьд үдэш хэлсэн билээ. “Х гишүүнд өгөх мөнгийг өнөө орой яаж бэлэн болгох вэ?” гэсэн бодлыг нь үргээн туслах нь ярьж байна.

-Та шууд ажил дээрээ ирэх юм уу?

-Тэгнэ.

-Даргаа, нөгөө гишүүний сурталчилгаанд явж байсан сурвалжлагч Тамир яриад байна. Тантай холбоотой нийтлэл тэдний сонинд ирчихээд байна гэнэ.

-Юун нийтлэл вэ? Мөнгө нэхээд байгаам уу, тэгээд?

-Тийм л юм шиг байна. Бас танай нутгийн зөвлөлийн хоёр хүн ирчихээд хүлээж байна.

-Намайг өнөөдөр ажил дээрээ ирэхгүй гээд нутгийн зөвлөлийнхнийг явуулчих.

-За. Сурвалжлагчийг яахав?

-Наад дуракийгаа үдээс хойш залга гэж хэл.

-Та өнөөдөр хоёр цагаас төслийн зөвлөхүүдтэй уулзалттай шүү.

-Тийм бил үү?

-Орой 5-д дэд сайд эмнэлэг рүү явна гэсэн.

-Сайдыг эргэх бол намайг хамт явна гэж хэлээрэй.

-Би хэлчихсэн.

-Сайн байна.

Туслах гэж ёстой туслах шүү. Ийм сайн залуу олж өгсөнд хадам ахдаа талархаад баршгүй.

Тэр муу сурвалжлагч юу олж шиншилчихээд эргэлдээд байгаа юм бол? Санаа зовоох юм мундахгүй юм аа. Ялангуяа дэд сайдад бодолтой хандах хэрэгтэй. Тэр чинь жинхэнэ сайдын хүн. Баруун гар нь гэсэн үг. Дэд сайдыг дагаад хэвтэрт байгаа сайдаа эргэхгүй бол болохгүй. Өөрөөс нь илүү итгэлтэйгээр сайдын суудалд санаархаж яваа нь мэдээж.

Чимгээгийн хэлсэн үг дандаа голыг нь олоод хатгачихсан байдгийг яана. Албан тушаалын хэнээ ийнхүү өнөөдөр амьд сэрүүн байгаа хүнийг аль хэдийн оршуулчихаад өөрөө суудалд нь суух гээд элдвээр хор найруулахад хүргэж байдаг. Үнэн хэрэгтээ хэтэвч хоосон ч гэсэн сайхан мөрөөдөл, хийж бүтээх, судалж шинжлэх хүслээр дүүрэн цэл залуухан, нэр хүндтэй дээд сургуулийн багш явахдаа бодох санах юмгүй хичнээн аз жаргалтай байснаа тэр дотроо хүлээн зөвшөөрдөг юм. Заримдаа ч эрх мэдэл, мөнгө хоёр хүнд аз жаргал авчирдаггүйг сэтгэлийн гүндээ хүлээнэ гэдэг гунигтай л байдаг юм...

Туслах нь дахиад л залгаж байна. Энэ үед машин хот дундуур ороод ирсэн байлаа. Бороонд угаагдсан Берлиний гял цал, шугам шиг тэгшхэн, засч янзалсан зүлэг мод, нүүрээ угаасан бүсгүй мэт цэмцгэр гудамжтай харьцуулахад улаан шороо хийсгэн, зөрөн өнгөрөх автобус машинууд гэж хөөтэй төлөг шиг халтайгаад гуравдугаар сарын Улаанбаатар зүдэнгэ дорой хөгшин мэт харагдана. Гэхдээ элгэн нутаг гэж цаанаа л сэтгэлд дулаахан.

-За.

-Даргаа, нөгөө сурвалжлагч чинь дахиад ярьсан. Таны тухай 97 оны үед авсан нэг

алтны уурхайн тухай баримт сонинд ирсэн. Одоо сонин нь хэвлэгдэх гээд байна гэнээ.

-Scheisse! Өөрийн эрхгүй германаар хараачихлаа.Германд хэдхэн хонохдоо нэг л мэдэхэд залууд нь мартагдсан энэ хараалын үг аманд нь орчихоод байх болжээ. Тэр залуудаа Германд ганц жил мэргэжил дээшлүүлэх курст сурахдаа хэлийг нь гайхалтай хурдан сурч билээ. Цаашлаад зэрэг хамгаалж ч болох байсан ч ээжийнх нь бие муудаад нутагтаа буцаж ирсэн. Хэрэв тэгэхэд Германаас буцаад ирээгүй сэн бол нефть химийн доктор болчихсон тэр чигтээ гадаадад ажиллаж байхсан. Амьдрал нь ч тэс өөр зам даган одох байж дээ. Ээж гэснээс өнөөдөр ингээд эхнэртэйгээ муудалцчихаад гал голомт нь зэвийгээд хариас нутагтаа хөл тавингуут аяга халуун шөл ч оочилгүй ажил руугаа нажидаа эдлэн явахдаа ээжийгээ өгүүлшгүй ихээр үгүйлж зүрх шимшрэн санаа алдаад тайвшрав. Эргээд очиход ээж сайхан, эргүүлж мөлжихөд хүзүү сайхан гэж... ямархан үнэн үг вэ? Аав нь ч бий л дээ. Ээжээс нь хойш эр хүний аминч зангаар өөрийгөө тойлуулах гээд отгон охиноо бараадаж хүргэнийдээ очоод хэвтчихсэн хүн. Тэр хоёр хаа нэг утсаар ярьцгаахаас биш нарийн ширийнээ хуваалцана гэж үгүй. Аав нь голдуу дүү охиных нь юм уу, хүргэнийхээ ажил хэргийг амжуулах гэж юм гуйж л залгадагт битүүхэн эгдүүцнэ. Гэхдээ аавыгаа буруутгах аргагүй гэдгийг ч ойлгоод байдаг юм. Өөрөө ч өтлөөд ирэхээрээ аав шигээ ганц охиноо л бараадна гэж бодож явдаг болохоор тэр. Хоёр жилийн өмнө охиноо Англи руу сургуульд явуулчихаад их л санаж үгүйлж нэг хэсэгтээ хэцүү байж билээ. Хүү нь бол өөрийг нь нэг их тоодоггүй, ээждээ л илүү элгэмсүү, өөрөө ч хүүгээ охиноосоо арай л дутуу хайрлаад байх шиг санагддаг ч төрсөн хоёр үрээ алагчлан ялгадгаа больж нэг л үл чадна. Ингээд бодоход аав нь ч охиндоо илүү амиа тавьж, хүргэнтэйгээ өөрөөс нь илүү ойр дотно байдаг нь арга ч үгүй юм биз.

Ингэхэд тэр арваад жилийн өмнөх өнгөрсөн зууны явдлыг хэн ухаад гаргаад ирдэг байнаа. Түүнийг сайдын суудалд санаатай байгааг зарим нэг нь гадарлачихсан байх нь. Хаанаас шидсэн чулуу байх вэ?

Энэ бол аль эрт арав гаруй жилийн өмнө болоод өнгөрсөн өчүүхэн өмч хувьчлалын хэрэг байлаа. Архангайд нэг жижигхэн алтны ордыг тайлан балансыг нь янзалж байгаад өрийг нь шилжүүлээд авчихсан нь үнэн. Гэтэл энэ чинь өнөөдрийн хэдэн тэрбумын луйвруудын дэргэд заан шоргоолж хоёр л гэсэн үг биш үү?

Сүүлийн үед өөрийг нь нэг л ёозгүй энерги хүрээлээд байх шиг. Тэр шөнийн клубт суугааг хэн эхнэрт нь дуулгаж гэр бүлд гарсан ан цавыг нь улам даамжруулав? Арав гаруй жилийн өмнөх тоос шороо, он цагийн уртад дарагдан мартагдсан баймаар өмч хувьчлалын хэргийг сөхөн гаргав?

Ийнхүү бодолд дарагдан явтал тэрэг нь яамны намхан төмөр хашаагаар орж явлаа. Том жижиг машинаар хахаастай байдаг талбай эл хульхан байв. Дэндүү эрт ирчихжээ.

-Даргаа, Тэнгисийг өдөр сургуулиас нь авах уу?

-Тэг, тэг. Одоо миний чемоданыг гэрт аваачаад тавьчих.

Түүнийг яамны хаалгаар ороход дөнгөж есөн цаг болж байлаа.

Жижүүртэй мэндлээд шатаар өгсч явтал утас нь дахиад л дуугарав. Хадам ээж нь залгаж байна. Охин хүргэн хоёроо эв муутай байгааг мэдэхийн цаагуур мэдээд салж сарничих вий гэж санаа зовон аргаа барж суугаа хөгшин. Өөрт нь сайндаа ч тэгж байгаа юм биш, дөч шүргэж яваа, зоргоор, өөрийнхөөрөө зүтгэдэг, амьдрал мэддэггүй адайр охиноо нөхөргүй үлдчих вий гэж сэтгэл зовоод байж сууж чадахгүй, сууж ч гэж хэвтэж төвдөхгүй залгаж байгаа нь энэ. Гэтэл утсаа авахын нь завдалгүй танихгүй утаснаас нэгэн мессэж ирэх нь тэр. “Сайн байна уу? Би Нараа байна. “White lotus“ клубийг санаж байна уу?” гэжээ.

Юу билээ, өнөөх баарны тайчдаг хүүхэн. Чимгээг орж ирэхэд өвөр дээр нь суугаад зангиагаар нь оролдож байсан... Түүнийг Нараа гэдэг юм байх даа. За тэр хүүхний мессэж ч яамай, ямар ч гэсэн хадамтай ярьдаг хэрэг. Хадам ээж гэдэг бол өөрийнх нь ээж биш ч гэсэн гэр бүлийнх нь амьдралын нэг хэсэг гэсэн үг.

-Байнаа.

-Миний хүү сайн явж ирэв үү?

-Сайн явж ирлээ. Таны бие яаж байна?

-Ээж нь хэвэндээ. Цаад Чимгээ чинь гэртээ алга уу, хүү минь? Нэгийгээ хол яваад ирж байхад...

-Нүхтэд семинартай гэж Тэнгис мессэж бичсэн байна. Ажилтай бол яахав дээ.

-Харин тийм, хаана ч гэнэ үү, хуралтай юм яриад байсан. Чөлөө авчихгүй дээ.

-За яахав дээ. Ажлаа хийлгүй дээ. Танд тариагий чинь авчирсан шүү.

-Яах нь вэ дээ. Баярлалаа хүү минь. Түрүүчийн өгсөн нь дуусаагүй байхад. Баярлалаа, гээд л аваад байдаг. Ээж нь цаадахыг чинь өнөөдөр тэр семинараа хаяад харь гэж хэлье.

-...

Хоёр талаас бие биенээ цэнэж, жинхэнэ хаяагаа манасан яриа болж арай гэж дууслаа. Хадам ээж нь гэж хатуудаа хатуу, зөөлөндөө зөөлөн, амьдралын хар ухаанаар яггүй хүн. Цагтаа их дэлгүүрийн бэлэн хувцасны нярав Пагмаа гэж ганган дэгжин, даналзсан, сүрдмээр авгай байж билээ. Бодвол Чимгээд хэдэн хатуу үг хэлж, оронгоо битгий тараачих гэж хэлсэн л байгаа. Гэтэл Цасчимэг? Зарим үед нэр шигээ хүйтэн зан гаргачихдаг, хэзээ ч хүний нөлөөнд ордоггүй, ховорхон тохиолдох чанга бүсгүй дээ. Тэр шатаар хөмсөг зангидан өгсч явлаа. Хөлийнх нь өвдгөөр янгианан цахилгаан шатаар явсаар муу зан сурсан хөл нь эсэргүүцэл үзүүлж, нөгөө талаас нас чинь дөч гарч байна шүү гэдгийг сануулах шиг. “Цаг хугацаа гэдэг жинхэнэ өршөөлгүй алуурчин юм“ гэсэн үг хэзээ ч билээ уншсанаа санаад мөрөө хавчин санаа алдаад өөрийнхөө өрөөний үүдэн дээр зогтуслаа. Хол яваад ирэхээрээ гэрийнхээ юм уу, ажлын өрөөнийнхөө үүдэнд ингэж хэсэгхэн зуур зогтусдаг зантай...

“Нийгмийн шилжилтийн үеийн хотын оршин суугчдын сэтгэл зүй дэх өөрчлөлт“

сонирхолтой сэдэв болохоор илтгэл нь ч сайн болжээ. Цасчимэг илтгэлээ тавьж дуусаад цагаа харвал 11 өнгөрч богинохон хэлэлцүүлгийн дараа хүмүүс асуулт тавих шинжтэй байсан ч бараг зугтах шахам гарч 00-ийн өрөө зүглэлээ. Сэтгэлээ амсхийлгэх хэрэгтэй байлаа. Залуудаа илтгэл тавихын урьд орой сэтгэл хөдлөөд л, амжилттай болсных нь дараа нэг л өөртөө итгэлтэй, урам зориг дүүрэн, нэг их том ажлын ард гарсан юм шиг сайхан байдаг сан. Нөхөр нь ихэвчлэн ажлаасаа чөлөө аваад эрдэм шинжилгээний хуралд нь заавал очиж түүний илтгэлийг сонсдог. Орой нь хариад алдаа оноогий нь шүүн хэлэлцэж байхдаа хоёулаа үнэхээр үгээр хэлшгүй жаргалтай байдаг байж дээ. Одоо тэр бүх аз жаргал эгнэгт эргэн ирэхээргүй алсран оджээ. Чинбат гэж “төрийн том хүн” эхнэрийнхээ илтгэлийг сонсох битгий хэл гэртээ гэгээн дүрээрээ нар жаргаагүй байхад морилж гийгүүлэх нь хүртэл нүдний гэм болоод удаж байдаг. Түүнд өөрийнх нь ажил, өөрийнх нь ертөнц, өөрөөр хэлбэл хамт хор найруулдаг амьтад нь л чухал. Тэр хоёр зүрх сэтгэлээрээ аажим аажмаар хөндийрөн холдсоор л байгаа нь хамгийн том эмгэнэл байлаа. Урьд нь эхнэрийнхээ эрдэм судалгааны ажлыг үргэлж үнэлэн, бусдын эхнэрүүдээс тэс өөр, эрдэм номын мөр хөөсөн ухаалаг Чимгээгээрээ бахархдаг байсан бол одоо “зөрүүд, гөжүүд, амьдралаас тасарсан амьтан” хэмээн адалж, айлын авгай нар шиг, ер нь стандарт эхнэр шиг байдаггүйд нь харин ч харамсах болсон шүү дээ. Айлын авгай нар шиг нөхрөө юу ч хийж байсан нүдэн балай чихэн дүлий, өгсөн мөнгөөр нь гоёчихоод л хааяа нэг гадаад явж дэлгүүр хэсээд л, залуу хүүхэнтэй гэдгий нь мэдсэн ч мэдээгүй юм шиг, уран шувуу үүрээ гооддог шиг элдэв тавилга буйдан эргүүлдэн, гэр ахуйн барааны тасгаар эргэлдэж, тураах зөвлөгөө уншиж, харвингаа хэмжсэн шиг л байх юм бол стандарт эхнэр гэсэн үг. Үгүй ээ, тэр л лав тийм өрөвдмөөр дүрд тоглож чадахгүй. Үгүй шүү. Нөмөрсөн арьсаа сольж төрөл арилжиж болдоггүйтэй л адилхан толгойтойгоо, доторхи бодолтойгоо л үлдэх минь.

Нөхөр нь аль хэдийн онгоцноос буугаад гэртээ харьчихаад эхнэрээ байхгүйг мэдээд бөөн цухал байгаа биз гэж бодоод утасдах юм уу гэснээ болив. Хамгийн сүүлд тар тур хийхэд уурандаа түүний араас үнсний сав шидсэнийг нь бодохоос дургүй нь хүрсээр л байлаа. Чинбат хичнээн ч хилэгнэсэн тэгтлээ хяналтаа алдаж байгаагүй, эхнэрийнхээ хойноос гартаа тааралдсаныг чулуудах нь байтугай эмэгтэй хүний өөдөөс эвгүй үг ч хэлэхээргүй төлөвшсөн хүн шүү дээ. Тэгтэл тэр нэг нууц цэнгээний газар юм уу, хайшаа юм, заваан газарт нүцгэн хүүхэн өвөр дээрээ суулгачихсан байж байгаагүй юм шиг, гэм зэмгүй амьтан шиг уурлаж гартаа тааралдсаныг чулуудсанаараа сэтгэл рүү нь мөс шидлэх шиг л болсон. Хүн нас ахих тусам намба суудаг юм бол Чинбат ингэж эвдэрч хүнээ байдаг нь юуных вэ? Олигтой төлөвшөөгүй байсан болоод л албан тушаалын хэнээ тусч амьдралынхаа үнэт зүйлсийг уландаа гишгэж байна бус уу?

“Чи жаахан бодолтойхон байхад яадаг юм. Хааяагүй л нөхөргүй хүүхэн шиг олон юм алга. Манай Чинбат шиг ажил албатай, нэр хүндтэй, мэдлэг боловсролтой, эхнэр хүүхдээ хүн шиг аваад явчихдаг, яагаа ч үгүй дөнгөж дөч хүрч яваа сайхан эр тийм ч зам дээр хэвтэж байдаг эд биш шүү, хүү минь! Ах чинь чамд олигтойхон түшиг болж чадахгүй, амиа тээж яваа л амьтан. Хүргэн өдий зэрэгтэй байгаагүй бол миний эмчилгээний төлбөр ч юу болоо билээ. Хүүхдүүд чинь том болчихлоо. Орон гэрээ тараачихвал багшийн хэдэн цаасаар яаж амьдрах хүн бэ чи? Нөхрийнхөө аар саархан явдлыг тэвчиж байхад яадаг юм. Дөч гарч яваа хүүхэн амьдралын ухаан суумаар юм.

Тэр нэг хэрүүлийн маргааш ээжийндээ очиход нь хангинадгаараа хангинасан. Чинбат тэр хоёр зүгээр нэг ам мурийхаар барахгүй муудалцаж, хооронд нь гараад буй ангал улам өргөссөөр байгааг яаж ч мэдсэн юм. Баахан үглэсэн. Нөхрийг нь залууд “Нэг муу багш, ном шагайсан амьтан” гээд тоодоггүй байснаа мэдэхгүй одоо л хүнээ байсан хойно нь учиргүй магтах болж гэнэ. Хэрэв Чинбатаас салчихвал өөрөө эмчилгээний төлбөргүй үлдчих юм биш байгаа гэж айсан юм байх даа хэмээн уур нь хүрч байсан ч хүний эх л юм хойно өөрт нь санаа зовсон нь дийлэнх гэдгийг ч ойлгож байлаа. Их дэлгүүрийн барааны нярав хийж араас нь хотын аль ганган дэгжин хүүхнүүд гадаадын хувцас хунар захих гэж хошууран гүйлдсэн ёстой цалгиж халгиж явсан дүүхэлзсэн авгай байсан даа, ээж нь. Хамгийн анх Чинбат түүнийг даган ирээдүйн хадмындаа очоод ядам хуруундаа алмаз гялалзуулан саатай гэрийн шаахай өмссөн, нэвт шувт ширтсэн хянуур харцтай авгай үүдэн дээрээ угтахдаа шуудхан гутал руу нь харахыг мэдээд нуруугаар нь хөлс дааварлан “За аймаар хадмын гарт орлоо доо” хэмээн зүрх алдсанаа ярьдаг сан. Аз болоход Чинбат гутлаа гялалзтал тосолж, өмдөө ир гартал нь индүүдсэн явсан нь эхний “ко ко” үнэлгээ авчирч билээ. Харин аав нь бодь хүн байсан болохоор хүргэндээ хүү шигээ л ханддаг байсан билээ. Хэдийгээр ээж нь хүргэнээ “Ном шагайсан нэг муу багш” хэмээн голонгуй байдаг ч тэдний амьдралыг хөл дээрээ бостол нь чадах бүхнээрээ тусалж, миний охиныг муухай ч хардаггүй, номонд гэгээрсэн боловсролтой хүү дээ гэж найз нартаа гайхуулах дуртай байсан билээ. Амьдралд хандах өөрийн гэсэн философитой яггүй хар ухаантай ээж нь охиноо хараад л ганц харцаар нь бараг л тэднийд юу болсныг гадарлачихаад байдаг нь хэцүү. Өвгөнөө алдаж бэлэвсрээд удалгүй элэгний хүнд өвчинд баригдан эмнэлэг эргүүлэн гэртээ хэвтрийн голдуу байх болсноор улам ч гярхай, зөнч болчихсон юм болов уу гэж Цасчимэг ээжийгээ өрөвдөх ч өдий дөч гарч яваа хүний амьдралд оролцон зааж зааварлах гээд байхаар нь уцаар төрнө. “Чинбат шиг эр тийм ч элбэг олдоод байдаггүй “эд” гэнэ шүү. Их дэлгүүрийн барааны нярав явсны үлдэгдэл нь яаж арилахав, ховор эд бараа гэсээр байгаад одоо хүргэнээ хүртэл ховор “эд” гэж ярьж байх шив. Ээж минь дээ, ээж минь”. Цасчимэг 00-ийн өрөөнд орж ус шоржигнуулан гоожуулж гараа угаан, нүүрээ чийглээд толь руу хяламхийв. Богинохон тайруулсан үс, цайвар царай, ядрангуй харцтай дөч гарч яваа хүүхэн. Зовхиных нь үл мэдэгхэн үрчлээ харьж яваа насыг нь сануулна. Удахгүй хүмүүс намайг адайр зантай багш авгай гэгцгээх биз дээ хэмээн ёжтойхон бодоод уруулын будгаа сэргээж зогстол гар утас нь дуугарлаа. Ээж нь байв. “Нөхөр чинь ирчихсэн аяганы амсар зуулгүй л ажил руугаа очих шиг боллоо. Хорин жил ханилсан нөхөртөө ингэж хатуурхаад юу олж долоох гэв” гэж нэг ширүүлснээ “За, за. Ээж нь ажлыг нь хийлгэхгүй түвэг болоод. Цаадхи чинь надад тариа хүртэл аваад л ирсэн байна. Сэтгэлий нь бодмоор юм даа. Чи ч гэсэн биеэ, амьдралаа бодмоор юм даа, ээж нь бол яахав өвчинд ээрэгдсэн хөгшин. Чаддаг юм нь л үглэх” гэсхийгээд санаа алдан утсаа тавьчихав. Тэр толинд удаан харж зогсох дургүй зантай.

Хүү нь байгаагүй сэн бол өнөө орой гэртээ харимааргүй санагдана. Семинар болж буй танхим руу шууд яваад орохоос түдгэлзэн хонгилын цонхон дээр очин хэсэг зогсов. Богд уулын нүцгэн модод, цас нь хайлж цоохортсон газар, үе үе хуйсганах ааштай салхины аясаар шороо хийсэх хаврын нүцгэн саарал байгаль уй төрүүлнэ. Гэхдээ л хавар ирж, айсуу урин цагийн баясгалант өнгийг байгаль өөрөө зөгнөөд байх шиг. Гэтэл байгаль ертөнцтэй харьцуулшгүй богинохон настай хүний амьдралд хавар эргээд ирэхгүй нь гунигтай юм даа. Тэртээд хоцорсон хавар шиг яруухан залуу нас, халуун хайр нь эргэн ирэх биш. Чинбат түүнд ямар халуун хайртай байлаа. Тэр их хайрыг нь эргүүлэн авчирч болдог сон бол... Өөртэй нь

хэрэлдэж муудсан ч ээжийнх нь тариаг аваад ирснийг нь бодохоор түүнийг гэсэн сэтгэл нь бүрмөсөн хөрч алга болоогүй юм болов уу гэсэн найдлагын оч сэтгэлд нь гялсхийлээ...

Эрчүүдийн хувьд хайр дурлал гэдэг нь энэ ертөнцөд түүнийг зугаацуулж байдаг олон цэнгэлийн нэг нь, харин эмэгтэй хүнд амьдралынх нь цорын ганц утга учир нь байдаг гэж нэгэн эмэгтэй зохиолчийн бичсэнийг санаад тэр гунигтай инээвхийлэв. Хайр сэтгэлээр тэжээгдэн амьдардаг залуу бүсгүй ч биш, ерөөс ганц эр хүний тухай элдэв бодлоор толгойгоо дүүргэсэн жир нэгэн эмэгтэй баймааргүй байдаг. Гэхдээ л хүн арьснаасаа мултарч болдоггүйтэй л адилхан. Чинбатаас урьдын тэр халуун хайрыг нь л хүсээд байгаа юм биш үү? Ажил, мэргэжил, сонирхол, унших дуртай номууд, найз нөхөд, өнөөдрийн тавьсан илтгэл, охин, хүү хоёр, ээж нь тэгээд түүний ертөнцөд хаахнуур байр эзэлдэг хэрэг вэ? Хэдэн хоногийн өмнө тэртэй тэргүй мухардалд ороод байсан харилцаагаа нэгмөсөн хүйтрүүлэхэд хүргэсэн тэр алхмыг хийсэндээ сэтгэлдээ харамссаар л байлаа. “White lotus“ бааранд хайрт нөхөр чинь зугаалж яваа шүү!“ гэсэн мессеж хэд хэдэн удаа ирэхэд нь тийшээ очих шийд тархиныхаа хаанаас гарсныг бодоод бодоод олдоггүй юм. Сүүлийн жилүүдийн ганцаардал, нөхрийнх нь улам бүр хөрч хүйтэрсээр байгаа харилцаа, гэр бүл, ойр дотныхон, эхнэр, хүүхдээсээ илүү албан тушаалын шатаар дээшлэх, гагцхүү дээшлэхийн төлөөх улайрсан тэмцлээсээ өөр юу ч үл сонирхохоо больсон нөхөртөө гомдсон гомдол нь ийм ухаангүй алхам хийхэд хүргэсэн биш үү? Бие даасан хувь хүнийг мөрдөж мөшгих нь утгагүй, мунхаг явдал гэдгийг Чинбат тэр хоёр анх учирснаасаа хойшхи 20 жилийн турш хүлээн зөвшөөрч, бие биедээ итгэдэгтээ бахархдаг байгаагүй гэж үү?

Айлын эхнэрүүд нөхрөө өсгий даран мөрдөж, хаа явсан газар руу утасдаж, гар утсыг нь шалган, ажил төрлийнхөн, найз нөхдийнх нь өмнө нүүр хийх газаргүй болгодгийг тэр шоолдог байсан. Нэг л өдөр сэтгэл буруулчихлаа гэхэд эр хүнийг мөрдөж, мөшгөөд улам цааш нь түлхэхээс биш буцаагаад хажуудаа аргамжчихаж болохгүйгээс хойш гэж тэр боддог байж билээ. Гэтэл одоо өнөө ухаантай бүсгүй чинь өөрөө дөч гарсан хойноо дэндүү оройтсон хойно хартай эхнэрийн өрөвдмөөр дүрд тоглочихдог. Хүн насжих тусам ухаан суухын оронд эргээд мунхардаг байх нь. Үүнийг ганц нөхөр нь ч биш өөрөө биеэрээ баталжээ. Тэр нэгэн үдэш нууц цэнгээний газар руу нөхрөө мөшгиж очоогүй бол сэтгэл нь одоогоос илүү амар амгалан байх байсан гэж үү? Чинбат бахь байдгаараа үдэш унтсан хойно нь ирээд, өглөө босоод аяга кофе хам хум уучихаад ёс төдий уруулд нь хошуу хүргэгчид л “Маргааш Герман явлаа. Чи юу захих вэ?“ гэж асуух байсан. Хэрүүлгүй л болохоос улиг домог болсон утгагүй харилцаанд цөхөрсөн сэтгэл нь нэг л өдөр гомдол, бухимдлаа зад тавих л байсан шүү дээ. Тэр санаа алдав. Чинбат тэр тайчигч бүсгүйн гөлгөр арьстай чанга, чийрэг биеийг ямар тааламжтай тэвэрч суусныг санаад толгойгоо ганхуулан хөмхий зуулаа. Орой хариад тэр гараараа эхнэрээ, өөрийг нь тэврэх байсан! Тэгээд энэ бүхнийгээ эхнэр хүүхдийнхээ төлөө, гэр бүлийнхээ төлөө хийж байгаа ажил гэж тайлбарлана. Гэр бүлийнхээ ариун нандин бүхнийг уландаа гишгэж, хамтдаа бүтээсэн амьдралаа дээсэн дөрөөн дээр дэнжигнүүлж байж гэр бүлийнхээ төлөө ажилладаг юм гэж үү?

Хүүхдүүд том болж, дутагдах гачигдах юмгүй амьдрал тэгшрээд ирэх энэ л үеийг залуу явахдаа ямар их хүлээж хамтдаа аялж, зугаалж, эрдмийн ажлуудаа ном болгон хэвлүүлж, хоёр биенээ гэсэн халамж хайр улам нэмэгдэнэ гээд л хичнээн ч сайхнаар төсөөлдөг байлаа. Одоо тэр бүх гэгээн мөрөөдөл нь Чинбатын хувьд инээдтэй санагдана биз.

-Цасчимэг багш аа, цайны завсарлага болчихож. Кофе уухгүй юм уу? гэх дуугаар хүнд бодлоосоо салж эрдэм шинжилгээний хурал, ажил төрлийн ертөнцдөө эргэн ирлээ.

Нэг тэнхимд хамт багшилдаг, хуучин шавь нарынх нь нэг Хүрлээ хэмээх багш залуу түүнийг дуудаж байлаа. Дөнгөж гэрлээд удаагүй, завсарлага бүрээр гэргийдээ мессеж бичээд л, одоогоор оюутны байранд толгой хавчуулж яваа ч аз жаргалаар бялхаж яваа яг л хориод жилийн өмнөх Чинбат гэсэн үг! Тийм ээ, Хүрлээ, Заяа хоёрыг харах бүрд өөрсдийнх нь залуу нас санагддаг юм. Сайхан залуус. Гэхдээ тэд өөр шиг нь дөчин насан дээрээ ямар байх бол? Бурхан л мэдэх байх даа.

Өөрийгөө хувирашгүй атеист. Мухар сүсэг боловсролгүй эмэгтэйчүүдэд л хамаатай гэж боддог байснаа жил ирэх тутам амьдралын утга учир, ертөнц гэдэг адармаатай эдийн аашийг олохгүй цөхрөхдөө бурхны тухай бодох болжээ...

Чинбат үдийн цайны цаг дундаа орсон хойно л ядарснаа мэдэрлээ. Өглөө ажлын өрөөнийхөө хаалган дээр түр зогтусан зогсч байснаас хойш чилийсэн таван цаг өнгөрч их ч ажил амжуулжээ.

-Даргаа, эмнэлэг рүү явах уу? гэж дэд сайд асууж байна.

-За.

Үдийн хоолоо идэж амжаагүйгээ гэдэс нь хоржигноход л санав.

Цуваа өмсөөд гарахдаа туслахын өрөөнд хувцасны өлгүүрийн дэргэд байх толинд зэрвэс хяламхийн юм л бол босчихоод байдаг эргүүлэгнийхээ хэдэн үсийг самнаад:

-Сайдын зөвлөлийн хурал 30 минут хоцорч эхэлнэ гээд зарлачихаарай. Тэгээд чи хурдан цайндаа орчихоод ир хэмээн санаа тавиад гарлаа. Туслах Цогтбаярын хувьд эхнэртэйгээ муудалцсан, охин нь хол байгаа энэ үед үнэн хэрэгтээ өөрийнх нь хамгийн дотнын хүн болчихоод байгааг ухаарсан хэрэг.

Дэд сайдтай гудамд тааралдан гар барилцан сүүлийн үеийн мэдээлэл солилцсоор шатаар уруудлаа. Инээж хөхрөн өнгөрсөн жил Голландад хамт явахдаа зөөлрүүлсэн хар тамхи татаад яаж хөглөснөө ярилцан, дэд сайд түүнийг Германд хэд хонохдоо гэдсээ татчихаад ирсэн байна гэхчлэн эрчүүдийн дунд болдог наргианы үг хэлэлцэн уулзахдаа хэн хэн нь удахгүй сулрах нь тодорхой болчихоод буй сайдын суудлын төлөө өрсөлдөгч биш, дээлнийхээ сугыг ханзартал барилдаж өссөн нэг жалгын хүүхдүүд шиг л ойр дотно харагдаж байв. Үдийн цайны цаг дундаа орсон энэ үеэр цаас барин нааш цааш хөлхөлдсөн хүмүүсээр дүүрэн байдаг яамны бүх давхрууд хоосрон эл хуль болжээ.

Чинбат машиндаа суугаад хөдлөхдөө эхнэр рүүгээ залгах гэснээ болив. Эцсийн эцэст өөрөө хэдийгээр буруутай ч, хойноос нь мөрдөж, мөшгиж хэрүүл өдөн, өчнөөн хоногоор сунжирсан муудалцаанд хүргэсэн эхнэртээ бууж өгч болохгүй гэсэн зөрүүд бодол орж ирлээ. Залуудаа эхнэртээ мөн ч их бууж өгдөг байж. Хайр сэтгэл нь ид халуун байсны гадна, яггүй зөрүүд, байр суурин дээрээ баттай зогсдог, эцийн эцэст голдуу эхнэрийнх нь зөв болж

таардаг тул Цасчимэг түүнийг буулгаж авч байж л санаа нь амардаг асан. Одоо бүх юм өөрчлөгджээ.

Хүүгээс нь мессеж ирэхэд л нөгөө баарны нүцгэлдэг хүүхний тухай сая саналаа. Тэр хүүхэн яагаад мессеж бичин мааслаад байгаа хэрэг вэ? Түүнийг тэр хаалттай бааранд байх мөчид эхнэрт нь дуулгаж, тэр нүцгэн хүүхэн өвөр дээр нь сууж байхад Чимгээ орж ирж таардаг. Яах аргагүй зохион байгуулалттай хэрэг байж таарна. Бас тэр алтны компанийн хувьчлалын тухай бичиг цаас яахаараа сониныхны гарт орчихдог байна. Хөмсөг атируулан бодолд орлоо. Орой Пандагатай уулздаг хэрэг. Тэр нь цагдаад багагүй өндөр алба хашиж явсан найз нь билээ. Машин яамны хашааны намхан төмөр хаалгаар гарч явах үед зэргэлдээх орон сууцны хог ухаж зогсоо хүүхдээ дагуулсан халтар хар хүнийг хараад эвгүйцэн харц буруулав. Тэгтэл тэр хогчны авгай нь бололтой залуухан хүүхэн ундааны хуванцар сав дүүртэл нь чихсэн шуудайгаа газар тавиад тосон гүйж ирэх хоёр ойтой болов уу гэмээр хүүд халааснаасаа чихэр гарган өгч инээмсэглэнэ. Эмэгтэй хүн гэхээргүй даг дайр болсон нүүр, гар, ширэлдсэн үс ... Тэр хогчиндоо бол хөөрхөн л харагддаг байх даа гэж өөрийн эрхгүй бодоод хүйтнээр инээмсэглэн эгц урагшаа харж суудлаа засан тэр тухай бодохгүйг хичээлээ. Хүмүүс ингэж л амьдарч байна. Өөрөө ч бодит амьдралаас хичнээн их холдон тасарч яваагаа ийм л үед ойлгон, Чимгээгийн хэлдэг хорон үгс бодогдоход “Би тэгээд хүн хэвээрээ үлдэж байгаа нь энэ гээд төсвийн хэдхэн төгрөг харсан ядарсан амьтан байх байсан юм уу? Багшийн цалингаар амьдарна гэвэл эднээс дээрдэх юмгүй л байх байсныг Чимгээ яагаад ойлгодоггүй юм? Би Чимгээгийн хэлснээр хүн шиг хүн байхын тулд өдийд дээд сургуулийн багш хэвээрээ байсан бол ээжийнх нь өндөр үнэтэй тариа, эмчилгээний үнийг яах байсан юм, голоос хайртай охин Халиуныгаа гадаадад сургаж чадах байсан юм уу? Чимгээ ингээд бодох санах юмгүй эмэгтэй хүнд тохирсон хөөрхөн машин унаад Нүхт мүхтэд хуралд суугаад тансаглаад явах байсан гэж үү? Юм болгон тохирсон үнэ хөлстэй, тодорхой золиос шаарддаг юм. Живж буй хүн гартаа таарсныг л шүүрдэг шиг хүний хамгийн өөдгүй чанаруудын нэг болсон ямар ч үед өөрийгөө өмөөрөх сэтгэл нь ийнхүү омогшин дүрэлзэнэ. Утас нь дуугарав. Дүүргийн намынх нь дарга залгажээ. Хүмүүсийнхээ цалинг тавих гэтэл мөнгө дутаж байна туслаач, энээ тэрээ гэж байна. Яаж ийж байгаад аргалаад хэдэн төгрөг өгөх л хэрэгтэй болох нь. Дүүргийнхээ намд сүүлийн улирлын татвараас хойш хандив энэ тэр өгөөгүй юм чинь.

Тэднийг эмнэлэг дээр ирж, сэхээн амьдруулах тасаг руу ороход үдийн цайны цаг хэдийн өнгөрсөн байлаа. Энд хөл тавихад л үхлийн үнэр мэдрэгдэх шиг, амьдрал мөнх биш шүү гэж нүдэнд үл үзэгдэх нэгэн дуу хоолой шивнэх шиг болж бие ширвээдэн саяхан л яамныхаа хонгилд тааралдан дуу шуу болцгоож, бие биенийхээ гэдэс гүзээ татарч, томорч байгааг тэмтрэн тоглоом шоглоом болж байсан дэд сайд ч төв царайлан намуухан дуугарна. Эмнэлгийн цав цагаан хонгилд эм тарианы үнэр ханхийн, лагшин чилээрхсэн сайдын ээж цагаан нөмрөгөө тайлан бэрдээ өгөөд мэндийнх нь хариуд толгой дохиод гарч явна. Өөр ганц нэг өвчтөний гэр бүлийн хэдэн хүн хэсэг хэсгээрээ тойрон зогсоод тэрүүхэн тэндээ аяархан ярилцаж зогсоо харагдана. Энд, тусгай эмнэлгийн сэхээн амьдруулах тасагт үхэл, амьдралын зааг дээр л байдаг, гадаах дуу шуугиант ертөнцөөс тэс өөр дүр зураг, орчин ахуй ноёлж байлаа.

Сайдын гэргий үсээ хайш яйш боож, нүд сэлхийсэн бүсгүй тэр хоёрыг хэзээ хойно олж хараад аяархан мэндлэв.

-Сайдын бие яаж байна? Ухаан оров уу? гэж дэд сайдыг асуухад:

-Янзандаа л байна. Ухаан ордоггүй ээ. Урд шөнө зүрх нь зогсчих гээд сандаргаад...

Тэр хоёр шилэн хаалтны цаанаас өвчтөнийг харж зогслоо. Хиймэл амьсгалын аппарат залгаастай сайдын нүүр нь гантигаар сийлсэн мэт хөдөлгөөнгүй, хагас аниатай нүднийх нь сормуус үе үе чичирхийлэн амьсгаатай байгааг нь илтгэх ажээ. Наанаа өвчтөнийг өрөвдсөн царай гарган, гэргийтэй нь аяархан ярьж, эргэж тойрч буй хүмүүсийн дүр эсгэж байгаа ч хоёулаа л удахгүй эзгүйрэх суудалд нь санаархан, амьсгаа хураахыг нь сэмхэн хүлээж байгаагаа бодоход хэн хэнд нь ичгэвтэр байлаа. Тэр хоёрыг гарч явахад зүс таних нэгэн сэтгүүлч хонгилд тааралдан бие муу байгаа сайдыг Японд хагалгаа хийлгэхээр нисэх гэж буй нь үнэн эсэхийг лавлаад сувилагчид хөөгдөв...

Наран үд болтол унтаад сэрлээ. Ээж дүү хоёр нь аль хэдийн гараад явцгаажээ. Өчигдрийн уусан архи толгойд нь гарч ам нь хатан дотор муухайрна. Урт өтгөн гээг үс нь хүзүү халууцуулан цонхоор нар шарж байгааг мэдрэн хэсэг нозоорон хэвлээ. “Өнөөдөр чинь дөнгөж гурав дахь өдөр. Ажиллахгүй. Тэгээд юу хийх билээ?” Сараагийн курсын ажлыг шивж өгдөг юм бил үү? гэж нэг сайхан зан гаргах гэснээ өчигдөр согтуу ирсэнд нь уурлаад байгаа ч юм шиг шилбэлзээд байсныг нь санаад дургүй нь хүрчихлээ. Сараа гэж Анагаахад сурдаг дүү нь. Нарангийн хувьд хоёр жилийн өмнө Их сургуулийн улстөр судлаачийн ангийг хаясан хүн. Ээж нь гэж багшийн сургуульд туслах багш хийдэг хүн хүний аясыг дагасан ноомой авгай. Хааяа ганц нэг оюутан, мэдэхгүй хүмүүс өөрийг нь “Цэндмаа багш аа” гэчихвэл баярласандаа хайлаад л бүтэн дипломын ажлыг нь ч үнэ хөлсгүй шивээд өгч мэдэх уулгар, гэнэн ч юм шиг, ноомой томоотой ч юм шиг, нэг үгээр хэлбэл тэнэгдүү хүн. Ямар юмных нь багш байхав дээ. Урьд нь лаборант гэгдсэн, тэнхимийнхээ хамаг л нэртэй нэргүй ажилд зарагдаж гүйсэн өрөвдмөөр амьтан байсан. Одоо бол багшийн туслах, заримдаа туслах багш нэртэй. Эрдэм номд сохроор шүтсэн, амьдралын ухаан, арчаа муутай, сэтгэл цайлган л хүн. Эцэг нь хаяад явсан хоёр охиноо ганцаар өсгөхдөө хэний зохиол, юунд хэрэгтэй, хэзээ уншихад тустайг үл ялган “ном унш, номтой хүн бол” гэсэн ганц үгийг л амны уншлага болгон хүмүүжүүлжээ. Амьдралд хэрэгтэй ажил төрөлд сургахын оронд ном, ном гэсээр дүүгий нь ч, өөрий нь ч амиа авч явах чадваргүй, арчаагүй, ядаж л хэрэгтэй мэргэжил ч сонгуулсан юмгүй чигээр нь яг л их далайд төөрсөн ганц завь шиг амьтад болгон тавьсанд Наран ээждээ уур нь хүрч, нөгөө талаар өрөвдөнө. Өөрийнхөө тэнэг байсанд ч бухимдана. Ядахнаа хар багаасаа нийгмийн ухаан энэ тэр сонирхон мунхаглаж явахын оронд математиктаа шамдаад нягтлан болчихсон бол өнөөдөр юу гэж ингэж бааранд нүцэглэж, хөлчүү эрчүүдийн нүд баясган, төрсөн биеэ бараа таваар мэт үзүүлэн болгож явах вэ дээ. Ямар баян айлын бандгар хүүхэд биш. Дундад зууны үеийн хийх юмаа олж ядсан язгууртнуудын үр сад биш. Юу юу ч үгүй бараанк байшингийн ядуу зүдүү авгайн охин байж, гүн ухаан, улс төр судлал гэж сэвсэн байгаа юм даа. Арай 21-р зууны Аристотель болж, цэцэн мэргэний ухаанд “цоорох” гэж бодсон юм биш биз дээ? Эсвэл улстөрийн бохир шавар шалбааг дундаас ёстой нөгөө “Шарилжин дундах цэцэг” гэдэг шиг дэлгэрч, монгол Маргарет Тэтчер болж тодорчих юм бодсон юм болов уу? Очиж очиж тийм мэргэжил сонгохдоо юу бодож байснаа гайхаад бардаггүй юм. Хаа байсан Орбитын тийших хотын баруун захын орхигдож мартагдсан муруй хазгай гудамжин дахь яйжийсан муу байшин руугаа харих автобусны мөнгөгүй, ходоодны мухар руугаа шидчих ганц хуушуур ч авах бэлгүй болж,

дадлага хийхээр нэгэн намын аппаратад хорин хэдхэн хонохдоо улстөрийн ертөнцийн бохир завааны зах зухы нь мэдрээд ирэхдээ л тэр сонгосон мэргэжилдээ эргэлзэж эхэлсэн билээ. Хоёрдугаар курсээ төгслөө. Гэтэл Сараа нь арваа төгсөөд мөн л ээжийнхээ алтан сургаалиар эрдэм номд шамдсаар Анагаахын их сургуулийн өндөр босгыг төвөггүйхэн давчихлаа. Сургуульд орох сайхаан. Төлбөр төлөх л тийм амар ажил биш юм хойно. Амьдралын хатуу ширүүнийг арай илүү ухаарч эхэлснээрээ Наран л сургуулиасаа чөлөө авч дүүгийнхээ сургалтын төлбөрт нэмэр болохоор санаа шулуудсан. Ангийнх нь бийлэгжүү охид үнэг, булган дээл сольж өмсөн, шинэ жилийн гоёлоо бэлдэх гэж Бээжин нисэцгээгээд л байхад хорьхон настай Наран дүүгийнхээ төлөө сургуулиасаа чөлөө аваад юу тааралдсан ажлаа хийхээр сэтгэл шулуудна гэдэг тавин настай ээжээс нь гараагүй л зориг байсан даа. Ном эрдэмд шамдана, их эмч болж, хүний амь нас аварна гэсэн үлгэрийн мөрөөдөл дүүрэн гэнэн хонгорхон дүүгээ л тэр хамгаас илүү өрөвдөж байсныг ээж нь ойлгосон бил үү? “Яанаа, тэр их мөнгийг хэнээсээ зээлдэнээ, хүүхдүүд минь. Олны дэмээр болох л байх даа” гэж худлаа уулга алдаад л сууж байсан. Хэнээсээ зээлдэх билээ гэнэ шүү. Хэдий болтол хүнээс мөнгө зээлдэж, урд хормойгоо хойд хормойгоороо нөхөж олны адагт гэлдрэх гэсэн юм бол? “Би л сургуулиасаа чөлөө авчихъя. Энэ зунжингаа ажиллаад төлбөрийг нь хийчихнэ. Тэгээд Сараа чинь сургуулийн цагаан цамцтайгаа оюутан болохгүй ш дээ. Солих гутал ч үгүй улаан нүцгэн амьтан тэр ганган охидын дунд нүүрээ хайш нь хий юм?” гэхэд ээж нь “болно доо, болно.” гээд булзааруулж суусан. Юу болох юм, яаж болох юм? Аль арван зургаан жилийн өмнө аав нь тэр гурвыг заяа нь мэдэг, би л хар толгойгоо бодох минь, удам судар залгах хүү төрлөө гээд“ тэр гурвыг яг л авахуулсан мухар олгой шигээ хаяад алга болоход ээж нь бас л ингэж хэлээд мэлэрч суусныг Наран бүүр түүр санадаг юм. Сургуулиасаа ч чөлөө авсан. Эхлээд гуанзанд бэлтгэгч, баарны зөөгч, айлын хүүхдийн асрагч, солонгос айлын үйлчлэгч гээд хийгээгүй ажил гэж үгүй шахам. Гэхдээ тэр тоолонгоор нэг хэрэгтэй юм сурч, ухаан сууж, хэрсүүжиж, ёстой л амьдралын их сургуульд суралцсаан. Харамсалтай нь тэр хооронд үерхдэг банди нь хаячихсан. Эргээд их сургуульд орж улстөр судлах хүсэл ч ор тас байхгүй болсон. Лили хэмээх ажилсаг, хатуу шаардлагатай ч сэтгэл зөөлөн эзэн авгай нь гэнэт нутаг буцаж Наран ажилгүй, амьдралд итгэх итгэлгүй амьтан хоцорсон тэр өдөр сэтгэлээс нь үл гарна. Өдөр бүр шинэ юм сурч, гэдэс цатгалан, сардаа 300 доллар авчихдаг тийм ажил мэдээж дахин олдоогүй юм. Ээж нь наян мянгын цалингаа аваад л, дүү нь цагаан нөмрөгтэй сүрхий хүн мөнгө нэхэхээс ямар сохор зоос олохыг ч бодох биш. Өөрийгөө гаргуунд нь хаях л болсон. Түүнд ашиглаж амжаагүй үлдсэн ганц юм байсан нь тэгш сайхан бие байлаа. Тархи толгой, дараа нь гараа ашиглан амьдрах гээд болсонгүй. Тайчдаг хүүхнүүд гайгүй цалинтай байлгүй гээд л сохор мухраар нэг газарт ажилд орсон нь нэг их гавьтай цалин өгдөггүй ч олны өмнө хээв нэг нүцгэлэх, бүжгийн хөдөлгөөнд эвсэлтэй болох гээд багагүй юманд сургаж билээ. Дараа нь “White lotus” гэдэг өндөр зэрэглэлийн цэнгээний газарт орж, ичих эрээлхэх гэдгийг мартаж, бэлхүүс нахилзуулан бүжиглэж, эрчүүдийн сэтгэлийг харцаар нь нэвг шувт уншин, эгзэгий нь тааруулж байгаад өвөр дээр нь сууж зангиагаар нь оролдон наалинхайтаж байгаад дотоожиндоо хэдэн төгрөг хийлгэчихдэг, таалагдсан нэгэнтэй нь эзнээсээ сэмхэн нуугаад учирчихдаг баарны мэргэжлийн тайчигч хүүхэн болж чадсан. Бахархаж, гайхуулах ч эрдэм биш л дээ. Тэгэхдээ л “эрдэмтэн” ээж, “доктор” дүүгээ өөртэйгээ тэжээж дөнгөөд л байдаг юм. Нэр нүүр, ирээдүйгээ баллан авчирдаг халтар төгрөгөөр нь амьдардаггүй юм шиг, өөрөөс нь ичиж, муугий нь дуудаж суудаг ч гэсэн төрсөн ээж, газар дээрх дүү хоёр нь л юм чинь. Хэдийгээр зэвүү нь хүрэхээр ээжийгээ “эрдэмтэн авгай”, дүүгээ “доктор оо” гэж тохуурхдаг ч уруул дордойхоос элэг дордойх биш дээ.

Сараагаа л өөр шигээ бүү болчихоосой гэж залбирдгийг тэр хоёр мэдэхгүй, мэдэх ч албагүй л дээ.

Тэр босч хөл нүцгэнээрээ хуучин банзан шалаа чихруулан гал тогоо руугаа орж цоргоны хүйтэн ус залгиллаа. Гэрт нь цэвэр ус байсангүй. Урд өдөр нь ядаж ганц шил рашаан аваад тавьчих ухаан ч өөрт нь байсангүй дээ. Ээж нь ус буцалгаад тавьсан ч түүн шиг дотор нь муухайран шартсан хүн тэр бүлбэгнэсэн бүлээн буцалсан усыг ганц балгаж ч чадахгүй. Нэг сайн суниаж аваад гар утсаа асаалаа. Хэн ч залгасангүй. Хүний урманд мессеж ч алга. “Би гэж хэнд ч хэрэггүй амьтан юм биз дээ?” гэж ундууцангуй бодоод орондоо орж хэвлээ. “Нөгөө Чинбат гэдэг нь таг шүү. Яагаад над руу залгахгүй байнаа?”

Эртүүд намайг өвөр дээр нь сууж байхад авгай нь орж ирэхэд царай нь ёстой мануухай шиг болсон шүү. Гэртээ хариад авгай нь яасан бол доо? Инээдтэй юм. Тэр авгай яах гэж нөхрөө мөрдөж очсон юм бол? Тэнэг байх аа. Би л бол гэртээ л сууж байна. Хүүхнүүд нөхрийгөө өөрөөс нь бусад хүүхэн рүү хардаг ч үгүй гэж итгэдэг юм байх даа. Эрчүүд л бол эрчүүд ш дээ. Хүүхнүүд шал тэнэг байх юм аа. Авчирсан мөнгий нь идээд л дураараа дургиж байсан нь дээр баймаар юм. Чинбат шиг нөхөртэй байсан бол тэгж тэнэглэж явахын хэрэг юу байнаа?” хэмээн хүйтнээр бодно. Тэр ч харин “White lotus“-ын байнгын зочдоос шал өөр хүн гэдэг нь харваас илт байсан шүү. Хүзүүгээр нь тэврэхэд хичнээн зөөлөн, үнэтэй нь илт сайхан ус сэнгэнэж байлаа. Бусад эрчүүд шиг хөх хонгоноос нь эрээ цээргүй базахыг ч санаархаагүй. Буурьтай, ухаалаг, мөнгөтэй, жинхэнэ эр хүн. Гэхдээ тийм харваас хүндтэй хүний өвөр дээр Наран тэгж шулуухан суугаад аалигүйтээд байхыг бодоогүй юм. Ердөө л менежер Баясаа хэмээх зэвүүн залуугийн даалгавар байснаас тэгсэн билээ. Сарын өмнө 500 доллар зээлснийхээ барьцаанд орчихоод л “Тэр саарал костюмтай хүний өвөр дээр яг одоо очоод суу. Олигтойхон янаг аашлаарай” гэж тэр тушаасан. Тэгтэл ч удалгүй эхнэр нь ороод ирсэн. Эхнэр нь ч харваас боловсролтой, ухаалаг хүн байх шиг байсан. Түүнээс биш зарим айлын авгай шиг хашгичиж, өөрийг нь үсдэж, элдвээр хэлэх л байсан шүү дээ. Гэтэл тэр таг дуугүй харж зогссоноо нөхөртөө нэг юм хэлээд л гараад явчихсан. Наранд айлын эхнэр, нөхрийн хооронд тэгж орж, хэрүүл шуугианы бай болох нь ёстой таалагдаагүй. Баясаа бол ёстой адгийн шаар. Тэр л хүмүүсийг хүүхнээр далимдуулан далайлгаж сүрдүүлэх олиггүй ажлаар мөнгө олдог амьтан! Гэтэл Наран аргагүй мөнгөний хэрэг болоод түүнээс хэдэн халтар төгрөг зээлснээс болоод тэр увайгүй ажилд нь гар хөл болчих ч гэж дээ. “Чи нөгөө дарга амьтан руу мессеж бичээд жаахан маяглаатах. Хэрэв уулзъя гэвэл татгалзаж тэнэглэв ээ? Дэгээндээ ордог л юм бол нэг аятайхан газар уулзаарай. Би уулзах газрыг чинь зааж өгнө. Тэгвэл өрийг чинь цайруулаад нэмж шагнана шүү” гэсэн. Гэтэл тэр Чинбат гэх хашир “тул” Нарангийн дэгээг тийм ч амархан үмхэхгүй байна гээч. Тэр тусмаа л сонирхлыг нь татаад байлаа. Эхнэр нь лав өөртэй нь чацуу биз. Цагийн эрхээр царай зүс нь хөгширч, гундаж яваа л хүүхэн харагдсан. Эрдэм номтой нь тэндээ л биз. Эр хүн л юм чинь залуу, сайхан хүүхнийг сонирхож л байгаа. Гэхдээ л ёстой “хатуу самар” юм гээч. Зурагтаар их хурлын чуулган дээр ихэмсэг царайлан, эх орончийн дүр эсгэж суудаг зарим эрхэм тэдний баарны жижүүрийн зочин болчихсон охин нь баймаар залуу бүсгүйчүүдтэй маазарч, марзганаж байдгийг мэдэхгүй биш дээ. Харин Чинбат бол тэднээс өөр хүн байсан. Тиймдээ ч бүсгүйд жинхэнэ эр хүн шиг санагдсан билээ.

Гэртээ үд дунд ингээд гав ганцаараа байх аятайхан. Хажуу айлын хоёр дэггүй хүү

шуугилдаж, түчигнэхгүй, зурагтаар ээж нь мэдээ үзэн “номын” царайлж саад болохгүй, Сараа чихээ даран дэвтэр номоо дэлгэн “шаналгаа” болохгүй. Болдог сон бол ингээд л ганцаараа амьдрах сан. Үгүй ээ, одоо удахгүй 22 хүрэх гэж байдаг. Амьдралын хань, жинхэнэ эр хүнтэй учран өөрийн гэсэн гэр бүл, гал голомттой болдог л нас. Ганц мод гал болдоггүйн амьд жишээ аавд нь хаягдаад ганцаараа арай л сөхөрчихгүй амьдралаа үлгэн салган авч яваа ээж нь билээ.

Бүсгүй хүнд бодлоо тархинаасаа сэгсрэн хаямаар байлаа. Мессеж бичин тэнэгтэж суухаар яаман дээр нь ямар нэг шалтаг хэлээд очдог юм бил үү ч гэсэн бодол тэнүүчилнэ...

Наран шөнө гэрийнхэндээ жаахан агсам тавьснаа бүүр түүр санаад байлаа. Гэвч амьдралын эрхээр, өөрсдийнх нь төлөө бүхнээ золиослон явааг нь ойлгохын оронд өөрийг нь “муу охин” хэмээн далдуур зэмлэн адлах ээж, ном шагайн суусаар ертөнцөөс тасарчихаад эгчийгээ, ер нь хэнийг ч ойлгохыг хүсэхгүй, дүнгийн хойноос хөөцөлдөн улам улам хатуу сэтгэлтэй болж яваа дүүдээ гомдсон сэтгэл нь далангаа сэт татсан үерийн ус мэт сад тавьсан нь тэр. Ийнхүү бодолд дарагдан хэвтэх зуур утас нь дуугарлаа. Нэг л танил дугаар байв. “Аан тийм, Номингийн дугаар байна” Их сургуулийн нэг ангид хамт сурч байсан ангийнхнаас нь түүнд хамгийн дотно ханддаг асан ганц найз нь Номин байсан юм. Гэвч түүний хувьд сургуульд сурч буй нэртэй үймэлдэн, хэдэн багш нараа аргалаад, хичээл дээр үүрэглэх нь үүрэглэн, баасан ахын төрсөн өдөр хаана тэмдэглэх вэ? гэдгээс өөр бодох санах юмгүй оюутны амьдрал дэндүү хол, дэндүү гэнэн, бас “дээдсийн” ертөнц мэт санагдах болсноос тэр ертөнцтэй холбож асан бүх л холбоо, сэжмээ таслахыг хичээсээр өнөөг хүрчээ. Сургуульдаа толгой цохихоор хөөрхөн, хамгийн сурлага сайтай охидын нэг байсан Наранг ганц нэг багш л хааяа үгүүлэн асууж сурагласан сонсогдохоос бус ангийнхан нь бараг л ор тас мартсан мэт байсан сан.

-Байна. Ямар сонин хүн бэ? За сайн уу? Найз аа?

-Сайн уу? Чи чинь яасан усанд хаясан чулуу шиг алга болчихдог хүн бэ? Яагаад надтай ярьдаггүй юм бэ?

-Сайн. Чи миний утсыг хаанаас олоов? Хичээлдээ яваад л байна уу? Манай ангийнхан сайн уу?

Дуу хоолойндoo нуухын аргагүй шингэсэн гунигт өнгийг далдлах гэж байдгаараа хичээн Номинг тийнхүү асуултаар булаад байгааг найз нь ч бас гадарлав бололтой.

-Манай ангийнхан сайн, сайн. Арзганалдаад л байцгааж байна. Энэ жил диплом бичих гээд л бөөн үймээн. Утсыг чинь Сараагаас аваад... Чи надаас юу гэж зугтаагаад байдаг юм бэ? Гомдмоор юм.

-Яахав дээ. Миний сургуулиас яагаад гарсныг чи сайн мэдэж байгаа ш дээ. Сараагийн утсыг чи мэддэг юм уу?

-Сургууль дээр нь очиж хүлээж байгаад уулзсан юм аа.

-Над шиг муу хүнтэй найзлах ийм л балагтай байгаа юм даа. Хамаг цагаа үрж, анагаах дээр эргэлдээд л. Барсаа сайн уу?

-Сайн. Бид хоёр хуримаа хийх гэж байгаа ш дээ. Чамайг урих гэсэн юм. Уул нь бүүр эрт л чамд дуулгамаар байлаа. Тэгсэн чинь чи олдохгүй байсаар тулчих юм. Нараа чи урьд нь ярьдаг байснаа мартаагүй биз дээ?

Наран өөрийн эрхгүй санаа алдлаа. Урьд нь, урьд нь ч гэж дээ. Дөрвөн жилийн өмнө Номин тэр хоёр нэгдүгээр курсэд орсноосоо хойш салшгүй дотно үерхэж, хуримаа нэг өдөр хамтдаа хийнэ, хэрэв нэг өдөр хийж чадахгүй бол хэн түрүүлж хурим хийнэ түүнийхээ хамаг ажлыг хариуцаж зохион байгуулна гээд л элдвийг мөрөөддөг байсан нь одоо эргэн санахад хиргүй цэвэр сэтгэлтэй байсан хүүхэд ахуйн сүүлчийн гэнэн мөрөөдөл байсан юм уу даа. Хамгийн гол нь Наран одоо хэзээ нэгэн цагт хурим хийнэ, цасан цагаан даашинз өмсөнө гэдэгтээ эгнэгт итгэл алдраад байлаа.

-Санаж байна. Саналгүй яахав дээ. За тэгээд баяр хүргэе. Энэ үгийг чин сэтгэлээсээ хэлсэн болохоор дуу хоолой нь хөхүүн сэргэлэн сонсогдсон бололтой. Номин ч сэргээд ирэв.

-Чи яагаад ингэж найз нөхдөөсөө зугтаад байдаг хүн бэ? Утсаа өөрчлөөд алга болчихно. Ангидаа хамгийн дотно найз байгаагүй юм шиг л надаас хүртэл зугтаах юм... Тэр цааш нь нэг үг хэлэх гэсэнээ больчихож байгаа нь илт үгээ тасалчихав. Тэр нь мэдээж “Сургуульдаа буцаж орооч. Тийм сурлага сайтай байсан юм байж...” энэ тэр гэсэн утгагүй ятгалга байж таараа. Нарангийн занг гайгүй сайн гадарладгийн хувьд сүүлчийн үгээ хэлэлгүй хоолойдоо үлдээсэн нь илт. Хамгийн сүүлд жилийн өмнө нэг диско бааранд тэр хоёр ёстой санаандгүй улаан халз тааралдаад Номин түүнийг сургуулиа хаялаа хэмээн зэмлэхэд жаахан халамцуу явсан Наран ам нээхээр уушиг нээ гэгчээр цээжиндээ хуралдсан бүгдийг ямар нэгэн хяналтгүйгээр ярих шиг л болж билээ. “Би яахав ээ, та нар шиг баян айлын бандгар хүүхэд биш. Эцэгтээ гологдсон, үерхэж байсан залуудаа ч хаягдсан амьтан. Надад дээд сургуульд сурсан нэртэй та нар шиг эрхэлж явах боломж ч алга, хүсэл сонирхол ч алга. Сургуульдаа ор, сургуульдаа ор гэнэ шүү. Хаа байгаа юм тэр их мөнгө? Намайг хараад нүд нь хорсч явдаг муусайн арзганасан охид, хичээл дээр элдвийн эсэргүү юм ярилаа гэж адалдаг багш нар, за тэгээд тэр Хангал хүртэл Наран байхгүй, нүдэнд нь үзэгдэхгүй алга боллоо гэж баярлана уу, гэхээс хүний урманд харамсахгүй юм чинь. Чи ч гэсэн дотроо надтай өрсөлддөг л байсан биз дээ? Би хэнд ч хэрэггүй хүн гэдгээ мэднэ. Худлаа жүжиглэж амьдарч чадахгүй. Чи ч гэсэн жүжиглэх хэрэггүй. Яасан? Найздаа санаа тавьсан сайн хүн болж жүжиглэх хэрэгцээ чамд байгаа биз дээ? Хүн чанар гэдэг юм байгаагаа харуулах хэрэгтэй болоо юу? Хэрэггүй. Тэр хүн чанараа өөр газар, тэр эмгэнэлт жүжгийнхээ тайзан дээр гарга, мэдэв үү? Амьдрал гэдэг юм та нарынх шиг багаа хуулахаараа ямар байдгийг би мэднэ.” гэхчлэн бараг л агсам тавиад гарч алга болсноо Наран бүүр түүр санан маргааш нь Номинг өрөвдөн, үгүй ядаж л найз залуугийнхаа өмнөөс яаж нүүр нь улалзсан бол гэхээс сэтгэлдээ өнөөг хүртэл гэмшил тээсээр яваа билээ. Өглөө нь архи нь гарч ухаан санаа цэлмэсэн хойноо бодоод байхад хүн хүний хувь төөргийг хэн хаана зурчихсан байдгийг мэдэх биш. Ядаж тэр өдөр солонгос айлынхан нь нутаг буцах болсноо дуулган, гай болоход тэдний хүнсийг цуглуулж яваад Хангалтай тааралдаж сэтгэл зүрх нь нэгмөсөн шархлан урагдаад арга ядахдаа ганцаараа диско бааранд орж, хатуу архи биш ч дэндүү их дарс уусаар халамцсан явсан юм. Нарангийн

энэ бараан хувь тавиланд Номин ямар ч буруугүй. Ямар ч байлаа гэсэн өөрийнх нь төлөө сайн үг хэлсэн байтал өөдөөс нь гаргасан аашаа бодохоор сэтгэл нь хэдэн өдөр хөндүүрлэн зовж байсан ч утасныхаа дугаарыг өөрчлөөд түүнээс нэгмөсөн холбоогоо тасалж билээ. Аав, ээж нь сэхээтэн, хотын төвд сайхан байртай, элэг бүтэн дүүрэн жаргалтай айлын том охин. Хөөрхөн, ааш зан сайтай, хүмүүжилтэй Номин түүний хувьд тэс өөр ертөнцийн хүн мэт санагдан, тэдний зам улам улам холдон хэзээ ч эргэн нийлэх ёсгүй юм шиг санагдах болсоор удсан юм. Хааяа мэдээж найзыгаа үгүйлэн уулзах сан гэж бодох боловч шөнийн цэнгээний газрын тайчигч өөр шиг нь замаа алдсан хүүхэн эрх танхи, хүүхдэрхүү, амьдралын хахир хатуу аашийг таниагүй, цаашид таних ч үгүй Номин шиг хүнтэй зам нийлэхгүйгээс хойш холхон шиг л явья л гэж бодно.

-За тэгээд хэзээ хурим чинь болох юм бэ? Хавар хийдэг нь яаж байгаа юм? Гэгээн Валентиний өдөр өнгөрчихсэн биз дээ. Зун хуримаа хийвэл гоё ш дээ гэж Наран найзынхаа баярыг чин зүрхнээсээ хуваалцахын тулд түрүүний бүүдгэр саарал дурсамжаасаа хүчлэн салж аль болох цовоо сэргэлэн өнгөөр асуусан ч ёстой л өөрийнхөө хэлдгээр эмгэнэлт жүжигт тааруухан тоглож буй дагалдан жүжигчин мэт хиймэл дуугарч байгаагаа мэдрээд байлаа. Номин түүнд дуулгаж байгаа баярт мэдээ нь Нарангийн хувьд гунигтай байгааг ухаарч байгаа бололтой даруухан дуугаар:

-Одоо гурван долоо хоногийн дараа хийнэ. Хоёулаа уулзъя тэгэх үү? Чи битгий л алга болчихоорой доо хэмээн гуйлаа.

-Уулзанаа. Уулзалгүй яах юм бэ? гэж амлахдаа гавьяа байгуулчихсан юм шиг хүнээр ингэж гуйлгаж байгаадаа эмзэглэж л байлаа.

Найзтайгаа ярьж дуусаад тэр сэтгэл нь бага зэрэг хөнгөрөн санаа алдаад босов...

Сургууль соёлоо хаяж, амьдралын шуурганд ийнхүү бүдэрч, нийгмийн ёроол дунд хутгалдан яваагийнх нь нэг шалтгаан болсон Хангалын тухай бодохоор дургүй нь хүрч тамхи гарган асааж утааг нь уушиглан шуналтайгаар хэд сорж байж сая тайвшрав. Наран анх их сургуульд орчихоод аав нас барсан, ээж багшийн сургуульд багш гэх мэтээр өөрийгөө ангийнхандаа аль болох сайн сайхнаар танилцуулан, гэрээ нэгдүгээр хороололд гэж ярьдаг байлаа. Мэдээж хүүхэд гэнэн зангаар хүнд хэцүү амьдралаа нууж нэрэлхэж байгаа царай нь тэр байв. Арван жилдээ хойноос нь гүйлдэх ганц ч хөвгүүнд царай өгдөггүй, хичээл номондоо шамдан, дотроо бол мэргэжил мэдлэгтэй болж, ээждээ нэмэр болох, яаран хүнтэй суухгүй, мундаг хүн болно гэсэн гэгээн хүсэл зорилготой хатуу, чанга охин явсаар Их сургуульд элсэж, зэргэлдээ ангийнхаа Хангал хэмээх залууд сэтгэл алдран үерхсэн нь төсөөлөхийн аргагүй гунигтайгаар төгсөнө гэдгийг яаж мэдэх билээ. Тэд жил гаруй үерхэн сургуулийнхаа хамгийн сайхан хосод тооцогдож байлаа. Гэхдээ одоо бодоод байхад энэ үерхэл эхнээсээ л бүсгүйд сэтгэлийн олон зовлон нэмжээ. Гар гараа хөтлөлцөн гүйлдэх нэг хэрэг. Нэгэнт үерхэж байгаа хойно гэр орноороо орж гарах болно. Хангал ч яахав боломжийн айлын хүү болсон хойно ээж, аавынхаа эзгүйд ширээ засч, цэцэг навч болоод л анх түүнийг гэртээ урьж билээ. Нарангийн хувьд хэдий хүртэл гэрээ худлаа заах билээ.

Нарангийн төрсөн өдрийг нэгэн бааранд тэмдэглээд гэрт нь хүргэж өгөх болоход “Дүүрсэн хэрэг. Миний хаана амьдардгийг мэдэж аваг. Надад л хайртай юм бол гэр орны

минь голохгүй байлгүй“ гэж Наран бодоод Орбитын эцэс рүү байх муу бараанк байшиндаа Хангалаар хүргүүлж очсон юм. Өчигдрийн орсон намрын уйлагнасан бороонд хавийн гудамжны шавар шавхай зууралдан шалбааг болсны хажуугаар, хүчтэйхэн салхинд нураад ойчмоор харагдах ганц дан навсгар байшингийн гадаа Хангал аавынхаа машинаар ирж зогсоод царай нь ямар хачин хувирсныг тэр мартаж чаддаггүй юм. Түүнээс хойш үерхдэг залуугийнх нь ааш зан нэг л өөр болж, аажмаар нүүр буруулсан нь Нарангийн сэтгэлд хэзээ ч эдгэршгүй гүнзгий шарх, ёроолоос нь яагаад ч гармааргүй санагдах гутрал гунигийн хар нүхэнд унагасан билээ. Зун нь нэгэн том намын аппаратад хийсэн дадлагын ажил бүсгүйн сэтгэлийг нэгмөсөн цөхрөлд оруулж намар нь сургуульдаа эргэж очихгүй гэсэн шийдвэрт хүрчээ.

Цасчимэг өглөө нэг л зовиуртай сэрэв. Өөрийнхөө унтлагын өрөөнд байгаа шиг санан хажуу дахь түмбүүшиг рүүгээ гар сунгавал ширээний бяцхан цаг нь байсангүй. “Энэ чинь юу билээ?” Сүүлийн таван жил нүдээ ч нээлгүйгээр тэр л бяцхан цагийг гар сунган аваад хэд болж байгааг харж, хэрэв азаар босох цаг болоогүй бол амтат нойрондоо хэсэгхэн зуур ч атугай эргэн очдог сон. Анх Чинбаттай айл гэр болох гээд үерхэж байхдаа Их дэлгүүрт хамт явж байгаад худалдан авсан, оросын бөх бөгөөд найдвартай эд сэн. Он цагийн уртад алтлаг хүрээ нь цайж, сэрүүлэгний нь товч элэгдэн мөлийсөн ч өдийг хүртэл ганц ч хором хоцорч, түрүүлж байгаагүй, эрхий хуруу шиг итгэлтэй тэр цаг бүсгүйн хувьд амьдралынх нь нэгэн хэсэг мэт санагдах болсоор илүү ч үгүй, дутуу ч үгүй хорин жилийг үджээ. Гарт нь өнөөх жижигхэн хөөрхөн хуучны цаг нь биш хүүхэлдэйн хүйтэн хөл баригдахад цочин өндийлөө.

Тийм байлгүй дээ. Нөхөртэйгээ хамт өргөн орон дээрээ, ижил дасал болсон унтлагын өрөөндөө биш, охиныхоо өрөөнд унтсанаа мартчихаж. Охин нь орныхоо дэргэдэх түмбүүшиг дээр багын хайртай шаазан нүүртэй хөөрхөн хүүхэлдэйгээ, урт иштэй хонхон цэцэг шиг харагддаг ширээний зөөврийн чийдэнгээ тавьдаг билээ. Охин гэснээс Халиунаа охин нь байсан бол сэтгэлд хичнээн ханьтай, аавыгаа ч харцаараа байлгаж, ээжийгээ ч элгэндээ нөмөрлөж чадах сан. Чинбат сүүлийн жилүүдэд охиндоо улам дотносож, зарим муудалцсан үед бол Цасчимэг охиндоо атаархмаар ч юм шиг санагдах болсон билээ. Чинбат өчигдөр ирснээсээ хойш хүний урманд өөр рүү нь ганц ч удаа залгасангүй. Урьд нь урьд нь ч гэж дээ, ер нь хоорондынх нь үл ойлголцол ингэтлээ гүнзгийрэхээс өмнө ялигүй жаахан ам мурийсан ч оройдоо цэцэг, шоколад бариад ирдэг, эсвэл өглөө босоход нь дэрэн доор нь энхрий дотно үгтэй зурвас хийчихсэн байдаг нь дурсамж төдий болсонд хамаг эмгэнэл нуугдаж байлаа.

Эрх мэдэлд шунан одоохондоо арай ч нөгөө ертөнцөд оччихоогүй, амь нас нь дээсэн дөрөөн дээр торж буй сайдын суудлаас өөр юу ч толгойд нь багтах аргагүй болчихоод юун гэр бүл, юун эхнэрээ аргадах, дэрэн доор нь зурвас энэ тэр хийх манатай вэ гэсэн амьтан явж байгаа нь мэдээж. Өчигдөр семинараа тараад тэнхимийн хуралдаа суучихаад хүүдээ санаа зовж яаран гэртээ ирэхэд нь Чинбат чемоданаа жолоочоороо явуулчихаад гэрээрээ шагайгаа ч үгүй байсанд урам нь хугараад л явчихсан билээ. Хэдий муудалцаад үнсний саваар шидүүлэн голдоо ортол гомдсон ч гоньдтой сайхан бууз хийж тавьсан нь тоо ёсоор хөлдөөгчинд байж байв. Цаг зав гарган зун өөрөө гараараа түүж хатаасан гоньдоор амтлан хамгийн гол нь сэтгэл шингээж хийсэн хоолонд нь тэр ам хүрсэнгүй нь улам ч гомдмоор. Хүүгээсээ ямар хоол идэх вэ? гэж асуухад банштай цай, аав дуртай ш дээ гэхэд нь хэдхэн мөчийн өмнөх гомдлоо мартан цагаа тайлж тавиад хормогч зүүн мэдээ үзэнгээ банш чимхэн хүлээсэн нь ч талаар болсон.

Мэдээгээр мэдээж сайн юм, гэрэл гэгээтэй, сэтгэл санаа өөдрөг урамтай болгох юм юу ч байхгүй юм шиг л баахан дээрэм тонуул болсон тухай, хил дээр харуулд гарсан цэрэг хоёр нөхрөө буудан алчихаад өөрөө амиа хорлосон тухай, цөөнх хурал хаясан тухай, хаврын түймэр эхэлсэн тухай, ямар нэгэн хохирогчид өлсгөлөн зарлах болсон тухай л ярив. Гол улам хүйт оргин харламаар хав хар мэдээг дуусгаж чадсангүй, оросын кино суваг дээр тавин хэсэг суугаад зурагтаа унтрааж байж сэтгэл арай тайвшрав.

...Цаг өглөөний долоо өнгөрч байлаа. Нөхөр нь хэдэн цагт гэртээ морилсныг бүү мэд. Өчигдөр хүүгээ унтсанаас хойш лекцэндээ бэлтгэн шөнийн нэг өнгөртөл суухад л тэр хүн сураггүй байсан билээ. Нөхрөө хүрээд ирэх байх гэсэн битүү горьдлого нь талаар болж шөнө дөл хэвийсэн хойно бүсгүй унтлагын өрөөндөө орж ороо засах гэтэл Түүнтэй хамт нэг орон дээр амраг эхнэр, нөхөр хоёр мэт зэрэгцэн хэвтэнэ, хөнжил дотроо хөл гараа шүргэлцэнэ гэхээр сэтгэлд нь багтахгүй тусдаа унтахаар шийдсэн юм. Тэгээд охиныхоо орыг засаад хэсэг хэвтсэн ч нойр нь хаа нэг тийш хулжин оджээ. Босч нойрны эм уугаад охиныхоо үнэр шингэсэн ягаан дэрийг дэрлэн хажуулахад хоёрт арван тав дутуу байсныг санаж байлаа. Хөлөөрөө гэрийн шаахайгаа тэмтрэн олоод хүндэрсэн толгойгоо нэг гараараа барин өндийлөө. Орноосоо босмооргүй, тэгсэн атлаа эргээд хэвтмээргүй, өдрийн бужигнасан их ажил, уулзаж учрах хүмүүс, ер харагдаж байгаа бүхнээс залхан, хаа нэг тийш хулжин одмоор өглөө байдаг даа. Тийм л нэг гунигтай өглөө байлаа. Буцалсан ус уугаад кофе чанан, өглөөний унд бэлтгээд хүүгээ сэрээх, хувцаслаж, бага сага өөрийгөө тордоод номын цүнхээ барин гардаг ерийн нэгэн өглөөнүүдийн нэг. Өглөө бүхэн нэг л янзын ажил хийдэг агал зарим өглөө амьдралын баяр баясгалан, эрч хүчээр дүүрэн, заримдаа ийнхүү толгойгоо дэрнээс хөндийрүүлэхэд ч хүнд байдаг нь амьдрал юм даа. Нөхөр нь түүний цаг завьг хайрлан, аяга таваг, угаах, тоос шороо цэвэрлэх ажилд гар нь муухай болчихно хэмээн бүр охиноо явахаас өмнө л гэрийн үйлчлэгч ав гэсэн ч “Би юм хумандаа гадны хүний гар хүргэмээргүй байна” гээд Цасчимэг дургүйцсэн. Заримдаа өөрийнхөө зөрүүд зангаас залхмаар. Одоо бодоход энэ заваан ажлуудыг хүнээр л хийлгэх нь дээр ч юм шиг. Охиныхоо шүүгээний толь руу зэрвэс хараад тэр угаалгын өрөө рүүгээ оров. Зовхи нь үл мэдэг сэлхэрснээс биш царай нь тунгалаг аятайхан харагдаж байлаа. Цэв хүйтэн ус гоожуулан нүүрээ норгоод овоо сэргэж өнөөдрийн ажлаа бодлоо. Чилийсэн дөрвөн цагийн лекц, улстөр судлалын хоёрын оюутнуудаас шүүлэг авах, интернетэд суун удахгүй хэвлэгдэх сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүлд өгөх нийтлэлдээ бэлтгэх, хими цэвэрлэгээнд өгсөн хувцаснууд авах, амжвал хүүгийн тооны багштай уулзах... бодоод байвал барагдашгүй олон ажил, больёо. Нүүр шүдээ угаагаад толгой овоо сэргэн гарч унтлагын өрөө рүүгээ нэг л мэдэхэд шагайж зогсов. Нөхөр нь хувцсаа шалаар нэг тараан тайчиж хаяад нам унтаж байлаа. Юу ч болоогүй юм шиг. Эсвэл үнэхээр шургаж унатал ядраа юу? Гэтэл шөнөжин хаана юу хийж явдгийг нь тэр мэдэх бил үү? Долоо хоногийн өмнөх өнөөх бааранд болсон явдлын дүр зураг сэтгэлд нь гялсхийн орж ирээд мөчийн өмнөхөн зүрх сэтгэлд нь үерлэн орж ирсэн хайрлах сэтгэлийн дулааныг арчин хаялаа. Бүсгүйн сэтгэлд хайрлах, өрөвдөх, үзэн ядах, гайхашрах холилдон аль нь ч нөгөөдөө зай тавьж төвдөхгүй багтаж цөхөн тэмцэлдэж байх мэт.

Шалаар тараан хаясан хувцсыг нь цуглуулан намхан сандал дээр тавиад унтаж байгааг нь далимдуулан нөхрийнхөө духыг нь зөөлөн илээд өрөөнөөс сэмхэн гарч хүүгээ сэрээлээ. Охин нь өглөө сэрэхдээ нойрондоо харам гэж жигтэйхэн хүүхэд билээ. Одоо харин эцэг, эхээсээ хол, биеэ даан амьдарч сураад, өглөө нойрмоглохоо болио биз. Харин хүү нь тиймгүй.

Ээжийнх нь гар духанд нь хүрмэгц сэрчихдэг нь өхөөрдөм. Тэгээд “Ээж!” хэмээн жаргалтайяа инээмсэглэн хэлээд хүзүүгээр нь тэврэх нь өөр юугаар ч сольшгүй, юутай ч зүйрлэмгүй аз жаргалыг мэдрүүлдэг юм. Хүүдээ хичнээн хэрэгтэй, хүү нь өөрт нь хичнээн хайртайг мэдрэх шиг гайхамшиг гэж үгүй. Энэ удаа ч тэр хүүгээ тэврэн орон дээр нь сандайлахдаа “Энэ ертөнцөд надад хувирашгүй үнэнч ганц эр хүн миний хүү л юм даа” гэж мэдээжийн атал сэтгэлийн хөндий хоосон зайг дүүргэм өег сайхан бодлоор өөрийгөө тайтгаруулж суулаа. Тэгээд хүүгээ ундлуулж, хувцаслах гэсээр нэг л мэдэхэд гуч дөчин минут нисэх мэт өнгөрч, өглөө сэрэхэд нь сэтгэл хөндүүрлүүлж асан гуниг гутралаа ч мартаад гарч оджээ.

Чинбатыг утасныхаа сэрүүлгийн дуугаар сэрэхэд есөн цаг болж байв. Авгай, хүү хоёр нь явцгаачихжээ. Мань хүн урьд шөнө хүн амьтантай уулзаж ажил зохицуулж явсаар шөнийн гурав болж байхад л сая гэрийн бараа харжээ. Чимгээг сэрээчихээс болгоомжлон түлхүүрээ аяархан дуугаргахыг хичээн хаалгаа чимээгүйхэн онгойлгож, гутлаа дөнгөж үүдэн дээрээ тайлан хаалганы хажууханд хүү нь тавьсан бололтой гэрийн шаахай нь байсныг олж углаад гэр рүүгээ орж явчихсан. Хэдий гадаадад цөөхөн хоносон ч өег дулаан, нэг л өөриймсөг гал голомтоо мөн ч их санажээ.. Уужимхан тохилог байрных нь бүр мухарт нь унтлагын өрөөнд эхнэр нь нойрсч буй гэж бодохоос хайр хүрнэ. Муудалцсанаа энэхэн мөчид мартчихжээ. Эхлээд эр хүн л болсон хойно гал тогооны өрөө рүүгээ шагайхад эхнэр нь банштай цай хийгээд аяганд нь тавьсанд сэтгэл их л уярч шарах шүүгээнд хийж халаагаад хоол идэх дур бага байсан ч хэд халбагадаад хүүгийнхээ өрөө рүү очих гэснээ хазайн унтлагын өрөө рүүгээ шагайвал Чимгээ байсангүй. Охины өрөөнд унтсан бололтой. “Уур нь гараагүй байх нь. За боль л доо, Чимгээ гуай. Арван наймтууд, хорин тавтууд биш дээ, ямар” гэж бодохоос дургүй нь хүрэн зүрх нь дахин хүйт даагаад явчихав. “Маяглах нь таалагдаж байвал тааллаараа болно биз. Надад тэгж муур хулгана бололцох зав ч, сонирхол ч, чадал ч алга”.

Тэр өдөр цагийн зөрөө нь гараагүй, онгоцонд олон цаг ниссэнээс толгой дүйнгэтэн ядарч байсан ч сайдын зөвлөлийн хурал, эмнэлэгт байгаа сайдыг эргэх, дүүргийнхээ намын хороонд мөнгө өгөх, дөнгөж буудалд хөл тавихад нь л туслахаар нь дамжуулан мөнгө нэхээд эхэлсэн сэтгүүлчийг дуугүй болгох, нөгөө нэг нөлөө бүхий эрхэмд хүүхдийнх нь сургалтын төлбөр нэрээр гарыг нь хүндрүүлэх мөнгийг тэр нь арван мянган доллар зохицуулсны дараа, өөрийнхөө ивээгч гишүүнтэй уулзаад, эцэст нь багын найз Пандагаасаа зөвлөгөө авснаар сая ертөнцийн нэг үйлт өдрийн ажлаа нугалаад гэрийн бараа харж байдаг. Тиймэрхүү л “шуурган” дундаас харьж ирэхэд нь гэргийгээс нь барьж буй бэлэг энэ. Элдэв асуудал гарахаар ээдрээг нь тайлахад тусалж, үнэт зөвлөгөө өгдөг, урьд нь цагдаад олон жил муугүй алба хашсан Пандага хочтой найзтайгаа уулзан сүүлийн хэдэн өдрийн явдлуудаа ярилцан суухдаа сөхөрч унатлаа ядарснаа мэдэрч л байсан билээ.

-Чамайг сайдын суудалд магадлалтай байгаа гээд мэдээлэл цуглуулаад эхэлчихсэн ажиллаж байгаа нь тэр. Чиний хувьд юу эмзэг вэ? гэдгийг цаадуул чинь мэдэхийн цаагуур мэдэж байна. Чи нэг их хүүхэн энэ тэртэй холбогдоод байх биш. Гэтэл гэр бүлийн асуудлаар орооцолдуулах хэрэгтэй байдаг. Дагуултай болсноо мэддэггүй ээ. Чиний машины араас хоёр ч янзын жижиг япон тэрэг дагасан байна лээ. Би замын цагдаагаас лавласан. Монголд дөнгөж орж ирээд сар болж байгаа, оруулж ирсэн хүнийхээ нэр дээр бүртгэлтэй юм билээ. Туслах банди чинь хүртэл чамайг тэр бааранд орсныг мэдээгүй байдаг. Гэтэл Чимгээ

мэдчихдэг. Танай тэр туслах залууг шалгасан гайгүй юм билээ. Гэр бүлтэйгээ хагаралдах нь чиний хувьд эмзэг цэг, ийм маягаар сануулга өгөх санаа. Тэгээд л Чимгээ рүү мессеж явуулсаар байгаад тэр бааранд очуулчихгүй юу. Алтны уурхайн тухай мэдээллийг ч хэд хоногийн өмнө Төрийн өмчийн хорооны архиваас хүнээр авахуулсан байна лээ хэмээн Пандага үгээ зөөн нэгэн жигд дуугаар яриад дуугүй болсон.

-Эзнийг нь мэдэж болохгүй юу?

-“Өглөө“-д ч билүү, “Тэмцэл“-д нь ч бил үү Сүхбаатар “Биш ээ, эзнийг нь, эздийг нь“ гэдэг шиг юм болох нь ээ. Ер нь бол ойлгомжтой ш дээ. За тэгээд яав, “Ах“ баарны нүцгэн хүүхэн өвөр дээрээ суулгачихсан баясаж суудаг, авгай ороод ирдэг хагуухан л юм болсон биз дээ?

-Хэлэх юм биш. Хэрүүлээр үдүүлсэн. Өнөө өглөө намайг ирэхэд ч Чимгээ Нүхтэд семинартай гээд алга болсон байна лээ. Одоо хүртэл утасдаа ч үгүй.

-Та хоёр ховорхон л халуухан хос байсан сан. Чимгээ шартай л даа. Тэхдээ ухаантай хүн. Нөгөө хүүхнийг айлын тэнэг авгай нар шиг самардаад унаагүй байлгүй гээд Пандага аяархан хэг хэг хөхөрсөн нь Чинбатын хувьд инээд биш, ханиад байлаа...

Нээрээ нөгөө нэг баарны хүүхэн өөрийнх нь утсыг хаанаас ч олсон юм мессеж бичээд байсныг найздаа хэлэхээ мартсан байв. Мэдээж явуулга л байж таараа. Хүүхэн ч гэж аятайхан амьтан байсан шүү. Хүзүүгээр нь тэвэрсэн гар нь цэв хүйтэн байсныг санаад нуруугаар нь хүйт оргив. Харин задгай намирсан үс нь нүүрийг нь ирвэгнүүлж байсан... Нэрийг нь ч үл мэдэх, одоо зүсийг нь эргээд үл санах тийм нэгэн баарны хүүхнээс болоод эхнэртэйгээ хэрэлдэн, юм хумаар шидсэнээ бодохоор уур хүрмээр. Өдрийн 24 цаг амьсгалахад ч хүрэхгүй мэт нисэх мэт өнгөрч шуурган дунд байгаа мэт элдэв үйл явдал, үймээн шуугиан дунд галзуу хурдтайгаар эрчлэн одож буй энэ амьдралд ямар утга учир байна вэ? гэдэгт заримдаа эргэлзмээр. Ийнхүү дотоод сэтгэл рүүгээ хэдхэн хором ч гэсэн өнгийх боломж өглөө сэрсний дараа л олдох юм. Алмайрч хэвгээд байж үл болох алтан хормыг алдахгүйн тулд тэр үсрэн бослоо. Шүүгээнд нямбайлан индүүдэж захыг нь цардан өлгөсөн олон цамцнуудаасаа цайвар цэнхэр “BOSS“, цусан улаан зангиатай сонгож толины өмнө удтал зангиагаа нямбайлан зангидав. Хувцасны том шүүгээний хаалган дахь босоо толинд Чимгээгийн дүр тодрох шиг. Толинд үйл явдлын дүр зураг, нүүрээ тольдсон хүмүүсийнх нь сайн муу энерги шингэж үлддэгт эхнэр нь итгэдэг. Гэрийнхээ толинд гадны хүмүүсийг харуулах дургүй байдаг билээ. Зарим нэг найзуудынх нь эхнэр шиг мухар сүсэггүй, лам хараар яваад нөхрийнхээ инээдийг хүргэм гэнэхэн засал, домоор хөөцөлддөггүй атал Чимгээ толины ид шидэнд л сэтгэлийн угаас итгэдэг нь сонин юм шүү. Өглөөгүүр өөрийг нь унтаж байхад Чимгээгийн гар духанд нь үл мэдэг зөөлнөөр хүрч илээд байсныг бүүр түүрхэн санаж сэтгэл нь түүнийг хайрласан энхрийллээр дүүрэн ээнэгшив. Охиныхоо өрөө рүү нэг орох гэснээ больж үнэртэй ус авч цацах зуур шалан дээр унасан Чимгээгийн торгон цагаан халатны бүсийг авч гоёлын ширээнийх нь өнцөгт тохлоо. Энэ халатны бүс, өглөөхөн духыг нь зөөлнөөр илж байсан гар, уурлахаараа охиныхоо өрөөнд ороод унтчихсан нь, шөнө дөлөөр ирээд шалаар нэг тарааж хаясан хувцсыг нь нямбайлан цэгцэлсэн нь, өмсөх цамцнуудынх нь захыг цардаад толийтол индүүдэж тавьсан нь Чимгээгийн түүнд зориулдаг хэмжээ хэмгүй хайр, халамжийн дулааныг мэдрүүлж зүрх сэтгэлийнхээ гүнд өөрийнхөө хайхрамжгүй, хахир хүйтэн занд гэмших сэтгэл

төрүүлнэ. Гар утас нь чичирхийлэн дүнгэнээд бодол нь тасарчихлаа. Жолооч Гантулга дохиж байгаа нь тэр. Толинд сүүлийн удаа харж сэтгэл хангалуунаар хөмсгөө хөдөлгөөд унтлагын өрөөнөөсөө гарлаа. Сэтгэлийг нь хоромхон зуурт эзэмдсэн эхнэрийн тухай хөндүүрт бодол нисэн оджээ. Цэвэр ус халаагчаас бүлээн ус нэг аягыг хийж аваад ганцхан амьсгаагаар залгилаад гарахад бэлэн. Хаалгаа цоожлоод гарч явтал туслах нь залгалаа. Ингээд дахин нэг шуурган өдөр эхлэх нь тэр ээ. Гэрээсээ гарч явахдаа нэг намынхаа нөхөр, томоохон агентлагийн захирал Алтансүхтэй улаан халз мөргөлдчихөв. Тэр хоёр их л ойролцоо томилогдсон ч хоорондоо төдийлөн сүйд майд болж дотносч явсангүй. Гэхдээ шинэ жилээр намынхаа хүлээн авалт дээр эхнэртэйгээ явахыг нь хэд хэд харснаас гадна гэр нь энд байдаггүйг сайн мэдэх билээ. Гэтэл мань хүн хажуугийнх нь орцноос хар өглөө гарч явдаг.

Танилуудынх нь амнаас унаж байсан дэл сул үгээр бол Алтансүх хоёр дахь эхнэрийнхээсээ гараад явж буй нь тэр аж. Албан ёсны авгай нь хүүхдийн эмч ажилтай, харваас намбалаг бүсгүй байдаг билээ. Гэтэл нөхрийнхөө нууц амьдралыг мэдэхийн цаагуур мэддэг, мань эр ч хоёр эхнэртээ хоёуланд нь хайртай гэж халамцуудаа ярьдаг гэж сонссоноо санах. Алтансүх толгой дохин мэндлээд машиндаа сууж давхин одов. Хүмүүсийн амьдрал ямар ч сонин байдаг юм. Энэ нөхрийн эхнэр гэж нэртэй сайн эмч, гуч гаруй насны аятайхан бүсгүй нөхрийнхөө энэ хоёрдмол амьдралтай яаж эвлэрээд сууж чаддаг юм бол? гэж гайхмаар. Ийм амьдралтай улс өнөөдөр хэнд ч гайхал төрүүлж, нүдэнд эвэр ургуулаад байхаа больсон нь Чимгээгийн хэлдгээр нийгмийн үнэлэмжийн доройтол юм уу, байх л ёстой үзэгдэл ч юм уу бүү мэд. Хэдийдээ яаж ч хоёр гэр бүлтэй зохицоод байж амждаг юм бүү мэд. Би л ганцыгаа яая гэж байхад хэмээн мань хүн төвөгшөөнгүй бодоод машиндаа сууж билээ. Түүний хувьд өөрийгөө дотроо зэмлэж явдаг нэг зүйл бол хүүдээ цаг гаргаж чаддаггүй, бараг бараагаа ч харалцалгүй явсаар том болгож байгаа явдал билээ. Охиноо бага байхад залуу ч байж, завтай ч байж. Үлгэр ярьж өгч тоглуулж, ном үзэж, хамтдаа музейгээр яваад л сайн аав байсан сан. Тиймдээ ч охиндоо амь тавьж, сэтгэл санаагаа хүртэл хуваалцдаг, одоо хичнээн завгүй байсан охиндоо хэдэн үгтэй мэйл биччихдэг, хол газар яаж явааг нь мэдээд байдаг атал хүүгээ танихгүй л өсгөж байдаг. Иймэрхүү юман дээр эхнэрийнх нь битүү зэмлэл яах аргагүй ортойг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй.

Дахиад л гар утас нь бодлыг нь тасалчихлаа. Бодлого төлөвлөлтийн газрын дарга Сэлэнгэ хэмээх бүсгүй залгаж байна. Хөнгөн үйлдвэрийг дэмжих төслийн хуралтай гэнэ. Удахгүй байгуулагдах хөнгөн үйлдвэрийг дэмжих агентлагийн дарга болох хамгийн их магадлалтай, ажлаа мэдсэн шиг мэддэг хүүхэн. Энэ агентлагаар дамжих хөрөнгө оруулалтыг дэмжих мөнгө ихийг хэлэх үү, олон хүний шүлсийг гоожуулж байгаа газар. Сэлэнгэ хичнээн сайн гар нийлдэг, ажлаа мэддэг байлаа ч эмэгтэй гэсэн том дутагдалтай юм даа хэмээн сайд нь хэлж байсныг санаад жуумалзав. Сайд гэснээс өчигдөр оройн сонссоноор гадаад явах замын аяыг бие нь даахгүй гэж эмч нь хэлсэн, ухаан орохоос өнгөрсөн нь нэгэнт ойлгомжтой болсон гэлцэж байсан. Дараагийн сонгуульд нэр дэвшихэд тойргоо бэлдэж хөдөөгүүр яваад л яамны зарим нэг хөрөнгө оруулалтыг сэмхэн тийш нь чиглүүлчихдэг, хамгийн сүүлд шалгаруулсан тендер дээр хөөрхөн ажиллалхаад маадгархан явсныг нь санах. Сайд тэндээс хоёр тэрбум төгрөгийн ашиг хийж чадсаныг тэр мэднэ. Сайдын тамгыг атгаж суух, хаа нэг газар номер нэг хүн байхын утга учир энэ гэдгийг тэр үед Чинбат улам тод мэдэрч билээ. Барын сүүл байхаас батганын толгой байх нь дээр гэдэг...яахын аргагүй голт зүрхийг нь оноод хэлчихсэн үг юм даа. Ердөө хоёрхон сарын өмнө ид дөчөөд насандаа гялалзаж явсан

түүнийг өнөөдөр энэ ертөнцийн хэрэг явдалтай хэдийн данс дугуйлахын даваан дээр ирчихсэн, орлогч нь, төрийн нарийн бичиг нь бараг л эрлэгийн дансанд оруулчихаад суудлыг нь булаалдаж байдаг. Амьдрал хичнээн богинохон, хорвоо ямар хуурамч вэ гэдгийг сануулах мэт. Гэтэл түүнд барын толгой болох алтан боломж гэрэлтээд байдаг. Амьдралд алдаж болохгүй агшин гэж тохиодог. Сарын өмнөхөн гэхэд л сайдын суудлын тухайд мөрөөдөөд ч хэрэггүй байсан бол өнөөдөр... Амжих, бүхнийг амжуулах хэрэгтэй гэсэн бодол төрнө...

Наран хоёр хоногийн өмнө хамгийн дотны найз Номинтойгоо утсаар ярьснаас хойш ажилдаа очсонгүй. Менежер Батбаясгалан гэж “хачин юмны” утасдахаас ч залхаж байлаа. Өнөөх “загасаа” нэг мөсөн дэгээндээ оруулах хэрэгтэй байна гээд л авлагатай хүний нэхэл хатуу зангаар шаардаад байгаа юм, тэр. “Загас” нь мэдээж тэр нэгэн үдэш өвөр дээр нь тухлан, зангиагаар нь тоглон эхнэрийг нь уурлуулсан танихгүй эр. Наран дахин тийм захиалга биелүүлэн, чадахгүй шоглоомоор оролдох хүсэл байсангүй. Гэтэл Баясаад өгөх ёстой хэдхэн халтар ногоон л түүнийг ийм адгийн хэрэгт оролцоход, цаашид ч үргэлжлүүлэхэд хүргээд байдаг. Тэртээ тэргүй энэ шаарлагдсан амьдралаасаа жигшин ой гутаж явахад өөрт нь ямар ч гэм хийгээгүй бусдын амьдралыг үймүүлэх, өөрөө өөртөө улам улам ой гутах хэрэг юу билээ.

Удахгүй хуримаа хийх гээд аз жаргалаар бялхаж яваа Номинтой уулзах ч дургүй байлаа. Гэвч уулзана гээд амлачихсан, тэгээд ч өөрийнх нь гунигт амьдралд Номин ямар гэмтэй биш дээ. Урьд хааяа мөнгөтэй үедээ хоёулаа орох дуртай байсан “Виннерс”-дээ уулзъя хэмээн өчигдөрхөн утасдахад нь татгалзаж болсонгүй. Шөнө бүхэн нэг клубт очин анх сургуулиасаа гарчихаад замарч явахдаа танилцсан эрээвэр хураавар амьтастай бүжиглэж, ууж наргиж яваад үүр цайж байхад гэрийн бараа харж үд өнгөртөл унтаад толгой гэж хүүдийтэй элс мэт хүндэрчихсэн амьтан босч ирсээр нэлээд хэд хоночихжээ. “Эрдэмтэн” ээж, “доктор” дүү нь ч юм хэлэхээ больж, ашгүй. Хэлье гээд ч бараг тааралдахаа ч больсон юм чинь. Гэхдээ өөрөөс нь мэдээж залхаж л байгаа. Ялангуяа сарын өмнөхөн тэдний хөрш болсон хоёр хүүхэдтэй залуухан хүүхэн, за байз нэр нь хэн ч билээ. Аа, тийм, Энхтуяа гэсэн байх аа, өөрөө хаана ч гэлээ нэг төрийн байгууллагад ажилладаг, харин нөхөр нь Солонгос явахдаа байраа барьцаанд тавьснаас өрөнд ороод зарахаас аргагүй болж, тэдний энэ хуучин, ямбий тагзанд нүүж ирсэн тухай ээж нь ярьж байсныг санах. Тэр хүүхний тухай тэгж сайн мэдэж байгааг бодоход ээж нь аль хэдийн түүнтэй танилцаж амжаад энээ тэрээ болоод, хүүхдүүдээ боловсролтой болгохын чухлыг, өөрийнхөө эрдэм номын газар буянтай сайхан ажил хийдэг тухайгаа, за тэгээд хоёр охиноо “сайн хүн” болгох гэж хуруу хумсаа хуйхалж, ганцаараа зүтгэж яваагаа, Наран нь тэгтэл сургууль соёлоо хаяад хэрхэн “муу охин” болсон, бага охин нь ээжийнхээ заасан замаар хичнээн урамтай сайн яваа тухай хуучилчихсан нь ойлгомжтой. Тийм ээ, ээж нь өөрийнхөө ахархан ухааныхаа хэрээр л мачийсан, авдаг цалингийнхаа хэмжээгээр “хуруу хумсаа хуйхалж” байсан нь үнэн. Нөхөртөө хаягдсан зол муутай, ганц бие, хүний аяар дэндүү номой төрсөн ээжийгээ тэр өрөвдөхийн цаагуур өрөвдөн хайрладаг. Гэвч амьдралын хүчит урсгалын эсрэг ээж нь тэмцэж чадаагүй, хоёр охиндоо ч тэмцэх тэсвэр хатуужил ухаарал хайрлаагүй нь үнэн. Тиймдээ ч амьдралын үнэнд гүйцэгдсэнээ мэдэхгүй, Нарангийн төрсөн биеэ нүцгэлэн байж олж ирсэн мөнгөөр бага охинтойгоо хоёулаа гол зогоодгоо хүлээн зөвшөөрч зүрхлэхгүй, нэг л их шударга, цэвэр ариун хүний дүр эсгэн, хавь ойрынхондоо түүнийг муучлан сэтгэлээ хуурч яваа шүү дээ. Гэтэл Наран ч Саран ч хоёулаа элгэнээс нь унасан үрс нь. Хэрэв Наран өөрийнхөө амьдралыг золиослон тэр хоёрыг тэжээж

өдий хүрээгүй бол ээжийнх нь ганц бахархал болсон Сараа Анагаахын их сургуулийн сор оюутан болж, идэх талх, өдрийн хоолны хуушуур, хөл дүүжлэх автобусны мөнгөнөөс эхлээд хэний хүүхдээс ч дутахгүй өнгөлөг хувцастай нүүр бардам явах байсан юм уу? Хүн чанар гэж юу юм? Ээж нь түүнийг сургуулиа хаялаа, замаа алдлаа гэж нэгэнт өнгөрсөн дэмий балай юм үглэж, хүний өөрийн амьтанд муучилж суухын оронд “ээжийнхээ арчаагүйгээс охин минь ингэж явна, цаашдаа яана даа. Одоо дүү бид хоёрыгоо тэжээхийн оронд өөрийгөө бод” гээд ганц удаа үнэнийг хүлээн зөвшөөрч, хүний эхийн сэтгэл гаргасан бол сэтгэл нь тайтгарахсан.

Түмпэнд ус хийн толгойгоо угаагаад толинд харав. Бүсэлхий шүргэсэн урт хонгор үс нь намираад, будаг шунхгүй, үл мэдэг цонхийсон царайг нь аятайхнаар эмжиж, нүцгэн цээжин дээр нь ганц нэг дусал ус бөнжигнөн, хөх нь хараад баймаар аятайхан сэрийн хус мэт цасан цагаан цээж нь жихүүцсэндээ биржрүүтжээ. Ганц ч үрчлээ суугаагүй цэл залуу насыг нь илтгэх нүүрнийх нь цэвэрхэн арьс толийн, хагас нүцгэн бие нь нүд булаам цавцайн цайрч дундад зууны үеийн уран зургийн хүүхнүүд мэт. Гэвч өөрөө тэднээс арай туранхай юм аа. Дундад зууныхан одоог бодвол махлаг хүүхнүүдэд дуртай байж. Амьдрал цэцэглэх хорин нэгэн нас аа гэж. Харахад ч тэр үнэхээр цэцэглэж яваа, царайлаг, гоолигхон бүсгүй. Гэвч сэтгэл зүрх нь гэж дотуураа өмхөрч хоосон хөндий хэрэмний үүр болсон хөгшин хожуул шиг л болжээ. Хуучин үслэг халат олж нөмрөөд үсээ сэнсдэн хатааж, толины өмнө суун нямбайгаар нүүрээ будаж янзлаад хувцасны шүүгээгээ нээж хэсэг харж зогсов. Номинтой уулзахад юу өмсөх вэ? Хоёр жил ичгүүр, гутралаа худалдан байж олсон мөнгө нь удахгүй урагдаад алга болох хэдхэн хувцас төдийхнөөс хэтэрсэнгүй.

Номин насандаа тохируулж, чанартай бөгөөд даруухан хувцасладаг нь хаана ч өөрийнх нь хэн болохыг харуулж, залуусын хүндэтгэлийг хүлээж чаддаг сан. Өөрийнхөө өмсөх дуртай цайвардуу жийнс, ноолууран битүү захтай цамц, цэнхэр өдөн хүрэм өмсөөд толинд харвал дажгүй шүү. Яг л Номингийн зиндааны аятайхан оюутан охин шиг харагдаж байнаа. Чихнээсээ өөрийг нь эрээ цээргүй хөнгөмсөг харагдуулаад буй том цагираган ээмгээ мултлаад жижигхэн, нүдэнд өртөх төдий атал гэрэл ойлгон гялалзсан хатгадаг алтан ээмэг зүүгээд бэлэн болов. Гадаа гуравдугаар сарын сүүлч гэхэд хаврын урь орох болоогүй жихүүн, хаа очиж салхигүй тогтуухан байлаа. Байрных нь гадаа хоёр гурван хөгшин хэмхэрхий хуучин сандлын оронцог дээр суугаад “Энэ их хурал тарвал таарна. Аль ч нам гараад хэрэг алга” гэлцэн улс төржих нь дуулдана. Хотын төв хүртэл арав гаруй км-ийн зайг туулахын тулд үзэн яддаг микроавтобусандаа суух л болох нь. “Ба-аг-шийн дээд, Бот-ааник” хэмээн дотор арзганам муухай уянгалуулан хашгирах мөнгө хураагч туранхай залуу түүнийг автобусныхаа хамгийн мухарт чихээд суулгачихав. Мөнгө хураагч хашгичсаар, хиртэй хувцастай, эвгүй үнэр ханхлуулсан хүмүүсийг мах шиг дүүртэл нь чихэж аваад автобус хөдөллөө. Хотын төв хүртэл замын турш мөнгө хураагч чихэнд чийртэй хашгичсаар автобус огцом огцом хурдаа авч, сэгсчүүлэн донсолгосоор Наран элдвийг бодож ч амжсангүй. Хотын төвд буугаад сая нэг биеийн чилээгээ гарган цээж дүүрэн агаар амьсгалав. Хотын төв гэж. Алаг чулуу дэвссэн гудамж, таримал зүлэг, асфальтан зам, хүмүүсийн хувцас, царай зүс өнгөлөг, тэдний бараанк байшингийн эргэн тойрны шороон зам, яажгий модон хашаа, зэгэл сааралтсан хүмүүсээс шал өөр ертөнц.

Ойрд ороогүй кафений босгоор алхангуут тэртээд одсон өнгөрсөн үе эргэн ирэх мэт. Нөгөө л улаан бүтээлэгтэй цэмцгэр ширээнүүд, ёстой л сэхээтэн байрын цэмцгэрхэн

үйлчлүүлэгчид, хүрэн арьсан хавгастай хоолны цэс барьсан эелдэгхэн үйлчлэгчид, Номин тэр хоёрын суух дуртай булангийн ширээ... Наран эргээд мөрөөдөл, хүсэл дүүрэн хонгорхон оюутан охин болчих мэт санагдаад сэтгэл нь нэг л сонин уяхан дурсамжаар дүүрээд ирэв. Номин арай ирээгүй байлаа. Энэ үнэтэй кафенд тэр хоёр хааяа л нэг ордог, ихэнхдээ л найз нь даадаг байж билээ. Гэхдээ шалгалтаа өгч дууссан, эсвэл хэн нэгнийхээ төрсөн өдөр, бас Наран нэгдүгээр курсдээ сургуулийн шилдэг оюутан болоход гээд л дандаа баяр баясгалантай, өөдрөг дурсамжууд л энэ кафетай холбоотой билээ.

-Сайн байна уу? Хэдүүлээ явна? гэсээр үйлчлэгч залуу дөхөж ирлээ.

-Сайн байна уу? Хоёулаа.

Түүнийг ширээнд дөнгөж суунгуут Номин дуу шуу болсоор орж ирэв. Удаан уулзаагүй найзууд тэврэлдэн учрав. Ашгүй тэр найз залуугаа дагуулсангүй ганцаараа иржээ. Анх гурван хоногийн өмнө угсаар ярихад тэр хоёрын хооронд тороод байсан юм үгүй болжээ. Урьд нь мөрөөдөн ярилцдаг байснаараа Наран хуримынх нь хөтөлбөрийг зохиоход оролцох, цэцгэн хэлхээ, бөмбөлөг, чимэглэл, даашинз захиалах ажлыг хариуцахаар болов. Бусдын аз жаргалд баярлах гэдэг бас л сайхан юм гэдгийг Наран тэр мөчид сэхээрч, алдаж онон бүдчиж яваад нь өчүүхэн ч буруугүй найзаасаа дөлж, зугтан, улам ганцаардаж явсандаа харуусав. Тэр хоёрыг хоолныхоо дараа амттан захиалж байтал гаднаас сургуулийнх нь хоёр эмэгтэй багш ороод ирэв. Нэг нь Наранг их л дэмжиж санаа бодлыг нь ойлгодог байсан дунд хэрийн насны эмэгтэй багш байлаа. Нийгмийн сэтгэл зүй заадаг байл уу даа. Нөгөө нь ч түүнийг сургуулиа хаяагүй байхад лав хичээл зааж байгаагүй залуухан бүсгүй байлаа. Хоёр багш эмэгтэй тэр хоёртой толгой дохин мэндлээд танхимын нөгөө булан руу явчихлаа.

-Цасчимэг багш. Чи санаж байна уу?

-Аанхаан.

-Ёстой сайн багш. Чамайг дандаа асууж сурагладаг юм.

-Тийм үү?...

-Чи очиж уулзахгүй юм уу? Нээрээ нөхөр нь аль яаманд ч гэлээ дээ, төрийн нарийн бичгийн дарга ч бил үү том дарга болсон ш дээ. Гэхдээ Чимгээ багш нөгөө л даруухан хэвээрээ. Тэнхимийн эрхлэгч бол гэсэн чинь зөвшөөрөөгүй гэсэн.

Наран түүний яриаг бараг сонсох сөхөөгүй болсон байлаа. Цасчимэг, Цасчимэг багш... нөхөр нь төрийн нарийн бичгийн дарга гэнэ үү? Саяхан түүнтэй хаа нэгтээ тааралдсан шиг... Санаа бодлынхоо мухар бүрийг нэгжих мэт духаа атируулан бодолд орлоо. Хавь ойрд сургуулийн орчмоор яваагүй. Сургуулиа хаяснаас хойш бүтэн хоёр жил Чимгээ багштай уулзаагүйгээ тов тодхон санаж буй мөрт саяхан таарсан мэт санагдаад болж өгөхгүй байлаа.

-Нөхрийг нь Чинбат гэдэг юм. Манай аавын танил нь. Удахгүй сайд болж магадгүй гэсэн.

Сая л санав. Ой дурсамж нь түүнийг хуурсангүй. Нөгөө менежер Баясаагийн тэр нэгэн үдэш хүнтэй ярьж байсан яриаг халт сонссон нь тодроод ирэв. “Сайд болох санаатай юм биз дээ? Нөгөөх нь босдог л юм бол хүүхэн сонирхож л таараа” гэж байсан... Тэгээд л Наранг дуудаж “Тэр ногоон зангиатай хүний өвөр дээр очиж суу. Удахгүй авгай нь ирнэ. Тэр хүртэл босч болохгүй, сайн нялуурна шүү” гэж даалгасан. Дараа нь ... Эхнэр нь ирсэн. Олон өнгийн гэрэл дунд тэгээд тийм ч их ойртож ирээгүй болохоор тэр хүүхний царайг сайн харж чадаагүй билээ. Гэтэл бодоод байхад тэр хүүхэн Чимгээ багш байсан байх нь. Багшийнхаа нөхрийн өвөр дээр сууж, гарыг нь хөхөн дээрээ авчирч тавин, зангиагаар нь оролдон, хүзүүгээр нь тэврэн маяглаж байж. Чимгээ багш түүнийг таньчихсан юм биш байгаа. Бурхан минь. Яасан утгагүй амьдрал вэ? Царай нь цонхийн цайж, сандрах, бачимдах, бухимдахдаа тэгдгээрээ хоёр гарын алгаараа нүүрээ таглан, хуруунуудаа үсэндээ шигтгэж толгойгоо сэгчсин духайгаад явчихад нь гайхсан Номин:

-Хүүе чи яав аа? Нараа? хэмээн тохойноос нь татахад л сая сэхээ орж нэг сайн шүүрс алдан уужим амьсгаа авлаа.

-Зүгээр ээ. Энд бүгчим байна ш дээ.

-Сэрүүхэн л байгаа юм биш үү? Чи хүйтэн ус залгилах уу?

-Тэгье, тэгье. Уг нь тэр ус биш аятайхан улаан дарс л залгилж дотроо онгойлгомоор байлаа. Гутамшиг. Гутамшигт амьдралын намгаас гарах гарц байхгүй юм гэж үү? Сэтгэлдээ болж буй гутрал, бухимдлын галыг цээжин дотроо унтраагаад утааг нь амаараа гаргахгүй, юу ч болоогүй юм шиг царайлан жүжиглэхэд хүч чадал нь арай ядан хүрэлцэж байлаа...

Номинтой уулзсан өдрөө гэртээ ирээд тэр оройдоо Наран шинэ ажилд орохоор сэтгэл шулуудлаа. Гэвч байз, юу хийх билээ? Компьютерээр юм бичээд, бичиг баримт боловсруулаад байж чадах ч мэргэжлийн үнэмлэх, диплом гэж хүнд харуулчмаар юм байхгүй. Хадгаламжиндаа хэдэн төгрөгтэй шинэ амьдралд хөл тавих болж байгаа билээ? Бодохоос ч аймаар юм. Сараагийнхаа төрсөн өдрөөр онц сурч байгааг нь урамшуулаад өр тавин байж гар компьютер авч өгөөд бас хэдэн аятайхан хувцас авч өгснөөс хадгаламжаа хоосолж, одоо 200 мянга үлдсэн юм уу, үгүй юм уу.

Аз болж түүнд тийм бичиг цаасны ажил олдлоо гэж бодъё, цалин нь гэж хариугүй юм байх нь мэдээж. Таньдаг мэддэг хүн бүхнээсээ өөртөө тус болж магадгүй гэснийг шүүрдэн бодлоо. Өнөөдрийг хүртэл амьдарч, баярлаж, гуньж 21 хаврын цас ханзрахыг үзэхдээ туулсан амьдралынх нь хуудсууд ном юм гэвэл дэндүү нимгэхэн, уншаад үзье ч гэхнээ өлгөөд авах юм даанч үгүй гэмээр ядмагхан гэдгийг сая л ухаарлаа гэж үү?

Ээж, дүү хоёр нь ирээгүй л байв. Юм бодонгоо тэр хоёртоо сайхан хоол хийгээд тавьчихъя гэж шийдээд, дүүпүү хууран, банш чимхэж гарав. Түүний хийдэг ногоотой, банштай шөлөнд ээж нь нугасгүй. Сараа нь ч яахав, юу өгснийг нь л идчихдэг юм. Хоол ундандаа сайн, ходоод нь ч гэж хоолой давуулснаа л шингээдэг, дэрэн дээр толгой тавиут л нам унтдаг сайхан үе, арван найман насандаа яваа хүн.

Бодоод байхад Саран өөрөөс нь дөнгөж гуравхан насаар дүү атал өөрийгөө түүнээс

хэдэн арван насаар ахимаг мэт санаж, тэр чинээгээрээ дүүдээ санаа тавьдаг нь амьдралыг хичнээн олон оноор илүү элээсэн мэт бүсгүй хүний үзэх, үзэхгүйг амссаных, зулайг нь гишгэж төрсөн ганц дүүдээ тэр гашууныг амсуулахгүй сэн гэсэн өрөвч харам сэтгэл байдгийг хэн ч ойлгох юм билээ? Лав л ээж нь үүнийг ойлгохын чинээ ухаан суугаагүй хүн. Саран? Бүү мэд дээ. Хариу нэхсэн тусыг тусад бүү тооц гэдэг. Төрсөн ганц дүүдээ өөр шигээ гутамшиг амсуулалгүй амьдралын захтай золгуулчихад сэтгэлд ч сайхан шүү дээ. Нээрээ л Сараа нь маргааш шүүлэг, нөгөөдөр дадлагын ажилтай гээд өдөр шөнөгүй номоо шагайж суухаас биш амьдрал гэдэг хичнээн гашуун, хүн гэдэг ямар өөдгүй байдгийг гадарлах ч үгүй амьтан. Дэндүү гэнэн, дэндүү нялхаараа. Гурилдаа өндөг холин зуураад махаа татаж тавиад бүсгүй зурагтаа асаан хуучин буйдан дээрээ суулаа. Оройн 19 цагийн мэдээ эхэлж байлаа. Нэгэн сайд нас барж эмгэнэлийн мэдээ хөвөрч байлаа. Суваг солиод ч нэмэргүй “Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, төрийн зүтгэлтэн, эх оронч... Таны хөдөлмөрч, дайчин, хичээнгүй, алсын хараатай, тусч нөхөрсөг занг үүрд дурсана...” Худлаа, шал худлаа үгс. Өнөөдөр нэг нь амьсгаа хураан энэ ертөнцийн амьдралтай данс дугуйлж байхад хэсэг ингэж худлаа магтаж байгаад л маргааш нь хүмүүс цуглаж оршуулчихаад, эсвэл занданшуулж үнс болгоод л нөгөөдөр гэхэд тийм хүн ор тас байгаагүй юм шиг таг мартдаг шүү дээ. Үүрд дурсана гэнэ шүү. Маргаашнаас эхлээд л тэр талийгчийн оронд хэнийг сайдаар томилох вэ? гээд бичээд яриад л эхэлнэ, тэгээд мэдээж хөөрхийг оршуулаад удаагүй байхад л их хурал дээр хэрэлдэж эхлэх нь мэдээж юм чинь. Хүүе байз. Өнөөдрийн тааралддаг Цасчимэг багшийн нөхөр нь сайд болж магад гэж Номин ярьсан, бас Баясаа тэгж байсан нь энэ хүний оронд сайд болох тухай яриа байсан юм биш үү? Сайдын сандал гэдэг чинь өөрөө онгойгоод сулраад ирдэг ч юм биш. “Удтал хүндээр өвчилж байгаад” гэж байсан шүү дээ. Уржигдраас хойш тэр ажилдаа очоогүй. Утсаа салгачихаад яваад байсан болохоос тэр муу Баясаа залгасан л байж таараа. Энэ бодлоосоо цочин цонх руугаа харлаа. Хажуу айлынх нь шинэ хөрш бүсгүй хоёр жаахан хүүгээ хөтлөн, шар ууттай идэх юм барьсаар байр руу орж яваа харагдана. Бас л нэг ядарсан бүсгүй. Хүний эхнэр байхын сайхан нь юу юм бэ? Мэдэхгүй. Өдөржин ажил хийгээд, дараа нь дэлгүүр хэсч хүнс цуглуулна, хүүхдээ цэцэрлэгээс авна, нөгөө махны машин шиг микрод сууж чихэлдэн цаг шахуу давхисаар энд, газрын мухарт байх умгар нүхэндээ ирж байгаа нь энэ. Гэртээ ороод хүүхдүүдийн чих дөжрөм дуу шуугианд хоолоо хийгээд шөнө дөлөөр л нэг юм дэрэн дээр толгой тавина. Маргааш нь хар эрт босоод хүүхдүүдээ чирээд гарна. Аймаар юм. Чөтгөрийн тойрог гэдэг шиг. Яг л тээрэмд хөллөсөн илжиг шиг аймшигт амьдрал. Наран хөршийн үл таних бүсгүйг орц руу ортол харж байгаад зурагтаа унтраагаад босч ногоогоо хуурч, шөлөө хийлээ. Хоол хийж байхад бүх анхаарлаа гагцхүү хоолоо амттай болгоход л зориулах тул элдвийг бодох чөлөө тархинд олддоггүй нь сайхан. Таван халуун, хуурсан сармисны хорхой хүргэм сайхан үнэр өрөөгөөр түгээн буцалж буй шөл рүү банш хийж байхад ээж нь, удалгүй Сараа нь ирэв.

-Хүүеэ, миний охин ямар сайхан хоол хийгээ вэ?

-...

-Дүү нь ирээгүй юу?

-Ирж яваа байх аа.

-Ээж нь талх аваад...

-За, за. Өө, та чинь юу гэж цагаан талх авдаг юм бэ? Хар талх авч бай, биенд сайн гээд байхад...

-Идэж сураагүй болохоор цээж хорсоод байх юм аа.

-Таны цусанд сахар ихдээд гэсэн биз дээ? Цагаан талх битгий идэж бай гээд байхад...

Хаалганд түлхүүр эргүүлэх чимээ гарч Сараа өөрийнхөө түлхүүрээр онгойлгон ороод ирэв.

-Ямар гоё үнэр гараад байнаа? Ашгүй ажаа та хоол хийж байгаа юм уу? Ээж ямар тан шиг гоё хоол хийх биш. Нүд нь гялалзан, гартаа компьютерээ барьсан дүү нь залуу, нас, гоо сайхан, гэнэн томоогүйн биелэл мэт.

-Үгүй ер, дуугүй л миний хийснийг идчихдэг юм. Цаанаа голдог байх нээ гээд ээж нь Сарангийн духан дээр үнэрлэнэ.

Наран хормогчоо тайлан ээждээ өгөөд нөгөө өрөө рүүгээ орлоо. Ээж нь гэж энэ амьдралдаа гутаж гуныж байгаа шинж огт алга... Ядаж л хоол муу хийдэг гэж бага охиндоо гологдож байгаадаа ч юм санаж болно доо. Онгорхойн дотор уужим гэдэг л энэ юм даа. Нэг бодлын гутаж гуниад байхгүй нь ч өөрт нь дээр юм уу даа. Жаргал гээчийг, ханийн халамж, нөмөр гэдгийг үзсэн ч биш. Дөчин таван нас гэдэг уруудах, улирлаар бол намар л гэсэн үг. Хөөрхий ээж нь ингээд жаргаж үзсэнгүй өтлөх нь. Хүний амьдрал гэдэг хэмжээтэй. Сэтгэлд нь саяын сайдын эмгэнэлийн ая эгшиглээд болохгүй байв. Өөрөө өнөөдөр дөнгөж хорин нэг хүрч яваа, толинд харж шүүрдээд ч нүүрэнд нь ганц үрчлээ үл олдох, өтгөн сайхан үс намруулсан залуухан бүсгүй байгаа нь сайхан ч хорин жил өнгөрөхөд л ээж шигээ болно. Бүсгүй орон дээрээ сандайлахад сэтгэл нь өгүүлшгүй гунигт автан хөндүүрлэж байлаа. Цаад өрөөнд ээж дүү хоёр нь ойр зуурын юм ярилцан инээлдэх дуулдана.

Тэдний байранд гал тогооны тусдаа өрөө гэж байдаггүй, дамждаг хоёр хавчиг өрөөтэй. Үүдний өрөө нь зочны ч, гал тогооны ч, хоолны ч, хичээл ном давтах ажлын өрөө ч болно. Наранг ухаан орохын л тэднийх энэ байранд амьдарч байсан. Аавын тухай бүүр түүрхэн нэг дурсамж байдаг нь хаалганы хажуугийн хулдаасан бүтээлэгтэй хуучин модон ширээнд суугаад “Би явлаа. Та гурав учраа олно биз. Би хүүтэй болсон” гэж байхад ээж нь ойндоо хүрч яваа Сарааг тэврээд өөдөөс нь харан уйлж суусан санагддаг юм. Тэгэхэд өөрөө хэдий нялх балчир байсан ч тэр өдрийг огт мартаж чаддаггүй, хожим өнөөх ширээг харах бүрт сэтгэл хөндүүрлэсээр гаргаад хаячихъя гэхээр ээжид нь шинэ ширээ авах битгий хэл заримдаа хоногийн хоолоо дийлэхгүй байх ч үе бишгүй байсан сан.

Сүүлд нь Наран аравдугаар ангид орох жилээ бааранд зөөгч хийж авсан анхны цалингаараа захаас шив шинэ ширээ авч, гунигт дурсамж хадгалсан тэр хуучин ширээг гаргаж хаян санаа амарч билээ. Хэдийгээр өөрөө ажил хийж олсон тэр хэдхэн төгрөгөөрөө шинэ гоё сандаал авч өмсмөөр байсан ч шүдээ зууж байгаад ширээ авч байсан сан. Аав ... гэхээр өш хорсол гомдол цээжинд зангирч өөрөөсөө илүү дүүгээ өрөвдөхийн цаагуур өрөвдөнө. Саран эрэгтэй гарсан бол аав чинь явахгүй байсан гэж тавдугаар ангид байхад нь нэг удаа ээж нь ярьсан юм. Дараа нь уран зохиолын хичээл дээр “Гологдсон хүүхэн” гэж тууж

үзээд “Дүү бид хоёр гологдсон хүүхнүүд юм байна” гэж бодож билээ. Аав нь тэр гурвыг хаяад явдаг тэр өдөр Сараа нь хөхөл үсээ орой дээрээ согсойлгон боосон, хацар нь цулцайгаад мяраалчихсан, ээжийнхээ өвөр дээрээс аавдаа очих гэж тэмүүлэн дэгэж, дэрвэсэн ямар өхөөрдөм амьтан байлаа даа. Өөрийг нь голоод хаяж байгааг мэдэхгүй аавдаа очих гээд гараа сарвайн тэмүүлж, харин ээж нь нулимсаа зоргоор нь тавин асгаруулж байж билээ. Энэ дүр зургийг мартахын аргагүй. Сараа нь жаахандаа мөн ч олон удаа хүүхдэд шоглуулан уйлахдаа “Аав аа! Намайг ирээд аваач ээ” хэмээн бархирч, хоёр бяцхан охин хичнээн ч удаа айлын хүүхдүүдэд “Аавгүй амьтад, та хоёр аавгүй юм чинь” хэмээн адлуулж өслөө дөө. Эхлээд аав нь, дараа нь анхны хайрын эзэн нь түүнийг голсон. Эрчүүдэд гологдсон азгүй хувь заяа. Ээж, дүү хоёроосоо холхон шиг бодолд дарагдан алсдаа яаж амьдрахаа бодож сууна гэдэг... 21 настай бүсгүйн мөрөн дээр дэндүү хүндэдсэн ачаа юм уу лаа.

-Өвчин нь хагалгааны дараа эдгэрэх болов уу?

-Би амьдармаар байна. Би үхмээргүй байна!

Ээж нь бас л ээлжит солонгос “савангийн дууриа” үзэж эхлэв бололтой. Бас л эдгэршгүй өвчин, төөрч одсон ах дүү нар, баян ядуу айлын хүүхдүүдийн дурлалын зовлонт түүх, ээжийнх шиг нь өр зөөлөн, алсын юм бодох дургүй атархан тархинд зориулсан хямдхан бүтээл биз. Наран орон дээрээсээ өндийн нөгөө өрөө рүүгээ шагайгаад :

-Алив наад тэнэг киногоо дуугий нь намсгаач. Чихэн дээр л “хагалгаа магалгаа” гээд л хашгичуулчих юм. Наад Сараагаа ядаж хичээлийг нь тайван уншуулбал яасан юм? хэмээн уцаартайхан хэлчихээд гэнэт ээжийгээ дотроо өрөвдөж:

-Ээж минь ийм киногоор яадгийм дээ гэж зөөлхөн хэлээд өрөө рүүгээ орлоо.

За байз, зар уншихаар маркетингийн менежерийн ажил их байдаг юм билээ. Намайг дипломгүй л гэх байх даа. Уг нь оюутан байхдаа хэрэгт дурлаад маркетингийн ном уншиж л байсан. Амархан л юм билээ. Гол нь сэтгэлгээ чухал. Англи хэл гэвэл ойр зуур ярьчихна. Номингийн аавыг гуйвал ажил олдох юм биш байгаа. Унтраагаад тавьчихсан утсаа аван асаалаа. Баясаа мэтийн элдвийн юмнуудаас болгоомжлоод л унтраачихсан хэрэг.

Саяхан авсан дараа төлбөрт дугаар. Нэгж дуусахын зовлонгүй сайхан л юм. Гэвч ингээд ажил төрөлгүй, цалин мөнгөгүй болчихвол хоол нэхдэг нэг ам л гэсэн үг.

Номингийн утас яриад байв. Бодвол хэдхэн хоногийн дараа нэг гэрт орох гэж байгаа мөрт нялуураад л Барсаатайгаа ярьж байгаа биз. Тэр хоёрыг шоолон инээмсэглэв. Цээж дотрыг чулуу мэт дарсан хүнд бодол нь түр ч гэсэн мартагдан ухаан санаа цэлмэх шиг.

Гэнэт утас нь чичирхийлэн дүнгэнэхэд хяламхийн харах зуур зүрх нь түгшүүрлэн цохилгов. Дугааргүй утаснаас залгаж байна. Гарцаагүй Баясаа. Цаад өрөөнд ээж нь түүний хийсэн хоолыг аягалан:

-Нараа хоолоо идээрэй, миний хүү гэх нь сэтгэлийн түгшүүрийг улам нэмнэ. Хэрэв утсаа авахгүй бол гэрийг нь мэдэх юм чинь хүрээд ирж ч мэднэ. Түүн шиг хорт могойноос

амархан сална гэж найдалтгүй. Ээж, дүү хоёроо л айлгахын нэмэр. Тэд өөрөөс нь болж зовох ёсгүй. Үгүй шүү.

-За...Нараа байна.

-Хатагтай утсаа салгаад, ажлаа таслаад нэг л өдөр надаас зугтчихъя гэж найдаагүй биз дээ? Хэн ч арьснаасаа мултарч чаддаггүй юм мэдээ?

-Би маргааш мөнгий чинь олоод өгье. Ээжийн бие муу.

-Битгий худлаа хэл. Ээж чинь ажил дээрээ эрүүл саруул инээгээд явж байна лээ. Нөгөө даалгавар яасан бэ? Аятайхан аашлаад байхад аягүй зан гаргавал яриа байгаа шүү, хонгор минь.

-...

“Хонгор минь” гэхээрээ түүний муу зан хөдөлдөг юм. Хэрэв дэргэд нь байсан бол Баясаа түүний эрүүнээс нь өргөөд үнэтэй ус сэнгэнүүлэн нүд рүү нь зэвүүн ширтэж байгаад дарамтлах байсан даа...

Наран бөөн бодолд орлоо. Ийм хүнд хэцүү үед нь ярьж зөвлөчихмөөр, өмөг түшигт нь хоргодчихмоор хүн түүнд ганц ч байхгүй ажээ. Ангийнх нь хөвгүүдээс хичээлээ хамт давтан хүүхэд зангаар үерхэж найзалж явсан хамгийн дотны хоёр л найз байсан. Хүрлээ нь японд сурахаар одож, Баатарзориг санаандгүй зодооны хэргээр яллагдаад одоо хаа байсан Мөнгөнморьтод бий. Хэрэв Зоригоо хэрэгт холбогдоогүй сэн бол ганц утасдахад л хүрээд ирэх байсан. Энгийн найзуудын ёсоор үерхэж байсан ч Нарантай уулзахаараа сэм сэмхэн шүүрс алдан, өөрийг нь харуулдан байрных нь гадуур эргэлдэж, төрсөн өдрөөр нь хамгийн түрүүнд баяр хүргэж, цэцэг авчирч өгдөг байсан түүнийг тоогоогүй нь алдаа ч байж уу? гэсэн бодол үе үе орж ирэн хар багын найзаа өрөвддөг юм. Өөртэй нь адилхан эцэгтээ гологдсон, ээж нь группт байдаг амьдрал нь өдөр хоногоо өнгөрөөж ядсан тийм л хүү байсан. Өндөр нуруутай, өрөвч зөөлөн сэтгэлтэй, нүдэнд дулаахан, тэгээд ямар ч хичээлийг ганц уншаад л самбарын өмнө гарч асуугдаад А авчихдаг тийм л хэмжээний толгойтой тэр хөвгүүний сэтгэлийг Наран хүлээж аваагүй юм. Хэдийгээр Зоригоо түүнд таалагддаг ч хоёр ядарсан амьдралтай амьтан бие биедээ гай болоод яахав, аль аль нь боломжийн айлын хүүхэдтэй суусан нь дээр гэсэн бодлоор нүүр өгдөггүй байжээ. Гэтэл арваа төгсөөд Зоригоо Хүмүүнлэгийн их сургуульд тэнцсэн мөртөө алтны компанид жолоочийн ажилд орж, бүр Сэлэнгэ рүү яваад өгч билээ. “Энд байхаар өдөр бүр Нараатай тааралдаад хэцүү юм. Тэгээд ч сургалтын төлбөрт өгөх мөнгө алга. Ээж дүү хоёроо ч тэжээ” гэж Хүрлээд ярьсан байсан сан. Харин Наран их сургуульд орж, бодож байснаараа боломжийн амьдралтай Хангалтай үерхэх болж, хөтлөлцөөд гүйж явахдаа нэг хэсэг Зоригоог мартсан нь үнээн. Гэтэл тэр Хангал нь түүнд хичнээн хуншгүй зан гаргалаа даа. Аяа яа тэр тухай бодож доошоо ороод ч яахав. Одоо бодоод байхад зан зангаа мэдэх, хэн хэндээ дээрэлхээд байх юмгүй багын найз Зоригоотойгоо л үерхэж байсан бол хамтдаа сайхан амьдрал босгох ч байсан юм бил үү? Хэн мэдлээ. Аавтай сан бол... эцгийн нөмөр нөөлгийг өөрийн эрхгүй үгүйлэх энэхэн мөчид хүчээр зүрх сэтгэлээ чангалан энэ бодлоо бас л үргээв. Баясаа өөрийг нь нэг их татаж чангаахгүй. Түүнтэй нэг хөнжилд орлоо гээд Наранд алдаад байх ч юм үгүй гэдгийг

мэдэхийн цаагуур мэдэж буй. Харин эвгүйдвэл дүүг нь, түүний нүдний цөцгий шигээ хайрлаж, өөрийнхөө энэ бохир жимээр оруулахгүйн тулд юуг ч тэвчихэд бэлэн байдаг Сарааг нь барьцаалж мэдэх л өөдгүй этгээд. Юуны түрүүнд Сарааг энэ нүхнээс хэсэгтээ л холдуулах хэрэгтэй. Үерхдэг банди нь Билгүүн гэж өөртэй нь таарсан сөөсгөр юм байдаг. Тэднийдээ ч байсан яахав. Манайхыг бодвол байр шиг байранд суудаг, аав нь гайгүй төрийн алба хашдаг томоотой хүн бий. Харин ээж нь гэж эмчийн ажилтай сэмбэгэр авгай тэдний ядмагхан амьдралтайг гадарлачихаад янзгүйхэн царайлдаг ч хүү, нөхөр хоёроо бодоод юм хэлдэггүй юм.

Ээж нь? Ээжийг нь Баясаа тоож авч хэлэлцэхгүй ээ. Тэгвэл өөрөө? Тав таван зуугаар нь хоёр удаа зээлдчихсэн мянган долларыг нь хаанаас олж өгөх билээ? Хадгаламжаа шавхаад шавхаад хоёр зуу ч хүрэхгүй шүү дээ. Тиймхэн мөнгөөр барьцаалагдчих гэж дээ. Ямар ч гэсэн багшийнхаа нөхрийг өвөртөө оруулж, насан туршийн шившиг, сэтгэлийн гэмшил, гутралд яасан ч унахгүй. Тэгээд цаанаа албан тушаалын өрсөлдөөн, өш хонзонгийн төлөөх бохир тоглоомд хүүхэлдэй болж оролцох гэж үү? Үгүй шүү. Алдаж хазгай гишгэж, амьдралын намаг шалбаагнаас хөлөө татаж авч чадахгүй, тийм боломж ч олдохгүй яваа нь үнэн ч гэсэн хэнээс ч дутахааргүй бодож бясалгах тархи толгой, ухаарч ойлгох оюун ухааныг бурхан түүнд заяасан юм. Цасчимэг багш... Түүнтэй л уулзаж үнэнээ хэлдэг хэрэг. Харин одоо... Ээжид мэдэгдэлгүйгээр дүүгээ найзынх руу нь явуулна. Сараа ухаантай охин ойлгоно.

-Сараа миний дүү нааш ир.

-За.

Дүү нь уншиж байсан номоо сугавчилсаар асуусан харцаар дүрлийн орж ирэв.

-Ямар хичээлээ уншиж байгаа юм?

-Органик хими.

-Миний дүү мундаг шүү.

-...

Сараа нь түүний орны хажууд багынхаа хуучин модон сандал дээр сандайлаад нүүр рүү нь асуусан, болгоомжилсон харцаар ширтэн доод уруулаа хазалж сууна. Улаан будагтай байгаад халцарч элэгдэн ямар өнгөтэй нь ч мэдэгдэхгүй, улам намхан болсон энэ сандлыг өвөө нь Наранг хоёр настайд гараа гарган хийж өгсөн болохоор тэр хоёр хайртай байдаг юм.

Наран хана налан сууж байснаа өндийж цэхрээд дүүгийнхээ богинохон тайралттай гялгар үсийг илснээ:

-Эгч нь ажлаасаа гарсан. Гэтэл манай менежер гээд өөдгүй амьтан утасдаад янз бүр болоод байна. Тэхээр миний дүү хэд хоног Билгүүний эмээгийн д ч юм уу очоод байж байвал аюулгүй. За юу?

-За...

-Одоо орой болчихож. Маргааш хичээлдээ явахдаа ойр зуурын юмаа аваад яв. За юу?

-За, за. Та тэгээд өөр ажилд орох юм уу, эсвэл сургуульдаа буцаад орох гэж байгаа юм уу? гэж асуухдаа дүү нь цаанаа түүнийг тайчдаг, нүцгэлдэг ажлаасаа гараад хүн шиг амьдралд хөл тавих нь гэсэн найдлага тээсэн харцаар харж байлаа. Томоогүй ч амьтан бол доо. Тийм ажил хийж байгаагийн хүчинд л гурвуулаа мөр нүцгэрч, хоосон хонохгүй амьдарч байгаагаа мэдэхгүй, ичиж зовдог хэвээрээ байх нь.

-Тэр яахав. Чи л хэд хоног энд битгий үзэгдэж үз.

-Билгүүнд юу гэж хэлэхэв?

-Манайд хөдөөний хүн хэд хонох гээд. Хичээл давгаж болохгүй байна гэхгүй юу.

-За.

-Одоо явж аягаа угаахад нь ээжид тусал.

Дүүгээ нөгөө өрөөнд ороход нь сая сэтгэл уужран санаа алдав. Баясаа бол гаднаа хүйтэн инээд наадуулж, сайхан царйлж байгаад тэдэн шиг ядарсан улсуудаар хөнгөхөөн тоглоод хаячих, дүү шиг нь өчнөөн аятайхан жаахан охиныг янз бүрийн аргаар айлгаж, сүрдүүлж, хуурч мэхэлж байгаад элдвийн үл бүтэх этгээдүүдийн өвөрт шургуулж орхиод ашиг хонжоо олоод авчих хэмжээний муу аргандаа гаргуун амьтан. Ээж шиг нь ганц бие ядарсан авгайг авч хэлэлцэх ч үгүй.

Наран тэр орой унтахын өмнө Номингоос Цасчимэг багшийнхаа утсыг аваад орондоо оржээ. Сэтгэл нь давчдан салхивчаа нээхэд нүүрсний гашуун утаа орж ирж хоолой хорсгоод, хажуу айлынх нь бяцхан хүү “Аав аа!” хэмээн чарлахад ээж нь аргадан сандчиж байгаа нь нимгэн хананы цаанаас нэвт дуулдаж, хүний өөрийн сэтгэлийн зовлонд зүрх шимширнэ. Хорвоогийн нэг өдрийн төгсгөл, маргаашийг авчрахаар хором хормоор өнгөрөн одож, утаатай бараан тэнгэрт одод бүдэгхэн гялалзаж байлаа.

Өглөө бүсгүй нь урьдынх шигээ санаа амар унтаад байж чадсангүй. Дөнгөж зургаа өнгөрч байхад сэрчихлээ. Хажуу дахь орон дээр Сараа нь ойн чөлөөний бутан доор нойрсож буй гэнэхэн янзага, хуурай дулаан өлгийндөө үнэгчлэх нялхаст л байдаг бөх нойронд автан нам унтаж байгааг хараад атаархах, өрөвдөх сэтгэл зэрэгцэнэ.

Цонхонд татаастай хуучин хөшигний сиймхийгээр өглөөний тунгалаг гэгээ шургалан, гадаа хүн ярилцах, хаа нэг машин сүнгэнэн өнгөрөх нь дуулдана. Эргээд хэсэг дугхийе гэж хичээсэн ч нойр нь нэгэнт хулжин оджээ. Босч хонгилд байдаг нийтийн бие засах газар руу очих гэснээ ээжийгээ чимх нойр аваг гэж бодоод түдгэлзэв. Удалгүй ээж нь сэрж байгаа бололтой нөгөө өрөөнд байдаг хуучин буйдан хяхтнан данх сав хангинаж эхлэхэд бүсгүй сая нэг юм орноосоо босч хөшсөн биеийнхээ чилээг гарган суниахдаа унтраастай гар утас руугаа сэтгэл түгшин хяламхийж байлаа.

Ээж дүү хоёр нь ажил сургуульдаа яаран цай унд энээ тэрээ болж байснаа гарч одооцгоосон хойно Наран үс гэзгээ цуглуулан боож, Номинтой уулзахад өмссөн шигээ даруухан хувцаслаад цаг харвал дөнгөж арав л өнгөрч байлаа.

“Одоо Цасчимэг багш мэдээж хичээлтэй байгаа. Эртүүд Номинтой “Виннерс“-т сууж байхад намайг сайн танихгүй байсан. Арга ч үгүй дээ. Манайд ганцхан улирал лекц уншсан юм чинь. Гэхдээ миний хойноос хамгийн их сэтгэл тавьж, нэхэл дагал болж, хүүхдүүдээс асууж, сураглаж байдаг гэсэн. Би улстөр судлалын 3-ын Наран байнаа гээд очиход таньж л таарна. Тэгээд юу гэж хэлэх вэ? Ёстой жинхэнэ холион бантан. Түүнээс өөр жирийн нэгэн дундаж эмэгтэй бол ийм юмыг ойлгох ч үгүй. Харин Цасчимэг багш бол өөр хүн. Атаа жөтөө, хов, жив, явуургүй залианаас ангид ховорхон эмэгтэй. Жинхэнэ сэхээтэн хүн юм чинь ойлгоно“. Нарангийн богинохон амьдралд тааралдаж, сэтгэлд нь хүндтэй байр эзэлсэн цөөхөн сайн хүмүүсийн нэг нь Цасчимэг багш нь билээ.

Наран бүсгүйг хүнд байдалд орчихсон байх тэр үеэр Чинбат Германаас ирснээс хойш туйлын хүнд долоон хоногийн ард гараад байлаа. Бурхан хүн бүхэнд таарсан зовлонг оноодог хойно. Сайдын оршуулганаас хойш гурав л хонож байв. Өнөөх багын найз Пандагатайгаа өнөөдөр заавал цаг гарган уулзаж олон нууцын учгийг тайлах мэдээлэл авах хэрэгтэй байлаа. Гэр орны доторхи хөндий хүйтэн уур амьсгал гавьтай дулаарсангүй нь их ажлын хажуугаар сэтгэлийн хямрал нэмнэ. Чимгээгийн тухай, авааль гэргийнхээ тухай бодохгүй байх нь амар мэт боловч уураг тархины нэг талд ургасан бэрсүү мэт, сэтгэл зүрхний гүнд бөх бат оршсон хамаг нандин бүхэн нь тэр л бүсгүйтэй нэгэн амин учгаар холбоотой, түүнийг энэ насанд яавч үл тасалж болох ажээ. Сайдын оршуулгатай өдрийг эс тооцвол тэр гэргийтэйгээ бараг үгийн солиогүй нэгэн дээвэр доор толгой хоргодож буйгаас хэтрэхгүй л хүйтэн зэвэр харилцаатай, хэн хэнтэйгээ тааралдахаас ч зайлсхийсээр энэ хэдэн хоногийг үдэж байв.

“-Чамд сэтгэл гэж байдгийм уу? Тэр баарны хүүхнүүддээ новш авчрахгүй юу!“ гэсэн үг нь бодогдоод Германаас Чимгээд юу ч авмааргүй байсан ч тэсэлгүй цагаан алтан цаг худалдан авч чемодандаа нандигнан далд хийснийгээ ирсэн өдрөө гарган эхнэрийнхээ гоёлын ширээний нүдэнд хийсэн билээ. Гэтэл өөрт нь уурласан уур гарах нь бүү хэл зориуд Монголд ирэх өдөр нь семинартай хэмээн уулын аманд очиж хэвтчихээд, хөлдүү бууз хөргөгчиндөө хийж тавьснаар барахгүй энэ хэдэн хоногт дуугаа хураан эр нөхөртэйгээ нүүр тулахаас зугтсаар байдаг. Өчигдөр нэгэн өдөр тутмын сонины эрхлэгч намынхаа нөхөртэй уулзаад шөнийн хоёр цагт арай гэж нэг юм гэрийн бараа харахад нь мэдээж хэрэг эхнэр, хүү хоёр нь нам унтаж байсан. Хүүтэйгээ ч уулзахгүй хүний хүн мэт яваадаа дотроо гэмшсээр өрөө рүү нь шагайтал хүү “Аав уу?“ гээд өндийгөөд ирсэн.

-Миний хүү унт даа. Эцэг эхийн хурал энэ тэртэй бол хэлээрэй гээд духан дээр нь үнэрлэхэд нойрмог нүдэлсэн хүү нь нүдээ нухалснаа эргэн хэвтээд:

-Та ямар сургууль дээр очих биш дээ. Ажлаа л бод гэж хэвлүүхэн гэгч нь хэлснээ эргээд унтчихаж билээ. Харин унтлагын өрөө рүүгээ ороход нь Цасчимэг хөдөлсөн ч үгүй таг чиг хэвтсээр байжээ.

Дөнгөж арван нэгтэй хүүхэд аавыгаа ирэхэд зөнгөөрөө мэдээд сэрж байхад эхнэр нь тэгэхээс тэгэх шиг таг унтаж буй дүр үзүүлж байсан нь мэдээж. Тэр эхнэрээ зориуд өөрийг нь

ирэхийг үл мэдэгчин царайлж буйг нь гадарласан ч сурсан зангаараа чимээ гаргахгүй санаатай гэрийн шаахай ч өмсөлгүй өлмий дээрээ алхлан хувцасны шүүгээ рүү очин пиджакаа өлгөөд хаалгыг нь аяархан хаан эргэхдээ эхнэрийнхээ гоёлын ширээний нүдийг өөрийн эрхгүй татаж үзсэн билээ. Гэтэл мөнгөн тууз, хөх ягаан цаасаар чимэглэж боосон хөх хилэн хайрцаг тэр чигээрээ хэний ч гар хүрээгүй нь илт байж байв. Өнөөх бэлгийг эхнэр нь авсангүй. Нөхөртэйгээ эвлэрэхийг огт хүсэхгүй тас зөрүүдэлж байгаа байх нь. Хэрүүлээ үнэтэй бэлгээр цайруулах гэлээ гэж Чимгээ хориг тавьж байгаа нь тэр. Өөр өөрийн гэсэн бодолтой, өөр өөрийн хувь тавилантай хүн л юм хойно эхнэр, нөхөр хоёр хэрэлдэж, ам мурийлгүй яах юм бэ? Энэ нь бие биенээ гэсэн халуун сэтгэлийг нь хөргөх тэсрэх бөмбөг биш шүү дээ. Ингэхэд Цасчимэг яагаад эр нөхрөө ойлгохыг үл хүснэ вэ? Эмэгтэй хүн чинь юманд уян хатан ханддаг биш үү? Юунд гэр орноо гэсээр шургаж унатлаа гүйж, амьдралын төлөө л үхэн хатан явааг нь үл мэдэгч царайлна вэ? Эрх мэдлийн төлөө бүхнээ худалдлаа гэж өөрийг нь тэр буруутгадгийг мэднэ. Юуны тулд эрх мэдэлд шунаж байгаа гээч. Гэр бүлийнхээ төлөө, үр хүүхдийнхээ төлөө, нарийндаа бол Цасчимэгийн төлөө л ингэж яваа ганцхан зорилготойг эхнэр нь ойлгоё гэвэл ойлгоно шүү дээ. Гагцхүү хүсэхгүй байгаа учраас л түүнийг ингэж дотроос нь мэрж байгаа юм.

Тэр гэрийн хувцсаа өмсөөд ажлын өрөөндөө орж охиндоо мэйл бичих гэснээ больж, ажлын өмдтэй, хөл нүцгэн чигээрээ зочны өрөө рүүгээ алхсан. Тэгээд ханын тавилганых нь зүүн хэсэгт байдаг бяцхан баарнаас болор савгай шарз архи авч мөс ч холилгүй нэг татаад удтал буйдан дээрээ сууж билээ. Тэр л мөчид амьдрал нь огтын утгагүй санагдсан. Эцсийн эцэст юуны төлөө тэр ингэж нойр хоолгүй зүтгээ вэ? Бусадтай адилхан нууц амраг энэ тэрд ил далд мөнгөө зөөж гүйдэггүй, хурдан морь мал гэж сонирхдоггүй, хөзөр биллиард эргүүлдэггүй, гэргийгээ, охиноо, хүүгээ, бүүр хадмаа гэж үхэн хатан явсаар хүртэж байгаа шан нь энэ юм байна. Эртүүд хар өглөөгүүр гэрээсээ өөр газар залуу бүсгүйтэй хоноод гарч явахдаа орцных нь үүдэнд улаан халз тулсан Алтансүх шиг хоёр эхнэртэй бол Чимгээ яах байсан бол? Аягүй бол Алтансүхийн авгай шиг мэдсэн ч мэдээгүй царайлаад явах байсан даа. Үнэн хэрэгтээ түүнд эхнэрээ араар нь тавья гэвэл алхам тутамд боломж таардаг шүү дээ.

Герман явахын өмнө Чимгээтэй хэрэлдэх шалтаг болсон тэр цэнгээний газрын тайчигч хүүхний тухай бодол толгойд нь өөрийн эрхгүй ороод ирэв. Цэл залуу, нүд алдам сайхан хүүхэн байсан. Гэсэн ч Чинбат тэр хүүхнийг тэгтлээ их шохоорхоогүй, бүр гуя хасыг нь илээ ч үгүй байтал юу боллоо! Ийнхүү элдвийг бодон сэтгэл чилээн хичнээн ч суусныг бүү мэд. Бараг үүр цайх гэж байхад нэг мэдэхэд архи толгойд нь гарч элдвийн зовиурт бодлыг нь түр ч гэсэн мартагнуулан зөөлөн бөхөд идэгдээд эхлэхэд л унтлагын өрөө рүүгээ зүглэж нам унтсан билээ. Тэгээд нэг сэрэхэд нь бага үд болж байжээ. Мэдээж эхнэр, хүү хоёр нь аль хэдийн ажил, сургуульдаа явсан байлаа. Тэр өдөр талийгаач сайдын үед зарлаад дүнг нь гаргасан ч хэлэлцэж амжаагүй тендерийн хурал, Засгийн газарт өргөн барих хуулийн төслийн хэлэлцүүлэг, орой нь Гишүүнтэй уулзалт гэсээр амсхийх завдалгүй өнгөрч хэдэн түншүүдтэйгээ үдэш нэгнийх нь зоогийн газрын арын өрөөнд уулзах үеэр санамсаргүй нэгэн тохиолдол түүнийг хүлээж байсан юм.

Хүрэлхүү гэж нэг намынх нь нөхөр хоёр бүсгүй дагуулж иржээ. Тэр нь чухам ямар бизнес хийгээд буй нь мэдэгддэггүй атал тэрбумаар ярих мөнгөний тоглоомд хошуу хуруу дүрчихсэн явдаг, тэгсэн атал улстөрд биеэр оролцдоггүй, аль аль намд хандив өргөөд ашиг

сонирхлоо хамгаалчихдаг сүйхээтэй эр. Мань эр дагуулж ирсэн нэг хүүхнээ зориуд Чинбатын дэргэд суулган “Танилц, миний найз Чинбат“ гэж ирээд л цаанаа учиртай харж, ирмэсэн атал ажил хэргийн яриагаа үргэлжлүүлж байлаа. Эхнэртэйгээ хэрүүлтэй, тэр нь зүгээр нэг ам мурийснаас илүү өдрөөс өдөрт улам даамжраад, хүн л юм хойно их ажлын хажуугаар сэтгэл зүрх нь хоосроод яавал ч яахаар явсныг хэлэх үү. Алтанзагас гэж гоё ч, содон ч нэртэй, гуч хүрч яваа байрын тэр адтай бүсгүйтэй нэгэн шөнийг хамт жаргаад өнгөрөөчихсөн билээ. Гэхдээ үүрээр гэр рүүгээ яаран очиж хоноод маргааш нь бага зэрэг гэмших сэтгэл үе үе шаналгаад харин ч сэтгэл санаа нь улам ч дорджээ...

Пандагатай нөгөө л уулздаг “Их хүрээ“ зоогийн газрынхаа бүхээгт уулзав.

-Танай сайдын хүчилтөрөгчийн аппаратыг санаатай салгасан юм байна. Чамайг мэдэж байх хэрэгтэй гэж бодоод хэлэх гэж ирлээ. Өөр ч нарийн юмнууд бий. Гэхдээ энэ бол нууцын нууц эх сурвалжийн мэдээлэл шүү гэж найз нь мэндийн зөрүүгүй бараг л уруулаа хөдөлгөхгүй шахам атал харцаараа яриад буй мэт хэллээ. Пандага аль залуу байхын их л ноцтой юм ярихдаа тэгдэг, найзууд нь түүн шиг уруулаа хөдөлгөхгүйгээр ярих гээд ер болдоггүй ажээ.

-Юу?

Чинбатын хувьд энэ нь үнэхээр санаанд оромгүй мэдээ байлаа.

-Чшш. Задлан шинжилгээгээр элэгний цочмог үрэвсэл, тархинд цус харваснаас биш, уушгинд хүчилтөрөгч дутагдсанаас үүдэлтэй гэнэтийн үхэл гэж гарсныг нууцалж байгаа юм байна. Сувилагч нь амьсгалын аппаратыг нь салгасан гэнэ. Гэхдээ мэдээж, энэ мэдээллийг нууцлахыг задлан хийсэн эмч нарт нь амь настай нь холбоод даалгачихсан байгаа.

-Хэн тэгсэн байхав?

-Мэдээж чи биш. Тэхдээ миний найзад хамаатай юм нэлээд байна. Эртүүд чамайг “White lotus“ руу ороход хүүхэн явуулчаад Чимгээ рүү утасдсан нь бас л зохион байгуулалттай байсан.

Чинбат санаа алдав. Амьсгал нь давчдаад байсан тул зангиагаа суллав.

-Чи өчигдөр Хүрэлхүүгийн дагуулж явсан хүүхэнтэй унтах хэрэггүй байсан юм. Элдэв дэмий юманд орооцолдох хэрэггүй.

-Хэдийд нь ... амьсгалын аппаратыг салгадаг байна?

-Хүүхэд нь сургууль дээрээсээ алга болсон юм байна лээ. Тэгээд авгай нь сандраад хүүхэд хардаг охинтойгоо утсаар ярих гээд хэсэгхэн зуур гараад орж ирэхэд л амьсгаа хураасан байсан юм билээ. Гэхдээ аппаратыг буцаагаад залгачихсан байсан байгаа юм. Задлангаар л гарч ирсэн мэдээлэл шүү дээ.

-Хэн тийм юм хийдэг байна?

-Чи ингэж их эмзэглэх хэрэггүй. Харин толгойгоо илүү сайн ажиллуулах хэрэгтэй. Танай сайд өөрөө бурхан байгаагүй. Асар их мөнгөний уут атгаж байсан, түүнээсээ өөрөө ч их цохисон хүн. Энэ мэдээллийн нууцыг одоо хэсэг хүн атгаж сууна. Аягүйдсэн цагт чиний эсрэг ч ашиглаж болно. Үүнээс л болгоомжлох хэрэгтэй. Алхам тутмаа хянаж яв. Чиний хувьд сайд болох магадлалтай хүмүүсийн нэг боллоо. Өөрийгөө шилэн хоргонд байгаа алтан загас л болсон гэж бод. Хүүхэн шуухан чамд зохихгүй ээ.

-Чимгээ рүү хэн утасдсан болж байна?

-Танай дэд сайдын зохион байгуулсан ажил. Цаана нь бас нэг хүн бий.

-Тэр нь хэн юм?

-Хүүхэн шуухнаар хүнийг шантаажинд оруулдаг нэг амьтан байдаг юм. Тэр “White Lotus”-ын эзэн Цагаанаа гээд. Чи таних л ёстой доо.

-Юу билээ? Ухаан санааных нь мухарт үлдсэн атал шууд толгойд нь орж ирэхгүй энүүхэнд байх бүдэг бадаг нэгэн дурсамжийг сэргээх гэж тэр их л зовж байлаа...

Пандага гэж найзынх нь багын хоч өнөөдрийг хүртэл салахгүй дагаж байгаа нь дөч гарсан зузаан эрд тийм ч зохимжтой санагдахааргүй. Жинхэнэ нэр нь Бат-Очир. Хэзээний мяраалаг хүүхэд байснаас Пандага хочтой болжээ. Наяад оны эхээр тавдугаар ангид орох зунаа Сэлбэ зусланд танилцсан хоёр ийнхүү гуч гаруй жил үерхэж найзалсаар бие биенийхээ сүүдрийг ч ялгахаар дотноссон гэхэд хилсдэхгүй.

...Нар наадсан голын бүлээн усанд шумбан, өглөө эрт болдог пионерийн шугам жагсаалаас хоцроод хөнжилдөө шурган унтах атал өдрийн унтлагын цагаар багш нараас нуугдан охидын тасгаар үймүүлж гүйсэн хөгжөөнт зуслангийн тэр өдрүүдээс хойш хоёр найз үерхэлдээ үнэнч яваа хоёр. Он цагийн уртад үзсэн дуулсны хэрээр танилын хүрээ өргөжсөөр сурагч, оюутан ахуй цаг, залуу насны найз нөхөд гээгдэн хоцордог нь жам. Харин Пандага тэр хоёрын амьдралын зам тийм ч амархан салахааргүйгээр зурагдсан бололтой.

Есдүгээр ангидаа Сөгнөгөрийн зусланд Цасчимэг, Чинбат хоёрын анх танилцахад хамт амраагүй ч түүнээс хойши хайрын түүх намтрыг нь Пандага ба, бэ-гүй мэднэ. Чимгээ, Пандага тэр гурав багадаа гайгүй сайн найзууд байж, Бат-Очирыг найз охинтой болохоор нь дөрвүүлээ нийлээд цаашдаа гэр бүлээрээ найзална гэж мөрөөддөг байж билээ. Гэвч Пандагын үерхэж байсан Сарнай гэж жижигхэн бор охин германд сурахаар яваад тэндээ хүнтэй суугаад үлдчихсэн юм. Хожим нь тэр Саратовт сурдаг Насаа хэмээх царайлаг хүүхэнтэй суусан нь Чимгээтэй нэг л нийцгүй байдгаас болоод тэдний үерхэл гэр бүлийнх болж чадсангүй. Цасчимэг эхнэртэй нь хөндий болохоор нэг л мэдэхэд нөхрийнхөө багын найз Пандагаас ч холджээ. Насаа бүхнийг ашиг хонжооны нүдээр харж, гарт баригдаж, нүдээр үзэж болохуйц биетэй бодитой зүйлийг л сонирхдог, “амьдралаас тасархай номын юмнуудад шал дургүй” хэмээн ил тод тунхагладаг хүүхэн. Гэр орноо гялалзтал цэвэрлэн, ганган аяга шаазангийн бүхэл бүтэн цуглуулга бий болгон гэрт ч гадаа ч нүдээ бүлтэртэл гоёж, хуучин хөргөгчөөсөө эхлээд нэг жил өмссөн булган дээлээ ч найз хүүхнүүддээ үнэ хүргэн зарахаас үл ичнэ. Түүний тод улаан өнгөөр будсан хумс, эрээ цээргүй нэвт шувт ширтсэн будмал сормуустай хүйтэн нүд харц, хурц үнэртэй ус түрхдэг нь, гэртээ утсаар хэдэн цагаар ярьдаг нь, ер нь юм бүхэн нь Чимгээгийн эгдүүцлийг төрүүлнэ. Эхнэрүүд нь ийнхүү бие биенээсээ тэс өөр бодгалиуд байлаа гээд эрчүүдийн үерхэл хөндийрсөнгүй. Уг нь Пандагын багадаа үерхэж байсан Сарнай бол ухаалаг, нарийн мэдрэмжтэй, хэнийг ч сонсч чаддаг Насаагаас ёстой л “180 хэм” өөр бүсгүй байж билээ.

Цагаанаа, Цагаанаа... энэ нэр ямархан нэгэн дурсамжийг бүдэг бадагхан сануулах боловч тоймтой юм юу ч толгойд орж ирэхгүй л байлаа.

-Чимгээгийн хойноос гүйдэг атаман байгаагүй юу даа. Чамд Чимгээг алдсанаа

мартаагүй явна даа.

Чимгээгийн хойноос гүйдэг байсан... Хүний тархи хэрэгтэй хэрэггүй мэдээлэл, амьдрал, он цагийн уртад зэрөөд өнгөрснөөс эхлээд хэд гурван удаа үг сольж үзсэн, нөхөрлөж, дайсагнаж явсан үй түмэн хүний нэр ус, царай зүс эрээлжилсэн нэг төрлийн хогийн савархуу ч юм уу даа. Тэр түмэн юман дотроос хааяа нэгэнтээ хэрэгтэй юмаа санах гэж хөөрхий тархи нугалаас атираа бүхнээ нэгжин агшиж тэлдэг бололтой.

Тийм ээ, Чимгээгийн хойноос гүйдэг асан олон хөвгүүн байсныг бүдэг бадаг санаж байгаа ч он жилийн тоосонд дарагдан мартагджээ. Цасчимэг... онцгой ховор чамин нэрэнд нь болоод ч тэр үү, үеийн охид дундаа дэгжин цэмцгэр хувцасладагт нь ч юм уу, нэр шигээ цасан цагаан царай, бусдаас өвөрмөц дүнсгэрдүү зантайд нь болдог ч байсан юм уу, хөвгүүд хошууран гүйлдсэн хотын цуутай охидын нэг байж билээ. Чинбат эхлээд түүнтэй жирийн сайн найзууд байснаа аравдугаар ангид орсон жилээ дотносон үерхэж, хөтлөлцөн гүйлдэх болсон юм. Цасчимэгийн хувьд тэр олны дундаас хувцас муутай, даржиндуу амьдралтай, олон дүүтэй Чинбатыг яагаад онцлон тоосныг бүү мэд.

Чинбат тэр жилээ арав төгсөөд Москвагийн улс ардын аж ахуйн дээд сургуулийн хуваарь авч магнай хагартал баярласан ч хотын захиргааны нэгэн том даргын хүүхдэд булаалгачихаад арай гэж нэг юм дотоодын сургуультай л хоцорч билээ. Тэгэхэд Цасчимэг “чамтайгаа хамт нэг хотод сурна” гээд Ленинградын их сургуулийн хуваариа Москвад болгуулчихаад байснаа сургуулиа алдсаныг нь сонсоод “Би яаж тийшээ ганцаараа явах юм?” хэмээн хачин их урам нь хугаран нулимс унаган явж билээ. Тэгээд дараа жил нь “хоолой өвдөөд” гэсэн шалтгаар монгол руу шилжээд ирсэн юм. Аав нь Соёлын яаманд хэлтсийн дарга, ээж нь Их дэлгүүрийн гадаад барааны нярвын ажилтай, түүн шиг ганган цэмцгэр бүсгүй Москвадаа шингээд том айлын хүүхэдтэй суугаад, эсвэл тэр үеийн зарим бүсгүйчүүд шиг бүр гадаадын бэр болчихож ч болох байсан. Гэхдээ Цасчимэг тийм хүн биш. Итгэл, зорилгодоо түүн шиг үнэнч, цэх шулуун зантай хүн эрчүүдийн дунд ч ховорхон байдгийг Чинбат мэднэ. Тэр хиргүй цэвэр үнэнч сэтгэл, өчүүхэн төдий ч ашиг хонжоо хардаггүй шулуун шударга зан нь он цагийн уртад өчүүхэн ч хувирсангүй. Гэтэл Чинбат? Цэл залуу, ид хайраар шатаж явах үедээ сэтгэлийг нь соронздон татдаг асан эхнэрийнх нь тэр үнэт чанарууд одоо өөрт нь тээртэй санагдан, эр нөхрөө юу ч хийж байсан нүдэн балай чихэн дүлий дэмжин таашааж суух номхон дорой боол шиг нь байсангүй, өөрийнх нь өөдгүй араншинтай эвлэрсэнгүй гээд адалж байгаа биш гэж үү?

Чи хэзээ нэгэн цагт, өөдрөг сайхан сэтгэлтэй, хүнд, хүний сайн сайханд итгэдэг эрдэм номын хүн байсны үнэр ч үгүй эрх мэдэлд шунасан өөдгүй амьтан болж хувирч байгаагаа мэдэхгүй байгаа нь харамсалтай! бус уу? гэж нэг удаа хэлж байсан эхнэрийнх нь зэмлэл үнэний хувьтай л үг.

Цагаанаа... тийм ээ. Цасчимэгийн шүтэн бишрэгчдийн дунд байсан сургуульдаа алдартай муу явдалтай, архи ууж, тамхи татдаг атал, тригонометрийн тэгшитгэл бодохдоо нүгэлтэй сайн, өндөр туранхай хүү байсныг тодхон санах. Тэд нэг сургуульд сурч байгаагүй ч Цагаанаа Пандагатай нэг гудамжны хүүхэд байсан. Бас хилэн өмд оёж зардаг тул халаасны мөнгөөр тасардаггүй, өөрийнхөө тойрон хүрээлэгчдийг Элдэв-Очир, Ард кино театруудын кинонд “дааж” явдаг бэлтэй амьтан байсныг ч санах. Тэр Цасчимэгийг одоо ч мартдаггүй

байх нь. Тиймдээ ч Чинбатын өвөр дээр хүүхэн суулгаж байгаад эхнэрийг нь дуудан авчирч харуулж, өнөөдрийг хүртэл үргэлжилсэн хэрүүл, үл ойлголцлын салхийг үлээлгэчихээд баярлаж суугаа байх нь ээ. Ерээд оны эхээр Москвад ажлаар явж байгаад халти тааралдахад ганзага хийж байна гээд тэр үеийн нэг мисс хүүхэн сугадчихсан явж билээ. Тэр тэгээд гахай үүрсээр тийм нэг өөдгүй цэнгээний газартай болсон юм биз дээ?

-Цаадхи чинь Их хурлын 76 мангуугийн нэлээд хэдийг нь хүүхнээр дамжуулан барьдаг эр дээ. Танай талийгч сайдын сексийн нууц бичлэг ч Цагаанаад байдаг гэж байгаа. Чи яах гэж тэдний баар руу орсон юм бэ?

-Мэдэхгүй ээ. Станцад бараа сэлбэг нийлүүлдэг оросуудтай уулзах ажилтай байсан. Тэд нар хүүхэнтэй аятайхан газар сонирхоод байна гэхээр нь Цогоогоор сураглуулж байгаад тийм газар байдгийг мэдээд очсон ухаантай. Би ямар тийм газраар явах биш. Үгүй тэгээд, намайг тийшээ орлоо гэж яаж мэддэг байна?

- Тэр нэг их сонин биш ээ найз аа. Яг тийшээ очихоор болсныг мэдэх амархан. Чиний хамгийн эмзэг тал эхнэр чинь гэдгийг мэдэж байгаа ш дээ, цаадуул чинь. Нөгөө алтны компанийн хэрэг чинь юу болсон?

-Сурвалжлагчид нь, сонинд нь мөнгө төлөөд чимээгүй болгосон.

-Аягүй бол утсыг чинь чагнаж л байгаа байх шүү. Утсаар нэг их нарийн юм яриад хэрэггүй шүү. За тэгээд сайд болох мөнчгөр байна уу?

-Би чинь юу руу л орчихов доо. Нөгөө талынхнаас манай орлогчоос гадна О гишүүн сайд болох гээд хүчтэй зүтгээд байгаа.

-Тэр чинь сайд болохгүй л юм бол дүүжлүүрийн гогцоо хүзүүнд нь бараг углагдчихаад байгаа хүн дээ.

-Юу гэсэн үг вэ?

-Танай яамны мэдлийн хэдэн тендерийг л авахгүй бол амь нас нь дээсэн дөрөөн дээр байгаа юм. Нийт зээлийн өр нь 8 тэрбум хол давчихаад байхад одоо амьдарч байгаа байшингаас нь эхлээд бүх үл хөдлөх хөрөнгө нь нийлээд дөнгөж таван тэрбум хүрэхгүй байгаа гэж... Гурван давхар байшинд суудаг баян хүн их хурал дээр пээдэлзээд л, сонинуудад мөнгө төлж өөрийгөө магтуулаад, ганган машин сольж унаад хүүхнүүдийг хошууруулаад байдаг, үнэн хэрэгтээ хамаг хөрөнгө нь удахгүй банкны зээлэндээ хураагдах гээд байдаг. Сайд л болохгүй юм бол дүүжлүүрийн гогцоо өнөөдөр углах уу, маргааш углах уу? гэгч болоод байгаа амьтан.

-Цагаанаагаар дамжуулаад хүүхэн яриулаад байгаа хүн тэгээд манай орлогч уу?

-Мэдээж. Чамайг оролдож байгаа нь тэр. Чи архиваас тэр алтны компанийн бичиг цаасаа үртэс ч үлдээлгүй олж устгах хэрэгтэй.

-Тэгье.

-Эхнэртэйгээ хэл амаа ололцох хэрэгтэй дээ...

Найзынх нь дууны өнгөнд зэмлэнгүй аяс байгааг тэр ялгаж байлаа.

Цасчимэгийг өмөөрч байгаа байх нь. Яг үнэндээ Пандага ч тэр үед Цасчимэгт санаатай ч байсан юм бил үү? Махлаг бүдүүн, болхи хөдөлгөөнтэй түүнийг Чимгээ тоогоогүй болохоос... гэсэн зурвасхан муу бодол орж ирээд замхрав. Хүн арьсан дотроо хичнээн муу муухайг тээж, тархиндаа элдвийн булай бодлоо нууцалж явдаг өөдгүй амьтан байдаг юм дээ. Өөрт нь сайн санаж хэлсэн үнэн үгний төлөө хар багын ганц найзынхаа тухай ийм ч юм бодох гэж дээ.

Тэр хоёрыг гарахад хавар эртийн жавар, хотын утаа хамар хорсгосон жихүүн үдэш байлаа. Цаг шөнийн нэг өнгөрсөн ч хотын төвийн гудамж хөл тасраагүй, 24 цагийн гуанзны гадаа таксинууд овооролдон, гэрлэн чимэглэлүүд гялалзана. Хол гэртэй гээд жолоочоо буулгачихсан болохоор Чинбат Пандагын машинд суулаа.

Машинд суугаад мань хоёр тус тусын бодолд дарагдан чимээгүй болсноо анзаарсангүй. Нэг л мэдэхэд хэд хэдэн гудамж өнгөрөөд Чинбатын гэрийн гадаа ирчихжээ. Тэдний байрны бүх айл унтсан бололтой гэрэлтэй цонх ганц ч үлдсэнгүй.

-За сайхан амраарай. Би ч Жижгүүлэйгээ очиж үнэрлэе.

-Сайхан амраарай.

Хоёр найз салан одлоо. Ийнхүү гэр рүүгээ яаран одож байгаад нь Чинбат найздаа атаархмаар санагдав. Жижгүүлэй гэдэг нь Пандагын хоёр настай отгон хүүхэд. Түүндээ амь гэж жигтэйхэн.

Хэзээ нэгэн цагт Чимгээ шөнө дөл болтол түүнийг харуулдан хоолыг нь өөрийн гараар халааж өгөх, өдрийн болсон явдлаа ярих гээд хүлээж суудаг сан...

Нарангийн хажуугийн хаалганд нүүж ирээд удаагүй шинэ хөршийг нь Энхтуяа гэнэ. Тэднийх хөхөө өвлийн дүн хүйтнээр нүүж ирж байснаас хойш хоёр сарыг хэдийнэ ардаа хийжээ. Нэгэн дүүргийн захиргаанд байцаагчийн ажилтай, дөнгөж 27-той бүсгүй. Хоёр тэрсхэн хүүгээ хөтөлсөн ийм аятайхан бүсгүй юугаа хийж, яаж яваад энэ бараанк байшинд нүүн ирж хотын борчуудтай айлссаныг байрныхан сонирхож, сонжихгүй байж чадсангүй. Нөхрөөсөө салсан, байраа өрийн барьцаанд хураалгасан, эс бол залилангийн хэрэгтэн байж мэднэ гэлцэн орхигдмол байшингийн эхнэр хүүхнүүд дор бүрдээ хэдэн өдөр хэл амаа билүүдэцгээсэн ч шинэ суугч бүсгүй далан булчирхайгаа тоочих гэж яарсангүй. Хүний сониуч зан гэж тэгсхийгээд дарагддагийг хэлэх үү. Нэг л мэдэхэд байрныхан хоёр хүүхэдтэй залуу хүүхнийг сонирхохоо больцгоов.

Бараанк байшингийн найман айл дундаа ганц яйжгий төмөр хаалгатай орцоор орж гарцгаана. Яйжийсан тэр муу төмөр бүрээстэй хаалганы нь нугас хуучран хэзээ л салж унах

бол гэмээр хүн орж гарах бүрд ёолох мэт гаслантайяа чихран дуугарна. Урт хонгилын дагуу өөд өөдөөсөө харан байрласан найман айлын хамгийн наад захад байх савхалсан модон хаалга тэднийх. Хонгилын мухарт байх нийтийн жорлонгоос дотор эвгүйрхэм муухай үнэр хонгилоор нэг ханх тавина. Найман айлын дунд байх хүйтэн усны ганц цорго тэрхүү хэцүү үнэрт 00-ийн зэргэлдээ байх тул ус авах бүрдээ хамраа чимхэн өнгөрөх хэрэг гарна. Хөршүүд нь гэж харваас борчууд. Арай л нэг гудамжинд гарчих нь холгүй, харцанд нь гуниг шингэсэн, хоногийн хоолоо яая даа гэсэн үлгэн салган амьдралтай атал хэрэгт дурласан хүйтэн сонжооч харцаар бүсгүйг ширтэцгээх нь онцгүй. Харин аз болоход өөдөөс нь харсан ногоовтор бүргэд хаалгатай айлын эзэгтэйтэй овоо хурдан танилцаж мэнд устай болсондоо бүсгүй их л олзуурхаж байлаа.

Энхтуяа энд нүүж ирээд удаагүй, тав зургаа л хонож байсан санагдана. Дэгдээхэйгээ дагуулсан эх нугас мэт хоёр хүү нь даган чиргүүцэлдэж гурвуулаа гадаа хогоо асгаж яваад хөршийнхөө тэр нүдэнд дулаахан намбалаг авгайтай анх тааралдаж билээ. Гадаа угаадасны дошин дээр гулгана гэж зөрүүдлэн зүтгэж яваад тэрий харан унасан бага хүүг нь тэрээр өргөж босгон хувцсыг нь гүвж хөмсөг нь улайн өмгөнөх хүүгийн гар дээр чихэр тавьж:

-Эр хүн чинь уйлдаггүй юм. Миний хүүг хэн гэдэг юм? хэмээн аргадаж байхад нь Энхтуяа дэргэд нь очив.

-Тэмүүлэн гэдэг...гээд хүү санаа алдав.

Хүү нь эцгээ явснаас хойш юм л бол ийн санаа алдах болсон нь эхийн сэтгэлийг өвтгөнө.

-Ээж, энэ эмээ надад чихэр өгсөн.

-Хүүхдүүдээ хамаагүй бүү гүйлгэж бай. Энүүгээр чинь машин тэрэг замбараагүй давхилддаг газар. Өнгөрсөн жил хажуугийн байшингийн нэг охин энүүхэнд машинд дайруулсан юм...

Олон жил химийн цэвэрлэгээнд өгсөөр муудсан бололтой өнгөө алдсан хуучин саарал хавар намрын пальтотой, урт түрийтэй, арьс сайтай өвлийн гутал жийж, жижигхэн саарал булган малгайг хажуулдуулан донжтой тавьсан, буурал санчигтай, үл мэдэг халирхай харцтай, нүдэнд дулаахан хүн байлаа.

Нэр нь Цэндмаа гэх ажээ. Ярианых нь намбалаг төрх, өмссөн зүүснээс нь үзэхүл арван жилийн сургуулийн хичээлийн эрхлэгч юм уу, багш хүн болов уу гэж бүсгүй дотроо таамаг дэвшүүлсэн нь оножээ.

Тэр үдэш хөрш нь түүнийг гэртээ “Цай уу” гэж урив.

Хоёр хүүгээ гэртээ тоглож бай гэж орхиод түүнийг шинэ танилындаа ороход нөгөө авгай гэртээ ганцаараа, сайхан хоол үнэртүүлчихсан сууж байв. Айл айлынхаас нэг л ондоо, тос нь тааруухан сайхан цуйван таваглаж, сүүтэй цай аягалан дайлж яриа дэлгэв.

-Эгч нь хоёр охинтой. Дээд сургуульд сурцгаадаг. Бага охин Саран Анагаахад... Том нь гээд үл мэдэг түгдэрснээ Наран гэдэг юм... Сайхан охин бий дээ. Манайх ерөөсөө л хотын айл. Эгч нь энэ байшинд бага насаа өнгөрөөж, хоёр охиноо ч өсгөсөн. Хүүхдүүд эрүүл саруул сайхан л өслөө. Харахад доожоогүй ч өлзийгөө өгсөн байшин байгаа юм аа... Миний дүү, боловсролтой, залуу хүн, юун алзахав. Эгч нь багшийн сургуульд туслах багшийн ажилтай. Хүн ер нь эрүүл байхад болохдоо л болно...

Энхгуяа ч ийм аятайхан яриа хөөрөөтэй хүнтэй танилцсаных амьдралаа ярьж бага ч гэсэн сэтгэлээ онгойлгов. Хотын төвд, циркийн зүүн талд хоёр өрөө байртай байснаа, нөхөр нь Солонгос явж амьдралаа дээшлүүлэх юм болж байраа барьцаалаад шагаар виз гаргуулсан, өөрөө хоёр хүүтэйгээ үлдээд банкны зээлийн хүүг дийлэхээ больж, арга буюу байраа зараад энд нүүж ирснээ цөмийг ярив.

-Миний дүү залуу, боловсролтой хүн алзахгүй ээ. Орох оронтой л үлдсэн улс учиртай. Дэм дэмэндээ дээс эрчиндээ... Орж ирж байгаарай.

Хоёр охин нь гэртээ байсангүй. Үүдний өрөөнийх нь гол тавилга болсон хуучны сервант хэмээх хүрэн мебель шүүгээн дээр Цэндмаа гуайн аав, ээж бололтой хоёр хөгшний зургийн өмнө зулын цөгцнүүд тавьжээ. Хананд охидынх нь багын зураг бололтой, дээр үеийнхээр үсэндээ тууз цэцэглүүлсэн тэрсхэн хоёр охины зураг харагдана. Мөн шүүгээнд өөрийнх нь залуугийн хэд хэдэн зураг тавьсан байв. Харин хаана ч нөхөр нь юм уу, хоёр охины эцэг гэмээр эр хүний зураг хөрөг үзэгдсэнгүй ээ.

Авгай хэдийгээр хүнийг сонсч чаддаг, яриа хөөрөө нь боловсон ч гэсэн халирхай харцтай, хүний ая дагасан, юмыг гоёчлон сэтгэлээ хуураад сурчихсан хүний шинжтэй мэт санагдав. Түүний яриаг сонсонгоо ширээнийхээ хуучин хулдаасыг арчих мэт гараа хөдөлгөн хээг нь гөлрөн сууна. Бүсгүйд яг л одоо дутагдаад байгаа эрс шийдэмгий ухаалаг үг хэлж чадахааргүй хүн гэдэг нь харваас илт. Чааваас даа, эмэгтэй хүнд ер нь тийм шийдэмгий зан зохидоггүй ч юм болов уу. Гэвч оёдолчин, зах дээр жижиг наймаа хийдэг, эсвэл хөдөөнөөс орж ирээд өрөө хөлсөлдөг гээд хэцүүхэн хөршүүдийнх нь дундаас хамгийн аятайхан айл нь Цэндмаагийнх л байлаа.

Нөхөр нь Солонгос явснаас хойш чилийсэн дөрвөн сар өнгөрчээ. Хараар явсан болохоор эхний нэг сарыг тогтмол ажилд орж чадалгүй арай ядан өнгөрөөсөн гэнэ. Дараагийн сард нь модон эдлэлийн үйлдвэрт орлоо гэсэн чинь дөнгөж арван хэд хоног ажиллаад бөөр нь өвдөөд хэвтчихсэн сураг гарав. Ингэж тэгсээр гавьтай мөнгө явуулсан ч юмгүй зээлийн хүү нь дийлдэхээ болиод бүсгүй байраа зарж өрөө дараад арай ядан ийм нэг байшингийн оронцогт толгой хоргодохоос аргагүй болсон билээ.

Цэндмаагийн хэлснээр орох оронтой л үлдсэн нь яамай. Орон ч гэж дээ, оромж л юм даа. “Эрүүл байхад болно доо...” гэдэг ч ёстой л онгорхойн дотор уужим л гэсэн үг юм биз дээ.

Түрүү долоо хоногт нөхрөөс нь цөөхөн хэдэн доллар ирснийг хадгаламжинд хийчихээд гарч явахдаа сэтгэл нь цөхрөл гунигаар дүүрч шил дарс ганцаараа залгилмаар, эсвэл хээр хөдөө гарч байгаад ганцаараа асгаруулан уйлмаар болж билээ. Дөрвөн зуун

доллар. Ийм өчүүхэн багаар нь цуглуулсаар хэзээ орон гэрээ буцааж олж авах юм бэ?

Гэтэл төсвийн хэдхэн төгрөгийн цалин нь гурван биед хаанаа ч хүрдэггүй. Тооцоолоод үзвэл одоо хэдийн гучин мянган долларт багтахаа больсон тэдний хуучин хоёр өрөө байр дараа жил гэхэд лавтай таван саяар үнэд орчихно. Сард бүр одоогийнхоос хоёр дахин их, найман зуун доллар цуглуулсан ч дөрвөн жилд байрны мөнгө хийж чадах уу, үгүй юу. Гэтэл өдрөөс өдөрт өсч том болж буй хоёр хүүтэйгээ гурвуулаа юугаа идэж, өмсөх болж байна? Ядахад гурван ой хүрч яваа бага хүү нь байсхийгээд л ханиад хүрч, эсвэл хоолой нь өвдөж эм тарианд өчнөөн мөнгө зарлагадна. Хүүхэд өвдөөд юм юманд ганцаардсан үедээ нөхрөө Солонгос явах гэж шийдсэн өдрийг зүхэж гарна. Хэдэн жилийн өмнө бол хоёр дүү нь ирж туслаад сайхан байжээ. Гэтэл том дүү нь хүнтэй суугаад өөрөө нялх хүүхэдтэй, бага дүү гадаадад сурахаар явчихсан байдаг. Аавынх нь хөдөө, хаа байсан Архангайн төвд. Хадмууд нь бид байр авч өгсөн, та нар түүнийгээ үгүй хийсэн улс хохь нь гэсэн янзтай.

Хавар ирж байлаа... Юу ч гэсэн хөхөө өвөл холдон урин цагийн амьсгал орж байгаа нь сэтгэл тэнийлгэнэ. Хоёр хүү нь чих дөжиртөл шуугилдан тоглож, онгоц, машинуудаа пижигнүүлэн, буун дууг дууриан ам амандаа хашгиран гүйлдэх чимээнд цуйван хийж дуусгаад гурвуулаа хооллож дуусаад нэг мэдэхэд бүрэнхий болжээ. Гадаа хавийн ноход боргон хуцалдана. Цаг лавтай арав өнгөрсөн бололтой. Хүүхдүүдээ унтуулчихаад орондоо эртхэн ороход нь хэдийн арав хагас болчихсон байлаа.

“Маргааш дөрөв дэх өдөр. Хэлтсийн тайлангийн хуралтай.” хэмээн ажлаа бодсоор нэг л мэдэхэд зүүрмэглэчихжээ.

-Хөөе, Сараа бацаанаа хаалгаа тайлаач ээ! Дотуур тамиртай бацаан... хэмээн бүсгүй хүний хашгичих дуунаар сэрчихэв.

Хажуу айлынх нь том охин бололтой. Хэдхэн хоногийн өмнө л Цэндмаа гуайн том охины гэгээн дүрийг анх харсан билээ. Өндөр гоолиг биетэй, царай зүс тэгш төрсөн тэр охин жаахан базаахгүй замаар орчихсон хүн бололтой. Дандаа л шөнө хугаслан ирнэ.

Хаалга нь торхийн нээгдэж халамцуу охин нь чанга чанга хашгичиж байснаа удалгүй дуу чимээ намжсан ч бүсгүйн нойр хэдийнээ хаа нэг тийш хулжин оджээ.

Гадаа ноход боргохоос өөр анир чимээгүй болсон байлаа. Гэнэт үүдний хонгилоор хүнд алхаатай хэн нэгэн холхиж эхлэх нь тэр. Цаг харвал аль эрт шөнө дунд өнгөрч нэг цагт арван таван хором дугуу байв.

Өдийд хэн хонгилоор холхидог байна? Бүсгүй хүйтэн юм залгилах далимаар босч хонгил руу шагайвал хөлийн чимээ цаад мухар руу холдон одох дуулдаж байгаа атал хонгилд хэн ч байсангүй. Хамаг биеэр нь хүйтэн юм гүйх шиг болж хаалгаа тасхийтэл хаалаа.

Тэр нэгэн аймшигт шөнөөс хойш арав гаруй хоног өнгөрчээ. Бүсгүй тэр хачирхалтай нууцын тухай хөрш Цэндмаагаас асуух гэснээ яагаад ч юм больчихов. Харин хүүхдүүдээ унтчихвал зүрх бөмбөрдөх мэт тасралтгүй холхих тэр эзэнгүй хөлийн чимээ, хуучин байшинд хоргодсон муу зүгийн хий үзэгдлээс айж атга нойроо хулжаан хэвтэхээс зүрхшээн хадмындаа

суудаг хөдөөгийн оюутан бандийг гэртээ авчирч долоо хонуулав. Айхын бараатай болсон тэр долоо хоногт нь хонгилоор хөлийн чимээ сонсогдсонгүй, санаа дагасан юм болов уу гэж бодоод сэтгэл нь ч тайвширчээ. Оюутан хүүг буцсаны дараа гуравдугаар сарын сүүлчийн шөнө. Хар дарж зүүдлээд сэрж цаг харвал нэг цагт арван таван хором дутуу байлаа. Эргээд унтах гэтэл нойр нь хүрсэнгүй. Гэнэт хонгилоор өнөө л хүнд алхаатай хүн холхиж эхлэх нь тэр ээ.

Сэтгэл хоосруулсан ганцаардлын хажуугаар зүрх хүйт оргим айдас хамаг бие сэтгэлийг нь нөмрөн авлаа. Шал нь чихарч, хана туурга нь цууран цонх нь яйжийсан энэ хуучин байр хий үзэгдэлтэй байх л дутаж гэнэ. Хар нялхаасаа аав, ээжээ даган бурхангүйн үзлээр хүмүүжсэн нь ч яалаа. Хонгилоор холхих хүнд хөлийн чимээ тархины гүн рүү алхаар нүдэх мэт... Хөлийн чимээ яах аргагүй сүүдэртэн харлах мухар руу цаашлан одож байхад хонгилын гол дунд байх ёлтойсон чийдэнгийн гэрэлд юу ч харагдахгүй байсан...хөлийн чимээ гараад байхад хэн ч байгаагүй. Бүсгүй хаалгаа тасхийтэл хааж, дангинатал түгжээд зүрхээ даран хэсэг суугаад орондоо оржээ. Гэтэл нойр нь хүрсэнгүй. Ам нь хатан бие нь чилж хөдлөх гэтэл ор нь нужигнан айдсын түмэн зарааг нуруун дээгүүр нь гүйлгэнэ. Хонгилоор өнөөх юм холхисоор. Айсан хүний нүдэнд аргал хөдөлнө гэгчээр тэр үл үзэгдэх хөлийн эзэн босгоор нь алхаад гэрт нь ороод ирэх ч юм шиг санагдан гэрлээ асааж, хоёр хүүгээ өвөртлөн хэвтсээр ашгүй нэг мэдэхэд нам унтчихжээ. Гэвч нүд хамхингуут л юүдэнтэй цув нөмөрсөн өндөр хүн өөрийг нь мөшгин дагасаар... зугтаж зайлахын аргагүй болж нүүр тулан учрахуйд нүүргүй хов хоосон юүдэн байх юм. Тэгээд хоосон ханцуйтай гараараа хоолойг нь бачууртал багалзуурдаж байна гэхчлэн эцэс төгсгөлгүй хар дарсаар өглөө болгов...

Нарангийн хувьд тэр өдөр үнэхээр хүнд өдөр болж өнгөрчээ. Цасчимэг багштай уулзах гэж өдөржин их сургуулийн хавиар эргэлдэж байж тав өнгөрч байхад л сая нүүр тулан учрав. Олон жил уулзаагүй багш шавь хоёрын яриа эвлэхэд тийм ч амар байсангүй.

-Пээ ямар сонин хүн бэ? Чамайг би ангийнхнаас чинь сураглаад л байдаг юм. Ингээд нэг өдөр гараад ирэх болов уу ч гэж бодож байсан юм аа...

Оюутнуудын хөлд элэгдсэн чулуун шатны сүүлчийн гишгүүр дээр зогсон мэндэлж, “Би уржнан улс төрийн 2-т байсан Наран байнаа. Багшаа та намайг таньж байна уу?” хэмээн дорой дуугарч духаараа харан зогссон түүнийг Цасчимэг харин дорхноо таньжээ. Тэнхимийнх нь багш хүүхнүүд, оюутнууд түүнийг “ихэмсэг зантай, хэтэрхий хатуу, найраа байхгүй” гэхчлэн тийм ч ам сайтай байдаггүй. Харин Нарангийн сэтгэлд чигч шударгуу зан, нягт нямбай бэлтгэдэг лекц, мэдлэг чадвараараа Цасчимэг багш л хамгийн тодхон үлдэж чадсан билээ. Нөхөр нь том дарга боллоо гээд багш нь бараг өөрчлөгдсөнгүй. Элдэв маяггүй богинохон тайруулсан шулуухан үс, нүдэнд өртөх төдий жижигхэн шигтгээтэй хатгадаг ээмэг, номын том цүнх, даруухан хувцаслалт, бараг будаггүй нүүр, цоргих мэт ширтсэн нүд... Өнгөрсөн хоёр жилд бараг овор нэмэгдсэнгүй, харин ч улам залуужсан мэт.

“Хүнийг илүү шунал нь л зовоож насыг нь богиносгож байдаг юм. Хүн жаргалтай байя гэвэл байгаа юмандаа сэтгэл хангалуун байхад л боллоо” гэж нэг удаа хэлж байсан нь бодогдов. Цасчимэг Нарангийн гарыг сурсан зангаараа чанга атган инээмсэглэхэд нөгөө цоргисон харц нь зөөлрөн ялдамхан болов. Гэвч тэр ялдамхан харцны цаана нууцхан гуниг

хурсан ч юм шиг. Үгүй ээ, түүн шиг амьдралд байр сууриа олчихсон, мэдлэг боловсролтой, сайхан гэр бүлтэй, нэр хүндтэй ид насны эмэгтэйд юу дутуу гэж харцанд нь гуниг хурах билээ. Үнэндээ Наранд байхгүй, магадгүй хэзээ ч бий болохгүй тийм үнэт зүйлс энэ хүнд байдаг болохоор далдхан атаархсан сэтгэл нь ийн харцнаас нь нууцхан гуниг эрсэн юм биш байгаа.

-Тантай уулзах хэрэг гараад...

-Тэгээд утсаар ярихгүй яасан юм? Багш нь гар, гэр утсаа нээлттэй л байлгадаг ш дээ.

-Харин тийм. Өглөөгүүр залгасан чинь та хичээлтэй байх шиг байсан...

-За тэгээд гол сэдэвтээ орох уу? Багш нь ээжийгээ зусланд хүргэх ажилтай юм. Оройтох нь. Наран бүр сандарч гүйцэв.

-Яанаа, тантай тухтай л яримаар байна. Хажуугийн кафед гялс ороод гаръя, тэгэх үү?

-За тэгье дээ. Хүн намайг зориод ирж байхад гээд ээж рүүгээ залган хэдэн минут хүлээж байхыг хүсээд хурдан хурдан алхлан сургуулийн гол хаалгаар гарлаа. Наран ч хойноос нь даган гарахдаа яажшуухан яриагаа эхлэхээ мэдэхгүй үүлгэртэн шаналж явлаа.

Тэр хоёрыг сургуулиас гарч ирэхэд дөрөвдүгээр сарын наран нүд гялбуулан ирж буй урин цагийн бүлээн салхи үлээсэн хаврын сайхан орой угтав.

-За тэгээд манай Наран юу хийгээд байна? Сургуульдаа эргээд орно биз дээ.

-Харин ээ. Дүү бас дээд сургуульд орсон. Хоёр хүний төлбөр, хоол унд гээд ээж ганцаараа дийлэхгүй л дээ.

-Юу гэсэн үг вэ? Чи тэгээд дүүгийнхээ өмнөөс амьдралаа золиослох хэрэг үү? Тэгж болохгүй. Чамайг хэл чимээгүй гэнэт сургуулиасаа гарчихаар чинь би гайхаад л байсан юм. Хамгийн гол нь харамссан.

-...

-За, ийшээ ороод таван үг сольчихье.

Үдийн цайны цаг аль хэдийн өнгөрч ажил тарах дөхсөн тул кафед бараг хүн байсангүй.

Яриагаа хаанаас нь яаж эхлэх, өөрийгөө хэрхэн ойлгуулах вэ? гэдэг хүнд даваа байлаа. Гэлээ гээд бүлх залгисан юм шиг таг суугаад байлтай нь биш. Сэтгэлийн гүнд нь сүүмэлзэх итгэлийн өчүүхэн дөл байсан нь Цасчимэгтэй ойлголцож чадна гэсэн найдвар байсан юм. Тэр нь ч оножээ.

Сургуулиа юуны учир орхисон, өөрийгөө золиослон байж газар дээрх ганц дүүгээ амьдралын өршөөлгүй хатуу эргүүлгээс цэвэр хамгаалж үлдэх, амьдралд хамгаас эрхэм ээж,

дүү хоёроо мөр бүтэн, гэдэс цатгалан явуулах хүслээр буруу замд орсноо, сар гаруйн өмнө цэнгээний газар ажиллаж байхдаа хүний эрхээр нөхрийнх нь өвөр дээр гарч суухад хүрснээ, дараа нь тэр хүн багшийнхаа нөхөр байсныг мэдээд ямар их хямралд орсноо, өнөөдөр хэдхэн халтар төгрөгийн барьцаанд орчихоод яахаа мэдэхгүй болсноо, энэ бүхнээс залхахын дээдээр залхаж, өмгөөлөл хамгаалал эрж яваагаа бүгдийг багшдаа ярьчихлаа.

Мэдээж, тэр хоёрын, тэр хоёрын ч гэж, Нарангийн яриа ийм хүнд сэдвээр өрнөж, зүрх сэтгэлийнх нь хамгийн эмзэг хэсэг рүү онилохын чинээ санаагүй Цасчимэг төгсгөл хавьд нь ер бусын их тэвчээр гарган ганц ч удаа таслалгүйгээр сонсож чадав. Тийм ээ, Цасчимэгээс өөр эмэгтэй ийм сайн сонсогч байж чадахгүй. Эмэгтэй ч гэж яс юман дээрээ эр хүн бол бүр ч чадахгүй байсан юм. Хэн нэгэн шавь нь хүний даалгавраар эхнэрийг нь өдөж хоргоосноо ярихыг нүүрээ бараг хувиргалгүйгээр сонсож чадах эр бол хүн биш аль нэгэн өөр төрлийн хулчгар, эсвэл өөдгүй амьтан байж таарна биз дээ.

Наран ярьж дуусаад сэтгэл дотроосоо нэг их том чулуу аваад хаячих шиг болж сая л нэг дотор онгойлоо. Харин Цасчимэгийн хөмсөг зангидаж бодлогоширсон харц нь юуг ч үл илэрхийлэн суусаар л байгааг сая анзаарав.. Сэтгэл дотор нь юу болж байгааг тааварлахад бэрх, цээжиндээ шатаж буй түймрийн утааг амаараа гаргахгүй байж чаддаг түүн шиг хүмүүстэй яаж харьцах ёстойг Наран мэдэхгүй байлаа. Ямар ч гэсэн түүний сэтгэлээсээ аваад хаячихсан бул чулуу одоо багшийнх нь цээжийг давчдуулж байна уу даа гэмээр. Хэдхэн хормын өмнө ээжийгээ зусланд хүргэж өгнө, чамтай таван үг солиодхоё хэмээн бодох санах юмгүй инээж явсан энэ хүнийг Наран л ийн хүнд байдалд оруулан сэтгэлийн хямралд унагасан биш үү? “Багш аа, та сэтгэлээр бүү унаарай“, “Та ухаантай хүн юм чинь...” үгүй ээ, ийм үед юу ч гэж сэтгэлийг нь илбэн тайтгаруулах гээд нэмэргүй. Ер хүний сэтгэл хэмээх эрхтэнг худал үнэн үгээр хууран тайвшруулж болдог юм уу? Тэр дундаа Цасчимэг шиг ихийг уншиж, ухаан цэлмэсэн уужуу талбиун бодолтой хүнийг. Тэртээ тэргүй Наран өөрөө л үүрч дуусгах үйлтэй амьдралынхаа гуниг зовлонг ярьж энэ хүний тайван амгалан байсан сэтгэл зүрхийг хөндчихөөд эцэст нь хөндлөнгийн хүний заавар тушаалаар хань нөхрийг нь уруу татах аядан нүцгэн шалднаараа өвөр дээр нь эрээ цээргүй гарч суун, зангиаг нь оролдон маяглаж байгаад өөртэй нь тааралдан зүрхийг нь урснаа ид бах болгох мэт ярьсан шүү дээ. Тэгээд саваагүй бяцхан жаал хөл, далавчийг нь тастсан эрвээхийгээ хэрхэн тарчлахыг нь харж баясах мэт өөдөөс нь хараад жишим ч үгүй сууна. Үгүй, ингэхэд Цасчимэг түүний хүүрнэсэн эл явдлыг сонсохоос өмнө ч гэсэн тийм аз жаргалтай байсан юм болов уу даа. Анх уулзахад л хоёр жилийн өмнөх түүний сайн мэдэх, үгүй ядахнаа муугүй гадарлах Цасчимэг багшаас өнөөдрийн Цасчимэг нэг л өөрчлөгдсөн юм шиг санагдаагүй гэж үү? Инээмсэглэж байвч нүднийхээ буланд гунигийн сүүдрээ нуусан юм шиг санагдаагүй гэж үү? Тийм ээ, Наран мэргэжлээ буруу сонгоогүй сэн бол муугүй сэтгэл зүйч болох байж. Өөрөөс нь сонссон тэр мэдээнд л ингэж сэтгэлийн тэнцвэрээ алдсан биш, ер нь амьдралдаа сэтгэл хангалуун биш явсан болоод л энэ эмэгтэй ингэтлээ хүнд бодолд унасан хэрэг. Наран түүний царайг ажиглан сууснаа тэсэлгүй санаа алдаад цайнаасаа балгав. Нимбэгтэй халуун цай хэдийн хөрч бүлбийсэн бүлээн юм болжээ.

-За... тийм байдаг байж. Энэ үгийг хэлээд санаа алдчихав. Манай Чинбаагийн өвөр дээр сууж байсан тэр... хүүхэн чи байсан гэхэд итгэмээргүй.

Цасчимэг энэ үгийг дуугүй суугаад байхгүйн тулд өөрийгөө хүчлэн байж хэлэх шиг түүнд санагдав...

“Би маргааш герман явлаа. Чи минь юу захих вэ?”

“Тэр баарны хүүхнүүддээ новш авчрахгүй юу!”

“Дура!” тэр өдрийн хэрүүлийг тодхон санав. Өнөөдрийг хүртэл сар гаруй үргэлжилж буй тэр гайтай хэрүүлийн алим нь очиж очиж өөрийнх нь хамгийн хайртай шавь байсан байх нь тэр. Өдөн хүрэм, жийнс өмсч, урт сайхан үсээ сүлжсэн, тунгалаг нүдтэй ердийн нэг оюутан шиг харагдах энэ охин тасам татсан дотоож, хөхөө дөнгөж далдлах төдий саатай хөхөвч зүүгээд гэзгээ задлан унжуулчихаад, нүүрээ хятад хүүхэлдэй шиг будчихад л танигдахаа байж төрсөн эх нь ч үрээ гэж мэдэхийн аргагүй ердийн л нэгэн баарны шалиг хүүхэн болон харагдаж байжээ. Семинар бүхэнд сэдвээрээ хязгаарлахгүй их юм уншиж ирээд, өнөөгийн улстөрийн ертөнцөд болж буй үйл явдлуудад үнэлэлт өгөхийг оролдон, ямагт шинийг мэдэх гэж явдаг, үзэл бодлоо хамгаалан зогсч чаддаг ховорхон оюутан байж билээ, энэ Наран. Гэтэл амьдрал хүнийг ингэтэл өөрчлөх гэж. Бас Чинбат. Ажлын төлөө гэж яваад л тайчдаг хүүхнүүдтэй бааранд орж, цаанаасаа элдэв хатгаас, явуулгаар өвөр дээр нь хүүхэн суулгачихсан байхад бухимдан өнөөдрийг хүртэл хэрэлдэж, хэн хэнийхээ зүрхэнд мөс хийж явах гэж дээ. Гэхдээ л тэр хоёрын дундуур орсон хар муур ганцхан түүний өмнө гэмшил дүүрэн духайж суугаа хуучин шавь нь байсан золгүй бүсгүйгээс үүдэлтэй юу гэвэл түүн шиг хийсвэр, гэнэхэн дүгнэлт хаана байхав дээ. Эрх мэдэлд шунасан хэн ч хайрлах юмгүй болдог юм чинь! Чинбат өөрийгөө хөндлөнгийн нүдээр хардаг ч болоосой. Бодит амьдралаас улам бүр тасарч өөрийнхөө одоо байгаа тэр бохир ертөнцийнхөө бүүдгэр цонхоор эргэн тойрноо тольдох болж, Цасчимэг өөрөө нөхрийнхөө байгаа тэр бүүдгэр шилнийх нь гадна үлдчихээд зүрх зүрхээ мэдэрч ойлголцохоо больчихоод байх шиг санагдана. Болдогсон бол тэр өөдгүй бүүдгэр цонхыг нь хага цохиод урьдын Чинбатыг гаргаад ирэх сэн. Тийм ээ, түүний байх болсон ертөнц Цасчимэгийн хувьд танихгүй харь ондоо нэгэн хорвоо гэсэн үг. Хүн хэвээрээ л үлдэх нь Цасчимэгийн хувьд үхэн үхгэлээ баримтлах зарчим нь билээ. Гэтэл цэл залуугаасаа хөтлөлцөн гүйсээр амьдралын ханиа гэж сонгож, хоёр хүүхдийн эцэг эх болсон, энэ хорвоогийн хамгийн итгэлт эр хүн нь, өөртэй нь адил сүүлчийн амьсгалаа татах хүртлээ хүн чанараа гээхгүй хэмээн найдаж явсан Чинбат өнөөдөр эрх мэдэлд шунасан жирийн нэг өөдгүй амьтан болчих гэж дээ.

За яая гэхэв. Одоо энэ тухай эргэн эргэн бодож зүрхээ зүсч суух цаг нь биш. Хүн өөрөөс нь тусламж эрээд итгэж найдаад ирсэн байна. Зовлонд унаад өөрөөс нь өөр аврал эрэх итгэж найдах ганц ч хүнгүйдээ л ингэж яваа шавьдаа туслах л хэрэгтэй. Нарангийн төлөө ямар нэгэн юм хийх хэрэгтэй хэмээн хүн чанар нь шаардаад байлаа.

-Багш аа, би ... надад ч хэлэх үг алга даа... Би ёстой өөдгүй, азгүй амьтан юм. Надад танаас тусламж гуйх нүүр байхгүй байхад ингээд сууж байдаг...

-Зүгээр, зүгээр. Би ойлгож байна. Өөрийгөө азгүй амьтан гэж бодож л ёстой болохгүй. Үнэнийг хэлэх, өөрийгөө буруутгах зүрх зориг хүн бүхэнд байдаггүй юм. Амьдралд аль хачин юм болохыг тэр гэхэв дээ. Одоо хоёулаа харин яадаг юм билээ дээ. Нэг арга байж л таараа.

-...

Наранд үнэхээр хэлэх үг олдсонгүй. Уруулаа хазлан дэмий л үсээ чихнийхээ араар чихэж суулаа. Харин Цасчимэг үсэндээ хуруунуудаа шигтгэн шанаа тулаад бодлогоширч суугааг тэр хулгай нүдээр хараад харц буруулав.

-Хоёулаа ингэе.

-Аан...

-Чи тэр хүмүүст, юу... баарныханд хичнээн өртэй юм бэ? Тэрийг нь аваачаад өгчих. Санаа зоволтгүй хэлээч.

-Санаа зовмоор юм аа. Би дараа нь ажил хийгээд танд заавал төлж өгнө. Заавал...

-Тэр ойлгомжтой. Би чамд итгэж байна шүү дээ. Тэгээд хэдэн төгрөгийн өртэй хүн бэ, чи?

-Би дүүгийнхээ төрсөн өдрөөр нөөтбуук авч өгөх гээд л өр тавьчихсан юм. Мянган доллар. Надад бараг хоёр зуун доллар дансанд байгаа байх аа. Удахгүй төлчихнө гээд мөнгө цуглуулж байсан юм...

-Тэр чинь одоохондоо байж л байг. Мянган доллар гэдэг миний зургаа, долоон сарын цалинтай тэнцэхээр мөнгө. Бага мөнгө биш л дээ. Дүүдээ компьютер авч өгөх гэж зээлсэн гэдэг чинь харин шал өөр хэрэг. Одоо мэдээж миний түрийвчинд мянган доллар байхгүй. Хоёулаа 24 цагийн банк орьё. Тэгээд дараа нь яах ийхээ шийдье дээ. Тэгэх үү?

-Ёстой их баярлалаа. Би танд заавал төлж өгнө. Заавал...

Тэр хоёр хамт явж банк хүртэл бараг юм ярьсангүй. Тус тусын бодолд автан дүнсийж явлаа. “Энэ тухай Чинбаад хэлээд дэмий байх аа даа. Өнөө өглөө гарахдаа уруул дээр үнсээд аргадангуй байсан. Миний л хань. Чинбаагүй бол түших баганагүй боллоо л гэсэн үг. Эртүүд би Герман явахад нь арай л хэтрүүлчихэж. Өөрөө буруугүй байсан юм болохоор надад уурлаж үнсний сав шиднэ гэдэг чинь багтрахдаа л тэр байж.” хэмээн Цасчимэг нөхрийнхөө тухай сэтгэл эмзэглүүлсэн бодолд автаж явлаа.

Харин Нарангийн хувьд ёстой л нүүрэндээ шир нааж байгаад багшаасаа тусламж авахаар болсондоо баярлахаас илүү сэтгэлийн улам гүнзгий шаналалд автан “Би энэ хүний оронд байсан бол нөхрийнхөө өвөр дээр шалдан сууж байсан хүүхэнд ийм их мөнгө данснаасаа гаргаад өгч чадах байсан болов уу? Хүн болгон адилгүй. Энэ хүнийг яаж өөртэйгээ зүйрлүүлж болохов дээ. Утгагүй юм. За ингээд Цасчимэг багшаас түр ч гэсэн мөнгө аваад өрөө дарах нь. Тэгээд тэр өөдгүй Баясаа руу ганцаараа очилтой биш. Номинг гуйдаг юм бил үү? Ямар ч гэсэн ганцаараа л тийшээ зүглэж болохгүй. Дараа нь яах вэ? Мөнгөө авчихсан гээд ч намайг зүгээр орхичих хүн биш дээ. Өөдгүй шаар...” хэмээн бодож явлаа.

Банкнаас шууд доллар гаргуулж авсан бололтой. Машиндаа ороод арван ширхэг зуутын ногоон дэвсгэрт гарган Наранд өгөхдөө:

-Чи тэр хүмүүстээ өөрөө очоод мөнгий нь өгчих. Тэгээд над руу яриарай. Би чамайг хэд хоног зусланд ээжтэйгээ ханьтай байлгая гэж бодож байна. Тийм улс чинь их аюултай. Нэг хэсэг зусланд буйдхан газар настай хүнд хань болоод байж байвал зүгээр байх. Тэгэх үү? гэж асуухдаа хоолойн өнгө нь зөрөхийн аргагүй шийдэмгий сонсогдов.

Нүднийх нь буланд нуугдсан өнөөх гуниг арилчихсан мэт нэг л өөртөө итгэлтэй, амгалан өнгө оржээ.

-Тэгье. Би ангийнхаа Номинг гуйхаас гэж Наран уриалгахан хэлэхдээ баярласнаа нууж чадахгүй байв. Хувь тавилан хааяа ч гэсэн хүнд ингэж мишээж болдог л юм байна. Ийм сайн хүнтэй учруулах гэж. Зовлонгоо түр ч гэсэн мартагнаад хувь тавилангийн инээмсэглэлд сэтгэл тэнийлгэх гэгч хичнээн сайхан юм бэ?

Багш нь түүнийг Номингийн байрны гадаа буулгаж өгөв. Нар шингэж хаврын намуун орой болж байлаа. Номин ч дорхноо гараад ирэв. Богинохон хар пальто, урт түрийтэй гутал өмсчээ. Гутал нь харваас итали арьсан гутал байв. Богиновтор шулуун үсээ шууж чихэндээ том мөнгөн цагираг зүүсэн нь их л содон харагдана.

Наранг ээмэг рүү нь сонирхон харахыг ажаад жаргалтай хөнгөн инээмсэглэн:

-Барсаагийн бэлэг. Валентины өдрөөр өгсөн байхгүй юу. Би том ээмэг зүүх биш. Зүүхгүй болохоор гомдоод... хэмээн тайлбарласнаа:

-За юу байна? Ингээд над руу хэрэг гарахаараа ярьж бай л даа. Өө, Барсаа хүрээд ирлээ. Аавынхаа машинтай яваа юм хэмээн тайлбарлав. Номингийн найз залуу Барсболд жижгэвтэр хар япон тэрэгтэй ирж зогсоод шилээ буулган Нарантай мэндлэв. Удахгүй хуримаа хийх гэж байгаа эр гэсэндээ нэлээн буурь суучихжээ. Наран хуримынх нь ажилд оролцоно гэж амлачихаад хэлсэндээ хүрч чадахгүй, үнэндээ ч хуримтай манатай яваадаа гэмшил төрнө. Номинд тэр том мөнгөн цагираг нь хөөрхөн зохиж байв. Тэгээд Наран шиг элдвийн юманд шаналж, сэтгэлийн зовлонд унасан амьтан биш. Нүд нь гэрэлтэн цаанаа л жаргалтай харагдана. Гэхдээ найзыгаа нэг л юманд сэтгэл зовоод явааг гадарласан бололтой ашгүй хуримын тухай ярихгүй байлаа.

Ойрд уулзаагүй найзуудын хувьд сонин хачнаа ярилцахын зуурт Наран хүнд юм өгөх хэрэг гараад хань татаж Номинг гуйснаа эвтэйхэн тайлбарлалчхлаа.

-Чи найзтай болтлоо Барсааг заримдаа дуудчиж бай л даа. Тийм ээ, хайр аа? хэмээн Номин эрхлэнгүй асууж элдвийг бодсон шинжгүй явахад Барсаа яагаад ч юм дуу муутай замаа харан давхиж байлаа. Наранг бааранд тайчдаг байсан тухай ямар нэгэн юм сонссон бололтой. Гэхдээ нэлээд санаатай, бас ч гэж зөв хүмүүжилтэй залуу болохоор Номинд хэлэхгүй л дээ. Тэгээд ч Хангалтай одоо ч муугүй харилцаатай хэвээрээ болохоор Нарантай урьдынх шигээ инээж хөхрөөд байж чадахгүй байгаа бололтой. Хангал түүнийг амьдрал доройгоос нь болоод хөндийрсөн ч дотроо бодож л явдаг гэж нэг найздаа ярьсан нь Наранд

сонсогдсон удаатай. Тэгээд бодвол, сургуулиа хаяад алга болсон Наран гэнэт гарч ирээд Номинтой нь нийлэх болсныг Барсаа Хангалд яриа биз. За эрчүүд ч яахав дээ. Хүүхнүүдэд өөдгүй зан гаргадаг мөртөө бие биедээ хачин хайртай улс юм чинь. Тэр ч гайгүй хэвтэнээ. Номинтой л эргээд сайхан харилцаатай болсон нь хамгийн чухал. Хамгийн гол нь Барсаа Наран шиг “явдалтай” охин хонгорхон Номинтой нь үерхэхэд цаанаа дургүй байгаа нь ойлгомжтой хэрэг.

Наран баарны гадаа ирээд Баясгаланд мессеж бичээд гарч ирэнгүүт нь мэнд мэдээд л мөнгийг нь өгөөд эргэв.

-Хонгор минь үлдэгдэл цалингаа бодуулахгүй юм уу? Шувууны ханиадны халдвараас зугтаж байгаа юм шиг хэдэн үг ч солилгүй нүүр буруулдаг байна ш дээ хэмээн үг хаяв.

-Зүгээрээ. Туяд захиад авчихъя. Их баярласан шүү. Баяртай гээд Наран Барсаагийн машинд суун одов.

Энд шөнийн хаалттай клуб байдгийг сонсож байсан Барсаа огцом хаазлан хөдлөхдөө толинд туссан Нарангийн баргар царайг халти хараад л зүгээр нэг хүнд мөнгө өгөх гэж ирээгүй, нөгөө тайчдаг байсан баар нь байх хэмээн яг тааварлажээ. Тийм ээ, Наран ингээд л тэр муу нэр, муухай газраас нэгмөсөн салчих юм сан, цоо шинээр амьдралаа эхлэж үзэх сэн хэмээн чин сэтгэлээсээ хүсч, бас энэ нь хэзээ ч биелшгүй мөрөөдөл юм гэдгийг ч мэдэрч байлаа. Мэдэж байсан учраас ч тийн баргар царайлан гуньж явжээ. Тэндээс хөдлөөд гэрээрээ орж ойр зуурын юмаа аваад Цасчимэгийн ээжийнх нь байрны гадаа хүргүүлэв. Цаг оройн найм өнгөрч цагаан гэгээ тасарч байлаа. Ингээд тэр үдэш нь багшийнхаа ээж хөгшнийг асрахаар Хандгайтын эцэс дэх тохилог зуслангийн байранд хүргүүлсэн Наранг түр орхиё.

Наранг ээжтэйгээ хамт зусланд хань болог гээд хүргүүлчихээд Цасчимэг гэртээ бодолд дарагдан сууж байлаа. Хүү нь тоогоо бодоод хариуг нь шалгуулахаар ирэхэд ч, охиноосоо ирсэн мэйлийг уншиж суухдаа ч гүн бодолд дарагдан, сэтгэл нь чилсэн хэвээр, яг л зүүдэлж байгаа мэт барин тавин хариу үйлдэл хийж байлаа.

“...Ээж ээ, аав та 2 муудалцаад байгаа юм уу? Би та 2-т хоёуланд нь хайртай. Хэнийх нь ч буруу гэхэв дээ. Таны зөрүүд зангаас ч, аавын өдөр шөнөгүй ажилладгаас аль алинаас нь л болсон байх. Гэхдээ Тэнгис бид 2-ыг биш юмаа гэхэд өөрсдийнхөө залуу насыг, бие биедээ хичнээн хайртай байснаа бодоод ойлголцохыг бодооч. Гуйя”. Охиных нь бичсэн урт захидлаас энэ хэсэг л сэтгэлд нь хадагдан үлджээ. Нөхөртөө хэлэлгүйгээр Наранд мөнгө өгч явуулсан, ээждээ ханьтай байлгах нэртэй ч цаанаа өнөөх айхтар улсаас нуух гэсэн бодлоор зусландаа аваачсан. Гэтэл Наран хэдийгээр хоёр жилийн өмнөхөн хамгийн сайн оюутнуудынх нь нэг байсан нь үнэн ч, нөхрийнх нь дайснуудын хатгаасаар өвөр дээр нь гарч суучихаад тэр хоёрын дунд өнөөдрийг хүртэл үргэлжилсээр буй хэрүүлийн алимьг шидэлцсэн хүмүүсийн нэг. Өнөөдрийн зовлон тоочиж түүн дээр ирсэн нь ч худал бааш, бас л ээлжит нэгэн явуулга байж бүрэн болох бус уу? Нөхөртөө урьдынх шиг урьхан аашлан, өөрөөсөө ч илүү итгэе гэж өөрийгөө хичнээн хүчлээд ч чадахгүй болсон нь үнэн. Гэтэл хаа байсан будант Англид суугаа охин нь эцэг эхийнхээ төлөө, угтаа гэр бүл гал голомтынхоо төлөө л юм даа, санаа зовон эвлэрүүлэх гэж ядаж байдаг. Дүү нь эгчдээ бичсэн биз. Хоорондоо найман насны зөрөөтэй эгч дүү хоёр газар дээр хоёулхнаа юм гэсэндээ үнэхээр аминчхан хоёр л доо. Бодоод байхад

өөрийнх нь хувьд ханийгаа ойлгож, санаа сэтгэл нэгтэй байхын оронд хүн чанараа алдлаа, албан тушаалын боол боллоо хэмээн үргэлж зэмлэж буруутгаж байсан нь л их байж уу дээ. Амьдрал мөнхийн хөгжил, хөдөлгөөнд оршдогтоо л үргэлжилж байдаг. Өнө мөнхийн тэр хөгжил, хөдөлгөөн нь бүхнийг өөрчилж байдаг нь жам. Он цагийн уртад Чинбат өөрчлөгдсөн нь ч амьдралын жам гэдэгтэй тэр яагаад эвлэрэхийг үл хүснэ вэ? Анх танилцаж байсан арван тавтай Чинбаа, үерхэн дотносч хайраа ханзалсан арван наймтай Чинбаа, Хонгороо охиноо мөрөн дээрээ суулгачихаад түүнийг хөтлөн инээж явдаг асан хорин тавтай Чинбаа, хоёр хүүхдийн эцэг, гучтай залуухан багш Чинбаа, дөч гарч яваа, төрийн өндөр алба хаших болсон өнөөдрийн Чинбаа бүгд хоорондоо ялгаатай шүү дээ. “Хэвийн сэтгэлгээтэй хүн амьдралдаа ганц л удаа хүчтэй дурладаг. Яахав зүгээр шохоорхол, сээтэгнэл л байдаг байх. Миний хувьд амьдралдаа хайрлаж дурласан ганцхан хүүхэн бол чи. Цаашдаа өөр хүүхэнд дахиад тэгж дурлах хүчин чадлын нөөц ч гэж надад үнэндээ алга. Гёте, Пикассо мэтийн яруу найрагч, зураач элдэв суутнууд л наяд хүрчихээд дурлаж суудаг байх. Тэд чинь хэвийн биш, сэтгэцийн хувьд өөрчлөлттэй хүмүүс байсан гэж байгаа юм ш дээ.” хэмээн нөхөр нь хэдэн жилийн өмнө Цасчимэгийн төрсөн өдрийн үдэш ярьж байж билээ. Цасчимэг хүүгээ унтуулчихаад маргааш унших лекцээ хэсэг харж сууснаа босч унтлагын өрөөндөө ороод сарын өмнө нөхрийнхөө авчирч өгсөн өнөөх хайрцагтай бэлгийг гоёлын ширээнийхээ нүднээс авч задлав. Хөх ягаан цаасаар ороосон жижигхэн хилэн хайрцгаас хийц нь энгийн атал цаанаа л чамин цагаан алтан бугуйн цаг гарч ирлээ. Зургаан ширхэг циркон шигтгээтэй, нүүрийг нь бяцхан хавхлагаар таглачихвал цаг биш бугуйвч мэт харагдахаар гоё эд байлаа. Бүсгүй нэг л мэдэхэд өнөөх цагийг бугуйндаа зүүж үзээд “Ямар гоё юм бэ?” хэмээн ганцаараа дуу алдчихсан байлаа. Тэгээд хуучин цагаа шүүгээний нүдэнд хийгээд нөгөө шинэ цагийг маргааш зүүж явахаар шийдэн орныхоо дэргэдэх түмбүүшиг дээр тавилаа.

Тэгээд нөхөр рүүгээ залгавал утас нь яриад байлаа. Яая гэхэв, завгүй л байгаа биз дээ. Сэтгэл нь нэг л уярч хайлаад байх шиг. Бодож бодож “Охиноос мэйл ирээд. Чи минь биеэ бодоорой. Найз нь унтлаа” гэж бичээд явуулчихав. Охиноос мэйл ирэх гэдэг ердийн явдал ч гэсэн нөхөртэйгээ эвлэрэх гэж ядаж байхад мессеж бичих аятайхан шалтаг биш үү?

Амьдрал заримдаа өчүүхэн юманд дэндүү хяслантай. Энэ олон хоногийн хүйтэн харилцаа нь арай ядан гэсэх гээд ядаж байхад Цасчимэгийг залгах тэр үед Чинбат руу нөгөө Алтанзагас хүүхэн ярьж байжээ. Хоёр ч удаа гэрт нь очиж энэ хүүхэнтэй хонохдоо гэр бүлийнхээ таагүй уур амьсгалыг мартагнаж, сэтгэлээ жаал тайвшруулья гэж бодсоноос биш сэтгэлийнх нь аль ч буланд түүнийг багтаах зай, энэ тэр болоод байх тэнхэл ч мань эрд байсангүй. Гэтэл нөгөө айхтар хүүхэн нь салахгүй наалдчих санаатай.

-Би байна. Загасаа байна . Чи минь ажил дээрээ л сууж байна уу? (Хэдийдээ “чи минь” болчихдог байна. Иймэрхүү хүүхнүүдэд нүүр өгч болохгүй юм гээч).

-Аан за, за. Дотроо хүүхнээс төвөгшөөж байгаагаа нууж чадахгүй байв.

-Зүгээр л намайг мартаагүй биз дээ гэж ярьж байгаа юм. Чи ядраа юу? Дуу цөөтэй байх чинь.

-Би юу? Ажилтай л суугаад байна.

-Болиоч ээ. Арван хоёр болж байхад ажилтай гээд сууж байдаг. Ертөнцийг ганцаараа бүтээх гээд байгаа юм уу даа? Маргааш манайд ирэхгүй юм уу? Би чамайг санаад л...

-Аанхаан. Тэгээд залгая, тэгэх үү. За баяртай.

-Баяртай.

Арай гэж нэг салах шив. Нойтон хамуу л гэсэн үг. Дэмий л энэ хүүхэнтэй орооцолдлоо. Пандагын хэлдэг үнэн л болоод байх юм гээч. Утсанд нь мессеж ирэв. Хэн байдаг байна? Хайхрамжгүйхэн хараад сэтгэл нь залуугийнх шигээ догдлоод явчихав. Эхнэр нь, Чимгээ мессеж явуулсан байв. “Охиноос мэйл ирээд... Биеэ бодоорой...” Чимгээ ухаантай хүн. Зөрүүд ч хүүхэн. Үүнээс илүү нялуурч чадахгүй л дээ.

Өөрөө ч өнөөдөр ажлынхаа заваар мэйлээ шалгаад амжсан. Охин нь бут авсан байсан. Бут авах ч гэж. “Аав аа, би ээж та 2-т хоёуланд нь хайртай. Та 2-ыг хоорондоо муу байгаа гэж Тэнгис бичсэн. Ээж дөч гартлаа л бид 3-ын төлөө гэж явсан. Таны хувьд ээжид илүү их анхаарал тавих, ойлгох хайрлах хэрэгтэй цаг үе нь одоо л ирээд байна. Таныг завгүй байгааг мэдэж л байна. Гэхдээ гэр бүл хүний хамгийн чухал зүйл шүү дээ. Та залуудаа ээжид ямар их халамжтай байлаа. Би жаахан байхдаа яг л аав шигээ хүнтэй л сууна гэж боддог сон. Одоо харин тэгж бодохоо болиод байна. Яагаад гэдгийг та өөрөө мэдэж байгаа байх. Өнөөдөр та ээжид цэцэг аваачиж өгөөрэй. Сайндъя гэвэл амархан ш дээ. Заавал шүү, гуйя.” гэсэн байсан.

Хонгороо нь үнэхээрийн ухаантай охин шүү. Ээждээ бас л баахан юм бичсэн байх нь. “Сайндъя гэвэл амархан”... энэ үнээн. “Ээжийг ойлгох хайрлах цаг нь одоо л ирээд байна” энэ бүүр ч үнэн. Өөрт нь өгсөн харамгүй хайр, цэл залуу насных нь төлөө Чимгээг тэр хайрлах сэтгэлийн их өртэй... Мань эр эхнэрийнхээ мессежийг аваад уярсандаа эргүүлээд залгах гэснээ болив. Маргааш хөдөө буцах гээд байгаа хоёр аймгийн засаг даргатай уулзчихаад нэгмөсөн харьдаг хэрэг. Цэцгээ барьж ороод сюрприз барья гэж бодоод болив.

Цасчимэг нөхрөө хүлээн нэлээд суугаад маргааш нь эрт хичээлтэй тул 00 цаг хүргээд орондоо оров. Гурван жилийн өмнө бил үү дээ. Яаманд газрын дарга байхдаа хуримынхаа ойгоор хачин завгүй амьтан Налайх явчихсан шөнөдөө л ирнэ гэж утасдаад л байсан. Жил жилийн наймдугаар сарын 02-ныг заавал хамтдаа тэмдэглэдэг, “Чи минь өөрийгөө надад бэлэглэсэн өдөр” гээд сэтгэлийн бэлэг бэлтгэн баярлуулдаг нь энэ жил худлаа болох нь хэмээн Цасчимэг урамгүйхэн яг л өнөөдрийнх шиг хүлээсэн сэтгэл чилээстэй горьдлого тасрах тал руугаа. Усанд орчихоод унтъя даа гэсэн бодлоор онгоцтой халуун усанд хэвтэж байтал нь хаалга дуугарах шиг болоод л угаалгын өрөөнийх нь хаалгаар бүтэн тэвэр гал улаан сарнайн баглаа ороод ирж билээ. Гэнэтийн баяр хөөр бэлэглэсэн баглаа цэцэгний цаана Чинбаа инээчихсэн зогсч байсан сан... Хайрт нь тэр их ажлынхаа хажуугаар шөнийн 00 цагт гэргийдээ хуримын ойн баяр хүргэх гээд насных нь тоогоор тэвэр дүүрэн сарнайтай ирсэн нь л тэр чигээрээ бэлэг байсан... Ийнхүү сайн сайхан гэрэлт дурсамжууд сэтгэлд мартагдашгүй олноороо байтал эхнэр, нөхөр хоёр муудалцахаараа юунд хамаг болохгүй бүтэхгүй бүхнийг сэргээн бодож сэтгэл зүрхээ гуниглуулан ахин ирэхгүй амьдралын гэрэлт өдрүүдээ сүүдэрлүүлэн хоёр сэтгэл хөндийрэн хүйтэрдэг юм бол доо хэмээн бодохоор өнөөдрийг хүртэл нөхөртэйгээ эвлэрчихээгүй өчнөөн олон хоногийг хэрүүлтэй өнгөрөөсөндөө харуусал төрнө. Гэр бүлийн амьдралыг аятай найртай авч явна гэдэг, эхнэр нөхөр хоёрын биенээ

ойлголцон хайрлана гэдэг хичнээн их тэвчээр, ухаан шаарддаг хэцүү эд юм дээ. Бүхэл бүтэн урлаг юм даа гэж бодон хэвтсээр унтчихжээ.

Чинбатын хувьд тэр үдэш цэцгээ аваад гэр рүүгээ харих гэтэл Пандага нь утасдаад яаралтай уулзах хэрэг гарсан тул эхнэрээ унтахаас өмнө харьж чадсангүй. Гурав хоногийн дараа хөдөө явахтай нь холбоотой яаралтай хэлэх юм гараад хэмээн найз нь утасджээ.

-Хөдөө явахад чинь нэг юм болох нь. Чи яваад хэрэггүй.

-Явах хүмүүсийн нэр гарчихсан. Би явах ёстой.

-Хэрэггүй. Автын осол ч юм уу, нэг юм болно. Бүр зохион байгуулчихсан... Би найдвартай эх сурвалжаас тийм мэдээ авлаа.

-Би тэгээд үхэх ёстой болох нь ээ?

-Цэвэрхээн автын осол юм шиг харагдах ёстой. Хэрэггүй, өөр хүн явуул. Ямар ч хамаагүй нэг шалтгаар хөдөө явахаа л боль. Би нарийн ширийнийг нь үнэхээр мэдэхгүй. Ямар ч гэсэн нэг юм болгох гээд зохион байгуулж байгаа бололтой. Чи сайд болох хамгийн боломжтой хувилбар. Дэмжлэг ч ихтэй байгаа юм байна. Гэтэл тэр суудлыг алдаж болдоггүй.

Чинбат гүн бодолд оров. Түрүүхэн гэр рүүгээ яаран нялхарч байсан сэтгэл нь хүйтрэн дасал болсон ажил хэргийн ертөнцөд эргэн ирэв.

-Ирэх баасанд миний нэрийг намд хэлэлцээд дараа нь байнгын хорооны хуралдаанаар оруулна гэж Гишүүн хэлж байсан. Тэрнээс өмнө тийм сюрприз бэлтгэжээ гээд найз руугаа харав.

-Байнгын хороог хуралдуулахгүйн төлөө бүхнийг хийнэ гэсэн үг.

-Энэ сард хэд хэдэн тендерийн эцсийн шалгаруулалт болох ёстой.

-Ээ дээ. Үгүй ядаж танай орлогч үүрэг гүйцэтгэгчээрээ яваад байхыг бодноо доо.

-Үнэндээ миний хувьд заавал сайдын суудал руу зүтгээд байх сонирхол алга. Бүлэглэлийн эрх ашиг л илүү шахаад байгаа юм.

-Салбараа мэддэг, хамгийн нэр цэвэр байгаа хүн нь чи гэж байгаа. Ганцхан жилийн дараа сонгууль болно. Танай нам одоо гарахгүйгээ мэдээд хүмүүс нь улайрчихаж. Миний найз нэрээ татчихсан нь дээр ч юм шиг.

Энэ үеэр нөгөө Алтанзагас хүүхэн дахиад л залгав.

-Яршигтай хүүхэн бэ гээд Чинбат утсаа таслахдаа найз руугаа хяламхийв. Гэр бүлийн талаар өө сэвгүй гэдгээрээ найзууддаа их л үлгэртэй эр атал сүүлийн үед иймэрхүү юманд холбогдох болсондоо сэтгэл зовох ч шиг.

-Нөгөө Цагаанаагийн явуулга таг болсон уу?

-Тэгээд чимээгүй болсон.

-Чимгээд цэцэг аваа юу? Тэгмээр дээ.

-...

Найзынх нь утас дуугаран тус тусынх нь бодлыг үргээж орхив. Ганцхан сулхан жингэнээд тасардаг дуутай атал цаанаа л нэг хоржоонтой сонсогдох аж.

-Насаа байна гэж Пандага хэлээд утсаа авч их л уриалгахан дуу гаргахыг хичээж буй нь илт:

-Байна, хөгшөөн. Чинбаатай л яриатай сууна. Та хэдээр юу байна? гээд шилэн аягтай усаа балгах зуур Чинбат руу хяламхийх аж.

-Чимгээд үү? За. Чи минь хэвтэж амар даа хө. Бид хоёр удахгүй дээ. Шууд, шууд. Жижгүүлэй унтаагүй юм уу? Аав нь очлоо гэж хэл. За, за. Шөнийн дэлгүүрт байх уу? За.

-Насаа л шалгаж байгаа тэр. Манай Жижгүүлэй жимстэй тараг иднэ гээд байна гэнэ. Хүүхдээрээ сайхан бамбай барина шүү дээ. Чимгээд мэнд хүргэж байна.

-Баярлалаа, дамжуулъя.

-Нээрээ, танай Жижгүүлэй том болоод л байна уу?

-Одоо гүйж байгаа. Гэр рүү намайг чангаадаг ганц аргамжаа шүү дээ гээд отгон охиноо өхөөрдөн инээмсэглэсэнээ:

-За, тэгээд чи хөдөө явах өөр хүн томил. Нэг юм болох гээд байна гэж хэлэхдээ хүүхдээ өхөөрдсөн өнгө өөрчлөгдөн харц нь ширүүн болжээ.

-Би л чиний оронд байсан бол сайдад нэр дэвшихээс татгалзана.

Цаана чинь танай намынхан цагаандаа гарч байна. Аягүй бол нэг өдөр буудалцана. Чимээгүйхэн буудалцаад эхэлчихсэн. Танай талийгч сайд үхэх жамаараа үхээгүйг санаарай. Замд нь тээглээд байгаа хэнийг ч амархаан зайлуулчихна.

-Би бодоод л байна. Гэнэт хөдөө явахаа больчихлээр хайшаа ч юм дээ. Би ахалж явах ухаантай юм сан.

-Шалтаг ол. Яваад хэрэггүй.

-Тэгье дээ.

Цаг хэдийнээ шөнийн хоёр өнгөрчихжээ. Найз нь Жижгүүлэй гэдгээс өөрөө

дууддаггүй отгон охиныхоо тухай тасралтгүй өхөөрдөн ярьсаар гэр рүүгээ салан одов. Пандагын эхнэр хоёр жилийн өмнө дөчин насныхаа босгон дээр гэнэт хэнз охиноор нөхөртөө бэлэг барьсан нь тэдний гэр бүлээр тогтохгүй дөч хэдийнээ хэвийсэн найз нарынх нь дунд бөөн яриа хөөрөөний сэдэв, дуулиан шуугиан мандуулаад авсан билээ. Аль залуу цагаасаа л хоёр биендээ тийм ч халуун дотно биш, цэвэр тооцооны гэр бүл юм шиг харагддаг байсан энэ айлын эхнэр, нөхөр хоёр хүүхдүүдээ том болох тусам улам л хөндийрөөд байсан нь мэдээж. Тэгээд ч найз нь хотын цагдаагийн удирдлагад гайгүй албан тушаалтай болоод хэлтсийнхээ нэг аятайхан бүсгүйтэй жиг ургуулсан нь золтой л оронгий нь тараачихсангүй. Эхнэр нь хэцүү хүүхэн тулдаа нөхрөө буцаан авчраад зогсохгүй бяцхан гүнж төрүүлэн сэтгэл санаагийг нь аргамжих аргаа олоод авсан юм санж. Насаа хүүхдийн угаалга дээр “Энэ амьтан бол манай гэр бүлийн авралын од байгаа юм” гэж хэлээд нөхөр рүүгээ галтай харц шидлэн тас тас хөхөрч байсан билээ. Харин Цасчимэгт тэр үг нь таалагдаагүй. Нялх хүүхдээр торгоож тогтдог гэр бүл, сэтгэл зүрх гэж юу байсан юм, тэрнийгээ зочдодоо хэлээд байхдаа ч яахав хэмээн үдэш нь харих замдаа түүнд дургүйцлээ илэрхийлж байж билээ.

Түүнийг гэртээ ирэхэд эхнэр, хүү хоёр нь унтчихсан байлаа. Мэдээж хэрэг шөнийн хоёр цаг өнгөрчихсөн байхад. Тэр гутлаа тайлаад оймстой хөлөөрөө чимээгүйхэн алхлан хүүгийнхээ өрөө рүү орж духан дээр нь үнэрлээд хэсэг зогсов. Энэ хүүхдийг долоон насандаа сургуульд орсон тэр цагаас хойш таван жил эцгийн үүргийг бараг биелүүлсэнгүйгээ бодоод гэмших сэтгэл төрнө. Яг яаманд хэлтсийн даргаар орсон жилээс эхлэн хүүгээ ихэвчлэн ингээд дуг нойрондоо байхад нь гэрийн бараа харсаар таван жил өнгөрчихөж. Тэр үед Тэнгис “Аав аа, эрт ирээрэй. Байлдаж тоглоё” гэж их гуйдаг сан. Тэгэхэд хүү нь үүдэн шүднүүд нь унаад эмсгий ам гаргачихсан, жижигхэн биетэй сөөсгөр амьтан байж билээ. Гэтэл одоо үсээ элдэв маягаар засуулан, нэг харахад л өөр янз болгочихсон явдаг, компьютер ухаад чимээгүй сууж байдаг, бараг ээжтэйгээ чацуу шахуу том эр болтлоо огцом өсчихөж. Энэ өнгөрсөн таван жилд хүүгийнхээ хичнээн том болж, өссөнийг тэр одоо л анзаарч байна гэж үү дээ? Тэнгис аавыгаа байлдаж тоглоё гэж гуйхаа хэдийнээ больчихож. Одоо бараг охин эргүүлж байгаа биз хэмээн бодоод инээмсэглэв. Мань эр унтаж буй хүүгийнхээ орны өмнө жижиг сандал тавиад хэсэг харж суув. Эгчдээ ээж, аавыгаа “матаад” эвлэрүүлчихэж дөнгөсөн л байгаа юм даа.

Хүү нь ширээн дээрээ сурлагын дэвтрээ дэлгээд орхичихож. Авч үзвэл тоон дээрээ А авчихжээ.

-Эр хүн. Аавдаа үзүүлэх гээд сурлагын дэвтрээ дэлгээд тавьж дээ. Эгч нь бас онц сурлагатан байсан юм чинь.

Мань эр нэг л мэдэхэд өөрийнхөө “амины” хүүхдээ бодоод инээмсэглэв. Хүү нь бол нарийндаа “ээжийн хүн” л дээ. Тэр босч хүүгийнхээ духан дээр үнэрлээд гарав. Эхнэр нь унтаж байснаа “Чинбаа юу?” гээд өндийгөөд ирэв. Бугуйндаа нөгөө бэлэгний цагийг нь зүүгээд унтсаныг нь анзаараад “Чи минь унт даа” гээд очиж үнсэв. Чимгээ тэгтэл түүнийг хүзүүдээд авчээ...

Тэр үдшээс хойш гурав хоног өнгөрөв. Хөдөө явах хүмүүсийг Стратерги, төлөвлөлтийн газрын даргаар ахлуулаад, өөрөө нийслэлээс сонгогдсон тойрогтоо шинэ дэлгүүрийн нээлтэд очих шалтаг олж дөнгөжээ. Хотын ойролцоох нэгэн хаягдсан бяцхан сууринаас тэр

нийслэлийн иргэдийн хуралд сонгогдсон юм. Тэнд шинэ супермаркет нээгдэхээр болж, тэр нь хөдөө явах өдөртэй нь давхацсан нь аз болов.

Өглөө Чимгээд хөдөө явна гэж хэлээд гарсан. Сүүлийн үед Чимгээ тэр хоёрын хувьд бараг л мартагнаад байсан янаглалыг сэргээсэн тэр нэгэн үдшээс хойш сэтгэл санаа тайван, хоорондоо эвтэй гэж нуур нугас шиг байтал өчигдөр орой нөгөө Алтанзагас гэр рүү нь дахин дахин утасдаад хамаг юм бусниулчихаа дөхөөд байлаа.

-Чинбаатай ярья, Загасаа залгасан гээрэй гээд нэг нялуун дуутай хүүхэн утас амрахгүй юм. Чи чинь тэр элдвийн хүүхнүүддээ гэрийн утсаа өгдөг нь юу юм? гэж эхнэр нь өнөө өглөө ууртай хэлээд хаалга саван гарч одсон. Тэр хоёрын харилцаа арай ядан эвлэж байгаа хагархай шаазан шиг хэврэг байгааг хэлэх үү? Баларсан хүүхэн. Чимгээтэй муудалцчихсан яваад л санаадгүй танилцаад, хэдэн удаа гэрт нь хоночихсон нь дэмий юм болж. Хэдэн удаа ч гэж хоёр удаа л очсон. Хүрэлхүү дараа нь нэг тааралдаад “За Загасаа ямар байна? Чамд л гэж зориулж аваачсан хүүхэн шүү дээ. Чамайг чинь урьд нь авгайгаасаа өөр хүүхэн татаж чангаахгүй болохоор сулралтай эр юм уу гэж боддог байсан чинь үгүй юм аа...” гээд инээж байсан. Пандагын хэлснээр тэр хүүхэнтэй орооцолддог нь үнэхээр дэмий юм болжээ. Өөр рүү нь залгаад пааслаад байснаа үр дүнд хүрэхгүй болохоор нь гэр рүү нь утасдан авгайг нь оролдож эхэлдэг байна. Хэдэн төгрөг өгөөд салъя байз хэмээн төвөгшөөнгүй бодож, орой ирээд л Чимгээтэй учраа ололцье хэмээн бодоод туслахаа дуудав. Зөгийн балтай орос бялуунд Чимгээ нугасгүй.

-Цогтоо, орос тоортны газарт зөгийн балтай тоорт захиалчихаарай. Би тойрог руугаа дэлгүүрийн нээлтэд явангаа хүмүүстэй уулзалт хийгээд үдээс хойш ирнэ. Өнөөдөр өөр юу билээ?

-Таныг хөдөө явна гээд түрүү долоо хоногт төлөвлөчихсөн байсан болохоор бараг хоосон байгаа. Радиогийн сурвалжлагч нэг хүүхэн ярилцлага авья гээд яваад байсан.

-Юун тухай?

-Өчигдрийн Засгийн газрын хуралдаанаар шийдсэн тогтоолын талаар.

-Тавын үед ярилцлага өгье.

-За.

Тэр өглөө Цасчимэг сэтгэл тавгүй байлаа. Нөхөртэйгээ эвлэрээд нөгөөх нь ч түүнд хайр халамж тавиад хичнээн сайхан байлаа. Залуу нас нь, бие биенээ гэсэн халуун хайр нь хавартай цуг эргэн ирэх шиг. Гэтэл нэг балай хүүхэн оройжин утасдан Чинбатыг асуугаад зүрх сэтгэлийг нь төмрөөр сэндийчээд хаячих шиг болгочихжээ. Наранг нөхрийнх нь өвөр дээр суулгаж байгаад өөрийг нь дуудчихаж байгаа юм чинь нэг байтугай нэлээд хэдэн хүүхнийг гэр рүү нь яриулж болно. Энэ бүхэнд эмзэглээд байх юм бол гэр бүл нь сүйрнэ гэдгийг эрүүл ухаан хэлээд байвч хоёрхон хоногийн өмнөх эвлэрэл, сэтгэлийн амар амгаланг нь тэр наалинхай дуутай хүүхэн эвдээд хаячихаж дөнгөв. Тэр ядарчээ. Эгнэгт эргэн ирэхгүй юм шиг санагдах итгэлцэл, эв найртай сайхан харилцаа, амьдралыг сүүлчийн мөч хүртэл

хамтдаа, нэгэн сэтгэлээр туулна гэсэн найдвар... Хайртай хосууд өөд, өөдөөсөө ширтэлцэн суух биш нэгэн зүгт харах ёстой гэдэг дээр хичнээн сайхан санаа нийлэн, бараг л ганц харцаараа ойлголцож чаддаг байсан хань нөхөртөө яагаад итгэж чадахгүй болоо вэ? Шалтгаан нь юу байж болох вэ? Дөчөөд настнуудын хямрал, хайр сэтгэлийн мөхөл, уйдалт, гэр бүлийн амьдралын мухардал... аль нь болж таарч байнаа? Гадаа нойтон цас, бороо холиолдон орж, тэнгэр гэж өөрийнх нь сэтгэл шиг бүүдийсэн юм байлаа. Хичээлийн завсарлагаар ээжтэйгээ утсаар ярив.

-Бие гайгүй. Ёстой ажилтай, нямбай ийм охин хаанаас олоо вэ? Бид хоёр хууч хөөрөөд, салхилаад сайхан байна. Өнөөдөр тэнгэр муухай болохоор харин гарсангүй. Над шиг хоолны дэглэмтэй хүнд тохирох нарийн ногоотой хоолыг Нараа мөн ч сайхан хийх юм аа. Чинбаагийн ажил сайн уу? Сайд майд болох гээд байна гэж сонинд бичих юм. Юу болж байна? Охин утсаар ярив уу? гэхчлэн ээж нь уйдсан бололтой хууч дэлгэхээ дөхнө.

Ашгүй Наран ээжид нь хань болоод гайгүй сайн асраад байгаа бололтой. Нагацын талын хөдөөний нэг охиноор ээжийгээ хэсэг харуулсан боловч ажил мэдэхгүйн дээр хоолны нарийн дэглэм сахидаг, тэгээд өөрөө ажил сайн болохоор хэр баргийн хүн санаанд нь таардаггүй ээжид нь шууд гологдож билээ. Тэгээд ээжийгээ асрах хүн олох гэж бас нэг толгойн өвчинтэй болоод байхад нь Нараа гараад ирсэн нь бас аз байлаа.

Хичээлээ арай дуусаагүй байтал нөхөр нь утасдан хөдөө явах болсноо хэлэв.

-Сайн яваад ирээрэй. Хоолоо идсэн юм уу? Цасчимэг аман дээр гараад ирсэн “Хайр аа” гэсэн үгийг хэлэх гэснээ зөрүүд нэгэн бодол нь хөндөлсөн босоод буцаан залгичихав.

-Миний хайр битгий ядраарай. Маргааш хоёулаа хамт өдрийн хоолонд орноо.

-Тийм хурдан ирэх юм уу?

-Оройдоо л хүрээд ирнэ.

-За.

-За орой хүртэл баяртай, Чимгээ.

-Баяртай.

Сэтгэл нь цэлмээд ирэв. Хүний сэтгэл гэдэг учир нь олдохгүй эд юм даа. Нэг болохоор өчүүхэн жаахан юманд эмзэглэж шархлаад, эсвэл дорхноо хөөр баярт автагдаад л.

Үдийн цайгаа уучихаад хүүгийнхээ багштай уулзаад Тэнгистэйгээ хүнс цуглуулаад гэртээ ирэхэд оройн тав өнгөрч байлаа. Гэтэл ах нь утасдан:

-Сонины сурвалжлагч таньдаг хүүхэн нэг хачин юм хэлэх юм. Миний дүү битгий цочирдоорой. Сайн асууж сураглая. Чинбааг хөдөө энүүхэн Лүнгийн тэнд осолд ороод муу байна гэсэн мэдээ ирлээ гэх юм...

-Юу?.

-Яамныхан нь осол гарсан сурагтай. Ажлын хэсгийг хэн ахалсныг мэдэхгүй гэгцгээх юм. Цогтоо бас утсаа авахгүй юм...

-Гар руу нь залгасан салгаатай байх юм

Нүд нь харанхуйлаад явчихлаа. Хэдхэн цагийн өмнөхөн утасдаад “Миний хайр битгий ядраарай” гэж дотно дулаахан хэлж байсан нь, өглөө тар тур хийгээд хаалга саван гарахад нь дуугүйхэн кофе оочлоод хоцорсон нь, “хайр аа” гэж хэлэх гэснээ больчихсоноо санаад ухаан балартан унажээ. Хүү нь сандран түргэн дуудаж, эмээ рүүгээ утасдав. Аавынх нь утас салгаастай байлаа. Сандарсан хүү ээжийнхээ ах Ууганбаяр руу залгав. Учир битүүлэг энэ мэдээг анх дүүдээ сонгосон ах нь ухаан малгайгүй сандран түргэний эмчээс түрүүлэн хүргэнийдээ давхиж ирлээ. Цасчимэг түргэн ирэхээс өмнө нэг урт санаа алдаад ухаан орлоо. Бэргэн эгч хүү хоёр нь дэргэд нь сууж байлаа. Ах нь ээжийг нь зуслангаас авчрахаар явжээ.

Бэргэн эгч нь:

-Чимгээ, миний дүү яаж байна? Ёстой сандаргалаа шүү. Чинбаа тэр машинд байгаагүй, яамных нь газрын дарга явсан гэнэ. Төрийн нарийн бичиг ахалж явах байснаа гэнэт больчихсон юм байна. Чинбаагийн хөдөө явахдаа унадаг машин онхолдсон болохоор сэтгүүлчид төрийн нарийн нь осолд орж гээд шуугичихсныг манай Ууган гэж нэг сорог юм халти сонсоод учир начрыг нь тодруулахгүй чамд хэлээд гайгаа чирч байх юм зүгээр хэмээн ярьж хүйтэн юм уулгаж байх зуур түргэний эмч ирлээ. Нөхрөө зүгээр гэдгийг сонсоод сульдсан зүрх нь хэсэгхэн амсхийх шиг болоод дахин хүчтэй агшиж, тархи нь мэнэрээд ирэв.

-Зүрхний цохилт сул, даралт нь хоорондоо ойртсон байна. Хэвтэх шаардлагатай гэж залуухан эрэгтэй эмч хэлээд клиникийн төв эмнэлэг рүү аваад давхичихлаа. Эмнэлэгт ирээд хэд хэдэн тариа хийлгээд бие нь жаахан дээрдэж байтал ээж нь ирэв. Ах нь мэдээж ээждээ загнуулсан болтой араас нь дуу шуугүйхэн орж ирэв. Хамгийн сүүлд Наран шагайж зогсоно.

-Охиныхоо хойно орж байгаа юм байх гэж л саналаа. Ёох, ёох гэсээр барагтай бол нулимс унагадаггүй хөгшин нулимс дуслуулан хөнжлөөс нь тэврээд авлаа.

-Ээж, би зүгээр, зүгээр. Баахан хүн сандаргачихлаа. Хадам аавыг битгий дуудаарай.

Энэ үеэр Чинбатын туслах Цогтбаяр зөгийн балтай бялуу барьчихсан сандран гүйж ирэв.

-Дарга Өвөрхангай яваагүй юм. Би ордон дээр хуралд суугаад утсаа салгачихсан байсан. Ууган ах хэд хэд залгасан байна лээ. Тэнгисээс мессеж аваад сандарлаа. Чимгээ эгч бие яаж байна? Даргын утас сүлжээ нь унасан байх юм. Өөрийнх нь тойрог болохоор уулзалт хийнэ гэж байсан. Дарга өглөө явахдаа танд зориулж энэ тоортыг захиалаарай гэсэн юм... Аваад ирлээ. Энд тавьчих уу?

Сульдсан зүрх нь энэ үгийг сонсоод өөрийн эрхгүй уяран хайлаад явчихлаа. Дуртай

бялууг нь захиалуулаад өөрийг нь бодож л явсан байна, хань нөхөр нь. Сувилагч ирж эргэлтийн олон хүнийг өрөөнөөс хөөн гаргаж, ээж нь ганцаараа үлдэв.

-Хүнд хань ганц заяадаг юм. Хоёр биенээ гэж яв. Би чамд хичнээн хэлдэг билээ. Намайг өөр шигээ их ном уншаагүй, эд бараа л сонирхдог гээд үгий минь сонсох биш дээ. Амьдрал гэдэг номыг ээж нь харин ч гадарлана шүү гээд л бууж гарах шинжтэй. Цасчимэг чимээгүй л сонсч хэвтлээ. Эцэг эх ч мөнх бус. Аавыгаа алдаад гашуудаж явсан өдрүүдээ мартчихсан л юм байх даа. Муу ээжийнхээ үгийг сонсохгүй явсан нь тэнэгийнх л байж дээ. Одоо ч ээж нь голыг нь гогодсон үг хэлж байна шүү.

Чинбатыг осолд орж гэсэн эндүүрэл Наран, Цогтбаяр хоёрыг ёстой л санаандгүй учруулчихав. Эмнэлгийн цав цагаан хонгилд хоёр залуу бие биенээ анх хараад л сэтгэл алдарчээ.

Цогтбаяр бол Цасчимэгийн бэргэн эгчтэй ойрын төрөл тул Наранг тэдний хамаатан гэж хэлж болохгүй байлаа. Цасчимэгийн бэргэн эгч Жаргал хэл амтай, түргэн аашгай ч сэтгэл сайхантай, тэднийд бэр болж ирснээс хойш төрснөөс дутуугүй ижилдсэн ховорхон бэргэн. Тиймээс цөөхөн хэдэн хамаатныг нь арван хуруу шигээ мэднэ. Заримдаа Цасчимэг түүнийг ахын авгай гэдгийг нь мартаад ахыгаа манай хүргэн ч бил үү гэж бодчихоод байх юм гэж ярьдаг нь хошигнол гэхээсээ үнэн бодол нь болчих шахдаг юм. Нүдээрээ инээмсэглэсэн намхавтар нуруутай, ухаалаг харцтай цэвэрхэн залуу Нарангийн нүдэнд шууд туссан бол гүнзгий хар нүдтэй, даруухан атлаа нүд булаасан бүсгүй Цогтбаярын харцыг булаажээ.

Санаандгүй энэ эндүүрэл Цасчимэг, Чинбат хоёрын ужиг удаан хөндийрлийг нэгмөсөн арилгаж, хоёр залууг учруулсан сонин учрал болоод өнгөрөв. Хэдий эхнэртэйгээ бүрэн эвлэрч сэтгэл нь нэг талаар жаргалтай байвч, Чинбатын хувьд бодох юм их байлаа. Пандагын зөвлөснөөр хөдөө явах өглөөнөө гэнэт өөр хүн томилсноор гэмгүй явсан нэгэн залууг осолд оруулсан буруутай юм шиг санагдана. Үнэхээр өөрийг нь сайдад нэр дэвшигчдийн жагсаалтаас хасахын тулд тэр осол гарсан байх нь.

Машинд явсан дөрвөн хүний жолоочоос бусад нь гэмтэж, өөрийнх нь оронд явсан газрын дарга залуу ухаангүй эмнэлэгт хүргэгджээ. Дор хаяж мянга шахам километр зам туулах машины хойд дугуйн эрэг боолтууд ганцаас бусад нь сулраад салж унахад бэлэн байж. Хотоос гараад бартаат замд ормогц баруун хойд дугуй нь салж замын хажуу руу хоёронтоо эргэлдэн онхолджээ Хөдөө явах машины техникийн бүрэн бүтэн байдлыг хянаагүй баазын дарга мэдээж цэвэрхэн үлдэж, ядарсан механикч залууг ажлаас нь халаад л өнгөрөв. Хамгийн сүүлд машиныг замд гарахад бэлтгээд хүлээлцсэн техникийн акт хаашаа ч юм алга болжээ.

Гэтэл энэ бол зохион байгуулалттай явуулга байсныг Чинбат мэдээд байдаг. Хэн ийм юм хийдэг байна? “Найз минь, чи юу ч нэмж мэдээд хэрэггүй. Аминд чинь халтай.” гэж Пандага ослын дараахан нэг удаа хэлжээ. Өөрийнх нь оронд бурханы оронд одооо алдсан газрын дарга залуу сарын дараа овоо бие нь сайжран ажилдаа орсноор Чинбатын сэтгэлийн чилээ сая нэг гарч санаа амрав.

Тавдугаар сарын эхэн. Цасчимэгийн ээж эмнэлэгт хэвтэх болж зуслангаас бууж ирлээ. Наран ч энэ хэсэгхэн хугацаанд эмээ шигээ ижилдэн дассан, хатуу хахир юм шиг атал

амьдралын ухаантай тэр хөгшинд сэтгэл хоргодон хоргодон байж салав. Цогтбаяртай танилцсанаас хойш Пагмажав хөгшинтэй хамт зусланд өнгөрөөсөн сүүлийн сар хүрэхгүй хугацаа хэрхэн яаж өнгөрснийг ч мэдсэнгүй. Цогтбаяр байсхийгээд л элдэв шалтаг гаргаад оройдоо ажлынхаа дараа түүн рүү давхин очно. Хааяа нэг сэвшээ зөөлөн салхи салхилан, утаа үнэртэх хаврын ойгоор Цогтбаяртай хөтлөлцөн алхаж, эсвэл кино, клипэнд гардаг шиг хөөцөлдөн гүйхэд сэтгэл нь баяр хөөрөөр гийнэ. Удахгүй зун болохоор навч нахиа нь дэлгэрээгүйгээс сүр муутай, эл хульхан харагдах энэ ой ямар гоё ногоорох бол гэлцэн хаврын урь анхилсан цэвэр тунгалаг агаарыг цээж дүүрэн амьсгалж, халуун гараа атгалцан алхсаар нэг л мэдэхэд үдэш болчихно.

Урьд нь болж өнгөрсөн бүх муу муухай явдал зүүд байсан юм шиг бүсгүйд санагдан шинээр амьдрах хүч бага багаар хуримтлагдаж эхэлжээ. Өөрийнх нь төлөө хийсэн бүхэнд нь багшдаа яаж талархахаа ч мэдэхгүй байлаа. Харин энэ үеэр Номингийн өвөө нь бурхны оронд одож, найзынх нь хурим зуны адаг сарыг хүртэл хойшилчихов. Өөртөө тохиолдсон элдэв явдлаас болоод Хандгайтад бүгээд найзынхаа хуримын бэлтгэл ажилд оролцож чадахгүй байсан Наранд энэ нь завшаантай юм шиг атал нэг л хөнгөн гуниг төрүүлчихэв. Тэгээд гэртээ ирснийхээ шөнө ёозгүй муухай зүүд зүүдлээд шөнө дунд сэрэв. Хандгайтад Цогтоотой зугаалдаг байсан хаврын ойд Номин, Барсболд хоёрын хурим болж байх юм. Хуримд оролцож буй зочид нь бүгд танихгүй хүмүүс. Ядаж Нарангийн сайн таних сүйт бүсгүйн аав, ээж, хоёр дүү нь ч байхгүй. Номингоос бусад нь тас хар гашуудлын хувцастай хүмүүс. Тэгсэн атал гадаадын кинонд гардаг шиг олон эгнээ сандалд зэрэгцэн суусан зочдын өмнө хуримлагч хоёр бие биедээ үнэнчийн тангараг тавьж, хар ламаар адислуулж байх юм. Хамгийн хачирхалтай нь найздаа баяр хүргэж баглаа цэцэг өгөх гэж очсон Наранг хэн ч олж харахгүй, үг хэлэх гэхээр дуу хоолой нь гарахгүй, тас хар гашуудлын хувцастай зочид ч, цасан цагаан өмсгөлтэй Номин ч биен дундуур нь нэвт нэвт гараад явчих нь үс арзаймаар. Нэг хартал Цогтоогоос хайрын үгийг нь анх сонссон өвгөн улиангар модны бүдүүн мөчирт хар улаан хүрээтэй өөрийнх нь зургийг хадсан байхыг үзээд давхийн сэржээ. Хамаг бие нь усан хулгана болтлоо хөлөрчээ. Айдас түгшүүрт автан хэсэг хэвтгээд сая нэг тайвшрав. Гэтэл хонгилоор нэг хүн холхиод байх аж. Унтах гэж хичнээн оролдоод тэр хөлийн чимээ нойрыг нь хулжааж орхив. Тайвширсан сэтгэл нь учир үл мэдэх далдын түгшүүрт автаж, яагаад ч юм найзынхаа хуримд хэзээ ч очихгүй юм шиг хачин мэдрэмж төрнө. Хонгилоор хүнд алхаатай хүн холхисоор л... Цаг харвал шөнийн хоёр өнгөрчихжээ. Хэн өдийд ингэж хонгилоор холхидог байнаа? Босч ус уунгаа шагайгаад хармаар сониуч зан нь хөдөлчихөв. Түүний босч ус уух чимээнээр ээж нь сэрж:

-Миний охин юунд сэрвэлзээд байгаа юм? Тайвшруулах эм уух уу? гээд өндийгөөд ирэхэд нь:

-Хэрэггүй ээ. Та унт, унт гээд дэрийг нь засч өгөв. Сүүлийн хэд хоногт ээжийгээ урьд урьдынхаас илүү өрөвдөн, юунд ч хөөрхий ээжийгээ загнаж, гомдоож, агсам хүртэл тавьж байв даа хэмээн гэмшин шаналах болоод байгаад өөрөө ч гайхна. Хүн хувь тавилангаа сонгодоггүйтэй адилхан ээжийгээ шилж голж болдоггүйг урьд нь юунд ухаарсангүй вэ?

Удалгүй ээж нь унтаад өгөв. Бүсгүй хонгил руу шагаймаар нэг л адын хүсэл төрнө. Гэрийн шаахайгаа тайлаад сэмхэн алхалсаар хаалганы дэргэд очоод хөлийн чимээ тулаад

ирэнгүүт дурангаар нь шагайлаа. Юу ч харагдсангүй. Гайхалтай юм. Яг хаалганых нь дэргэд ирэх шиг л болсон доо. Хөлийн чимээ аажуухан зүүн тийшээ алсрав. Зориг гаргаад хаалганыхаа замгийг нь эргүүлээд завсар гарган шагайлаа. Хонгилын мухарт хэн ч байхгүй атал хөлийн чимээ өөр рүү нь ойртсоор саарал өмсгөлтэй туранхай эр хүний дүрс тодрон гараараа түүнийг дуудан даллах шиг харагдав ... Айж гайхсандаа хөшиж орхив. Бүсгүй нэг л мэдэхэд хаалгаа чанга гэгч тархийтэл хаагаад өлмий дээрээ хэд үсрээд орондоо оржээ. Хөнжилдөө орж зүрхээ даран хэсэг хэвтээд овоо тайвшрав.

Түүнийг сургуульд ороогүй байхад нэг хөвгүүн манай байр хий үзэгдэлтэй, би хий юм явж байхыг шөнө харсан хэмээн хүүхдүүдийн сүнсийг зайлтал айлгаад, эцэг, эхчүүд нөгөө хүүг загнан бөөн юм болж байснаа чимээгүй болж байж билээ. Тэгэхэд Наран тавтай л байсан байх. Тэр орой ээж нь үлгэр биш харин хий үзэгдлийн тухай ярьж “Тийм юм байдаггүй юм. Бурхан ч гэж байхгүй. Эрдэмтэд хий үзэгдэл, сүнс байхгүй гэж баталсан” гэж итгэлтэй хэлж байж билээ. Тэгэхэд бурхан байдаггүй гэдэгт бүгдээрээ л итгэдэг, бас байрныхан нь одоог бодох юм бол бүгд ажил төрөлтэй, амьдралтай шал өөр цаг үе байж дээ.

Гэтэл өнөөдөр бүх юм орвонгоороо эргэчихсэн “Бурхан байхгүй” гэж тийм итгэлтэй хэлж байсан ээж нь байсхийгээд л Гандан руу шогшиж, зурмал бурхандаа зул өргөж суудаг насжуу авгай болчихсон байдаг. Тэр аймшигт үзэгдлийн тухай ээждээ ярих гэснээ больчихов. Одоо санахад өвөө нь нэг удаа сүнс сүлд нь хаясан, эсвэл удахгүй үхэх хүнд хий юм үзэгддэг юм гэнэ лээ гэж ярьж байжээ. Пагмажав эгчид ярьдаг юм уу, гэснээ бие муутай настай хүнд муу юм яриад яахав гээд больжээ.

Наран багшийнхаа ээжийг асарч байгаад гэртээ ирэнгүүт нэгэн шинэ дэлгүүрт бэлэн хувцасны худалдагчийн ажилд ороод удаагүй байжээ. Зургадугаар сар гарч, хий үзэгдлийн тухай овоо мартагдаж эхлэв. Наран Цогтбаяртай анх танилцахдаа гэрийнхнээ тэжээх гэж сургуулиасаа түр чөлөө авсан гээд хэлчихсэн байжээ. Залуу ч түүнд хөл алдаж, Наран ч Цогтоод улам улам татагдан дурлаж байлаа. Тэр Нарангийн өмнөх амьдралын тухай гадарлаа ч үгүй яваа болохоор түүнийг сахиусан тэнгэр шиг л дээдлэх нь нэг бодлын аз жаргал, нөгөө талын бөөн там байлаа. Нуусан юм хэзээд илэрдэг болохоор урьдынх нь гутамшигт амьдралыг хайрт нь нэг л өдөр мэдчих байх даа гэхээс бүсгүй үргэлжийн сэтгэлийн зовлонтой явж байлаа. Ялангуяа хаалттай бааранд нүцгэлж, нэг удаа даргынх нь өвдөг дээр нь гаран сууж, эхнэртэй нь таараад бөөн юм болж байсныг мэдвэл яана. Хүн үзэж өнгөрүүлсэн бүхнээсээ ичихээргүйгээр амьдрах нь нэр төрийн хэрэг байдаг юм байна. Одоо бодоод байхад бааранд тайчиж, мөнгөтэй зарим хүний өвөрт оролгүйгээр нэр төрөө цэвэрхэн аваад явж болох л байсан атал юунд тийм алхам хийгээ вэ? Сэвгээгүй ариун нэр төртэй байсан бол магадгүй амьдралд ганцхан тохиох хайртайгаа учирчихаад хичнээн бардам, толгой дээгүүр, сэтгэлийн зовлонгүй алхлах байсан бол?

Номингийн шахалтаар нэг өдөр Барсаа тэр дөрөв танилцаж, кино үзэв. Хөдөөнөөс хотод ирж, дээд сургуулиа төгсөөд, магистр хамгаалж, бор зүрхээрээ л амьдралын төлөө зүтгэсээр яамны ажилтан болтлоо хал үзсэн Цогтбаяр, хотын эрх танхи оюутан Барсаа хоёрын яриа, үзэл бодол тийм ч их нийлэмжтэй байж чадахгүй байлаа. Киноны дараа оройн хоолон дээр Цогтоо Нарангийн гарыг энхрийлэн атгаж суухыг Барсаа ёжтой хүйтэн харцаар ширвэн харсан нь бүсгүйн зүрхийг нь зүсээд авах мэт санагджээ. Түүний тэр харцанд

илэрсэн зэвүүцэл, ёжлол “Чи наад хүүхнээ хэн байсныг мэдэхгүй их нялуурч байх шив?” гэсэн шинжтэй. Ер нь ч Барсаа Номин тэр хоёрын үерхэлд урьдныхаасаа илүү дурамжхан хандах болсон нь бүсгүйд анзаарагдаад байлаа.

Тэр орой Наранг гэрт нь хүргэх замдаа Цогтоо “Ухаантай, даруухан тэгсэн мөртөө ийм хөөрхөн ийм охинтой учрах гээд л би 27 хүртлээ ганцаараа явсан юм байх даа. Бушуухан зун болоосой. Би чамайгаа Архангайд дагуулж очоод аав, ээжтэйгээ танилцуулмаар байна” гэж ярьж явахад бүсгүй сэтгэлийн хүнд дарамттай чимээгүйхэн сууж байлаа.

Маргааш нь Наран ажлаа тараад харьж иртэл хөршийн бүсгүй сандарсан царайтай тааралдаад мэнд мэдээд л яаран зөржээ. Гэртээ ортол Сараа нь хичээлээ цүнхлээд гарах гэж байснаа:

-Энэ Энхтуяа эгч хүүхэд халуураад гээд явж байна. Эмэнд явах хүнгүй гэнэ гэж тоосон шинжгүй хэлэв.

-Чи хүүхдий нь хараад өгөхгүй яасан юм?

-Би маргааш сэдвийн шалгалттай. Юун айлын хүүхэд харах.

-Миний дүү эмч болох хүн ш дээ. Энэрэнгүй сэтгэлгүй хүн эмч болдоггүй юм за? Саран энэ үгэнд гөлс гээд явчихав.

Хөөрхий бүсгүй. Хааяа нэг тааралдахдаа Наранг хараад хичнээн дулаахан сайхан инээмсэглэдэг билээ. Эмэгтэй хүн өөр шиг нь залуухан сайхан бүсгүйг хараад өширхүү, өөлсөн хүйтэн харцаар шилбүүрддэг бол Энхтуяа тиймгүй хүн. Туслах хэрэгтэй. Хэдхэн хормын дотор бүсгүй өндөр өсгийт, цуваа хурдан хурдан тайлан хаялж, биед эвгэйхэн хувцсаа өмсөөд тэдний хаалгыг тогшоод зогсч байлаа.

Энхтуяагийн хүүрнэл

Би ажлаа тарж ирээд хоол хийж эхэлтэл манай сонгино дуусчихжээ. Хөршийнхөөсөө л гуйхаас аргагүй. Намайг Цэндмаа гуайнд ороход дээд сургуульд сурдаг бага охин нь чихээ таглан ном уншиж, ээж нь юм индүүдэж байв. Хоёр тэрсхэн хүүтэй манайх гэж айлд зурагтын дуутай зэрэгцэн хүүхдийн дуу хадан чих дөжрөм чимээтэй байдгийн дэргэд эднийх номын сан шиг л нам гүм байх нь аятайхан. Тэгээд ч шүүгээ дүүрэн номтойг яана.

Намайг оронгуут гэрийн эзэгтэй хийж байсан юмаа орхин босч “Суугаач, миний дүү. Аяга цай уу, чихэр ид” хэмээн сайхан загнаж, гал тогооны өрөөнөөсөө хоёр том сонгино авчирч өгөв. Тэднийд сууж энэ аятайхан зантай авгайтай ганц хоёр үг солин саатмаар байвч гал дээр хоол тавьчихсан, бас хоёр “дайсан”-даа санаа зовох зэрэгцээд дараа л нэг тухтай айлчлах ам өгч яаран гарч билээ.

Манайх хотын захын хуучин байшинд амьдрах болсоор нэлээд хэдэн сар өнгөрчээ. Хотын төвд тохитой угсармал байранд амьдарч дассан надад энд нүүж ирсэн эхний нэг сар үнэхээр хэцүү байж билээ. Шавар шохой нь холторч унаад, гаднаас нь харахад хүчтэй үлээхэд нурчихмаар харагдах энэ навсархай байшинг эргэн тойрныхон нь “бранк байшин” гэж нэрлэнэ. Галладаг зуухтай, хонгилынхоо мухарт хориод айл дундаа жорлон, хүйтэн усны ганц цорготой, чийг ханхалсан ийм оромжинд амьдрана гэдэг өнгөрсөн зуунд ирчихсэн мэт цухал төрүүлдэг юм. Энд амьдардаг хүмүүс гэж хятадын оёдлын үйлдвэрийн оёдолчин, захын жижиг наймаачин, тэтгэврийн хөгшчүүд, ажилгүйчүүд гээд дандаа ядарсан эмзэг давхаргынхан. Манай хажуугийн хоёр өрөөнд суудаг Цэндмаа гуайгаас бусад хөршүүдтэйгээ би нэг л дотносч чадахгүй байлаа.

Нөхөр маань Солонгост явж ажил хийж амьдралаа дээшлүүлэхээр явахдаа байраа барьцаалан зээл авснаас л бүх юм эхэлсэн. Очоод л ганц хоёрхон сарын дотор зээлээ төлчихнө гээд явсан хүн чинь ажил олдохгүй байна хэмээн хэдэн сарыг өнгөрөөгөөд, дараа нь бөөр нь өвдлөө гэж хэвтээд ард нь үлдсэн бид гуравт мөнгө төгрөг гавьтай явуулж чадсангүй жил тойрчихсон юм. Ингээд өндөр хүүтэй зээлнээс гарахын тулд байраа зарж энд нүүж ирсэн. Ингээд амьдралаа дээшлүүлэх гэсэн биш нэг шатаар доошлуулан хотын захын энэ хуучин байшингийн хоёр өрөө оромжинд амьдрах болсон нь энэ. Манай хөршүүдээс хамгийн аятайхан айл нь Цэндмаа авгайнх санагдана. Дээд сургуульд туслах багшаар ажилладаг энэ авгай том болсон хоёр сайхан охинтой. Харин нөхөр нь яасныг бүү мэд. Нас барсан юм уу гэтэл гэрт нь зул, зураг хөрөг үзэгддэггүй, өөрөө ч тэр тухай үл ярина. Намайг заримдаа элдэвт бухимдахад тайвшруулан “Зүгээр, ээ миний дүү. Чам шиг боловсролтой хүн юу алзахав. Эрүүл саруул байхад нэг л өдөр амьдрал сайхан болоод ирнэ” хэмээн намуухан дуугаар ярина.

Нээрээ л амьдрал сайхан болох байлгүй гэсэн горьдлого л намайг зоригжуулдаг байлаа. Түүнээс биш хотын захаас хар эрт хоёр хүүгээ хөтлөн автобусанд суун хотын төвд цэцэрлэгт нь өгөөд ажилдаа хожигдолгүй очих гэж дахин нэг автобусанд сууна. Тэгээд ажлын өдөр дөнгөж эхэлж байхад би гэж сульдаж гүйцсэн амьтан ажилдаа амьсгаадан очно. Орой нь хүүхдүүдээ цэцэрлэгээс заавал оройтож аваад манаач өвгөнд нь загнуулна. Тэгээд дэлгүүрээр орж хүнсээ цуглуулаад тор дүүрэн юмтай, хоёр хүүгээ хөтлөн автобусанд чихэлдсээр

ертөнцийн мухарт байх хуучин байшиндаа ирэхэд хамар сэтлэм хахуун үнэрт чийг ханхлан угтана. Тавгай, гуравгай хоёр бандийн тоглох , хашгиралдах чимээнд хоол хийсээр орой болгоно. Үүнийг над шиг дөнгөж хорин долоотой залуу бүсгүйн амьдрал гэхэд хэцүү.

Гэвч хүн зовлонд дасдаг юм болохоор амьдраад л байлаа. Энд нүүж ирээд хагас жил боллоо. Хавар ирэхэд хүний сэтгэл бага ч гэсэн тэнийдэг бол энд нэг л биш ээ. Манай энд явган хүний ч, машины ч зам гэж үгүй тул цас хайлмагц шавар шавхайд нь гутлын өсгий шигдэн нэгшмэл муухай үнэр ханхална. Байшингаас гараад л суух ганц модон сандал ч үгүй тул хоёр хүүд минь тоглох битгий хэл хөөцөлдөөд гүйлдэх тохмын чинээ ч тэгш талбай үгүй нь бухимдал төрүүлнэ. Нөхрөөс гавьтай мөнгө төгрөг ирэхгүй л байлаа. Урьдын адил Цэндмаа эгчтэй хааяа хууч хөөрч бухимдлаа тайлдаг хэвээрээ. Хараад байтал тэдний том охин нь шөнө их оройтож ирэх бөгөөд ээж, дүү хоёртойгоо заримдаа нэлээд ширүүн харилцах нь нимгэн хананы цаанаас дуулдана. Ер нь тэднийх анх танилцахад надад санагдсан шигээ тийм ч амгалан тайван айл биш гэдэг нь мэдэгдэж эхэллээ. Нэг орой хоёр хүүгээ унтуулчихаад ном уншиж хэвтгэл гадаа эрэгтэй, эмэгтэй хоёр хүн хэрэлдэж гарлаа. Цонхоор шагайвал Цэндмаа эгчийн том охин жийпнээс түлхэгдэн буугаад “Fuck you. Муу новш...” гэхчлэн чанга чанга хараасаар орц руугаа орж хаалга тасхийлгэх нь дуулав.

Өндөр нуруутай, урт хөлтэй сүмбэ шиг л гоолигхон биетэй, задгай хүрэн үс намируулсан тэр охин хааяа тааралдахаараа гуниглангуй харцтай гоё нүдээрээ инээмсэглэн мэндлээд л зөрдөг сөн. Уг нь харах бүрд нүд баясгам сайхан бүсгүй. Бодоод байхад ээж нь бага охин Сарангаа л анагаахад сурдаг гэж ярихаас биш Нарангийнхаа тухай барагтай бол ам нээдэггүй нь ямар учиртайг одоо л гадарлаж эхэллээ. Харамсалтай юм. Тийм сайн ээжийн ийм сайхан охин ингэж явах гэж дээ. Би санаа алдаад гэрлээ унтраалаа.

Хэд хоногийн дараа бас л гадаа бөөн дуу шуу болж, манай байрныхан тэр аяараа л сэрцгээсэн биз. Цонхоор харвал Наранг хоёр залуу татаж чангаан баахан хэл ам болж байгаад нам болж машиндаа суун одоцгоов. Цаг шөнийн 00 өнгөрч байлаа. Энэ удаа хэрүүл гэрт нь үргэлжлэв. Ээж нь бодвол улс амьтнаас зовоход яадаг юм гэсэн бололтой. Нарангийн дуу хадаад явчихлаа.

-Та нарын сайн сайхан нэр төрийг би бузарлаад байна уу? Аргагүй ээ, та хоёр чинь над шиг бузар амьтад биш, ичихээс яахав. Хоёулаа эрдэм номын мөр хөөсөн, ёс суртахуун ярьсан, хүнд яавал сайн сайхан харагдах вэ гэж ядсан улсууд. Тэхдээ миний авчирсан бузар мөнгөөр амьдардагтаа ичихгүй ээ. Би энэ өмхий нүхнээс чинь яваад өгч чаднаа. Тэхдээ би муу ч гэсэн, муухай ч гэсэн та хоёрыг далан мянган төгрөгөөр яаж амьдрах юм бэ? гэж өрөвдөх сэтгэл надад байдаг юм. Ээж ээ, та намайг энэ хажуугийн хүүхэнд юу гэж ярьсан бэ? Эсвэл яачихсан хүүхэд ийм байдаг юм. Сайн сайхан хүн болгох гэж яаж ч улайгаад дийлдэхгүй юм гээд л бөөн зовлон тоочсон уу? Алив, Сараа босоод ир. Юундаа муухай хараав. Би чиний төлбөрийг төлдөггүй юу. Чи амьдралын ухаан суухгүй бол анагаахын дээд төгсөөд эмчийн диплом аваад л сайхан амьдарна гэвэл гонж, мэдэв үү? гэхчлэн баахан агсам тавьж байгаад чимээгүй боллоо.

Маргааш нь ажил тарсны дараа Цэндмаа эгч тавагтай хуушуур барьсаар манайд гэмшингүй царайлан орж ирлээ. Тэгээд миний хийж өгсөн цайг оочлон санаа алдаж:

-Өчигдөр манай том охин хашгичаад та нарыг унтуулсангүй юу? Эгч нь уучлал гуйх гэж явна. Хүүхдийн биеийг нь төрүүлэхээс ухааныг нь төрүүлэхгүй юм даа. Уг нь энэ жил их сургууль төгсч байх ёстой хүүхэд. Сургуулиа хаячихаад замаа алдаж байна. Багадаа сайн л охин байсан. Эгч нь энэ хүүхдийг эрдэм номтой сайн хүн болгох гээд дийлсэнгүй хэмээн зовлон ярилаа. Надтай л адилхан эх хүн муу үр хүүхдээсээ болж энэлж зовж яваад нь би өрөвдөж байсан ч хэлэх юм олдохгүй сонсож л суулаа. Ер нь ч би хүнд элдвийг зөвлөж цэцэрхээд байх дургүй хүн л дээ. Нөгөө талаар охинд нь бүх бурууг өгч болохгүй мэт санагдаад байсан юм. Тэгээд ч хүнийг зовлонгоо ярихад нь дуугүй л сонсох шиг их дэмжлэг байдаггүйг би мэдэх юм чинь. Тэр манайд нэлээн удаан сууж хоёр хүүг өхөөрдөж байгаад овоо тайвшраад гарлаа.

Зуны эхээр нэг орой бага хүү маань гэнэт хүчтэй халууран сандаргав. Түргэн дуудаж үзүүлээд эм тариа авах хэрэгтэй байлаа. Ийм үед л би тэсвэрлэшгүй их ганцаарддаг байв. Энэ байрныхнаас хамгийн дотно ганц хөршийнхөөсөө л тусламж гуйхаар орлоо. Цэндмаа эгч гэртээ байсангүй. Улсын шалгалтын комисст орчихсон гэртээ бараг ирэхгүй байгаа гэж бага охин Саран нь хэллээ. Хүүхдийн эмэнд яваад өгөөч гэж би түүнээс гуйлаа. Сараа маргааш шалгалттай болохоор одоо интернетэд суух гэж байна, завтай бол яваад л өгмөөр байна хэмээн эвтэйхэн татгалзав. Намайг гэр рүүгээ орох гэтэл Наран гэр тааралдлаа. Мэндлээд зөрөх гэснээ:

-Миний дүү хоёр хүүг минь харж байхгүй юу. Бага нь халуураад эм тариа авчрах хэрэгтэй байна гэхэд тэр нүүр рүүгээ орж ирээд байгаа үсээ хумин арагш шидээд:

-Тэгэлгүй яахав. Харин та хүүхдүүдтэйгээ үлдсэн нь дээр байх. Би хувцсаа сольчихоод очъё гэж уриалгахан хэлэхэд нь сэтгэл амсхийгээд ирлээ. Хэдхэн хормын дараа Наран өндөр өсгийтэй гутал, бариу дэгжин цуваа сольж, пүүз, жийнсэн хүрэмтэй орж ирээд эмийн жор, мөнгө аваад яаран гарч одлоо. Тэр эмийн сангаас ирээд ч гэртээ орсонгүй, том хүүг хооллон унтуулах зэргээр үүр цайтал хамт сууж хань болсонд нь би яаж талархахаа мэдэхгүй баярлаж билээ.

Хоёр хүүг унтсан хойно тэр надтай хамт цайлж суухдаа миний нүд рүү эгцлэн ширтэж:

-Эртүүд би агсам тавиад та нарыг унтуулаагүй бол уучлаарай. Би буруу замаар будаа тээж яваа хүн гэдгээ мэднээ. Гэхдээ ... гээд санаа алдсанаа үсээ чихнийхээ араар хавчуулаад санаа алдаж:

-Ээж намайг муу охин л гэдэг юм. Би хоёрдугаар курст ортлоо сайн хүн байх гэж их хичээсэн. Үнэхээр их хичээсэн. Би оюутны илтгэлийн уралдаануудад дандаа шалгарч байсан. Бүх шалгалтуудаа дандаа онц өгч байсан. Ээж намайг эрдэм номтой л хүн болох юм бол сайхан амьдарна гэж сургадаг. Өөрөө ч дээд сургуульд насаараа туслах багш хийж байгаагаараа бахархдаг юм. Гэхдээ бидэн шиг ядуу хүмүүст эрдэм ном сурснаар аз жаргал ирнэ гэж үү? Энэ чинь надад бараг доромжлол юм шиг санагддаг юм. Би улстөр судлаачийн ангид сурч байсан. Философи нэлээд сонирхдог байсан. “А бодомж А баримттайгаа дүйж байвал үнэн” гэдэг биз дээ? гэснээ яриагаа таслан над руу харж:

-Миний яриа танд яришигтай санагдаагүй биз дээ? гэхэд нь би:

-Үгүй ээ, яалаа гэж. Маргааш тэгээд ч амралтын өдөр юм чинь. Би хааяа ч гэсэн ингэж ярилцаж суух дуртай гэхэд тэр инээж:

-Тан шиг ийм сайн сонсогчтой бол яриад л баймаар санагддаг юм. Би юу гэж ярьж байлаа. Аа, тийм. Тэгэхээр “Наран их эрдэмтэй хүн болбол сайхан амьдарна“ гэдгийг А бодомж гэж бодъё. Гэтэл би их сургуулийг улстөр судлаачаар төгсөөд юу хийх вэ? Намайг заавал магистр төгсч байж багшлахыг зөвшөөрнө гэсэн. Тэр их мөнгө надад байхгүй. Тэгээд ч багшлаад сайндаа л ээжээс арай илүү цалин авах юм биз дээ? За, тэгвэл ямар нэгэн намын аппаратад ажилд оръё гэтэл цалин багатай, тэгээд шалиг дарга нарынх нь зугаа гаргагч л болох юм байна лээ. Энэ тэгээд сайхан амьдрал мөн үү? Тэгэхээр А бодомж А баримтаар батлагдахгүй нь. Ингээд л би сургуулиа хаячихсан. Тэгээд ч намайг гуравдугаар курсэд ороход Сараа бас арваа төгссөн. Хоёр оюутан охин ээжийн далан мянган төгрөгийн цалингаар хооллож, хувцаслаж, унаанд сууж, ном дэвтрээ авч их эрдмийн оройд хүрнэ гэдэг жинхэнэ үл гүйцэлдэх мөрөөдөл байсан. Энийг ээж мэдсээр байсан мөртөө л эрдэм сур, эрдэм сур гэнэ. Өөрөө тэр сайхан сургууль дээрээ ямар байдалтай ажилладаг гээч. Гүзээлж, хамар нь улайчихсан хоцрогдсон хэдэн бэртэгчин өвгөн багш нарыг тэр доктор, энэ профессороо гээд л долигоноод цайг нь зөөж, архийг нь хундгалаад л, лекцийг нь хуулж өгөөд л яг л шивэгчин шиг. Тэгээд түүнийгээ мэдэхгүй, эрдэм номтой, боловсролтой хүмүүстэй ажиллах сайхан гэж ярина. Ой гутмаар. Та манай аавыг хаана байдаг бол гэж гайхдаг л биз, тийм үү? Тэр чинь Сарааг төрөхөд хүү биш гэж голоод бид гурвыг хаяад явчихсан юм. Ээж маань амьдралын ямар ч ухаангүй хүн. Тэгэхэд л бүсээ чангалаад амьдралаа өөд нь татах, сургуулиас өөр газарт ажиллах боломж хайх байсан юм. Ядахнаа л Сараа бид хоёрт ажил сургаагүй. Ном унш, ном унш л гэнэ. Би сургуулиа хаячихаад солонгос айлд гэрийн үйлчлэгч хийж байхдаа харин хоол хийж, талх барьж, кимчи хүртэл дарж сурсан. Тэр айлынхныг буцсаны дараа нэг бааранд стриптиз үзүүлдэг болсон. Цалингийнх нь ахиуг бодоод л тэр. Тэгээд нуух юу байхав, гайгүй мөнгөтэй хүмүүс татаж чангаахаар нь үгүй гэхээ больсон. Шөнө бүхэн хоногоор арван мянга гээд зогсч байдаг янхан болоогүй л дээ. Та битгий тэгж бодоорой. Тэгэхдээ ингэж яваадаа би мэдээж их гутардаг. Тэглээ гээд яах юм, ном уншихаас өөр юм мэдэхгүй дүүгээ, сарын цалин нь хоолондоо ч хүрдэггүй шахуу мөртөө сохроор эрдэм ном шүтсэн ээжийгээ яах юм бэ? Яая, гэхэв. Тэр хоёр миний муу муухайг гайхаад олж ирсэн мөнгийг минь идэж, өмсч байгаа хүмүүс. Энэ байр, энд амьдардаг энэ ядуу хүмүүс, шавар шавхайтай гудамж, бид хоёрыг хаяж явснаасаа хойш ганц удаа яаж байна гэж асуугаагүй эцгээ бодохоор ой гутдаг юм. Сараа сайн охин. Тэгээд яаж байна, хажуу айлынх нь хүүхэд нь өвдчихөөд байхад шалгалттай гээд л яваад өгч байгаа юм. Өөрөө эмч болох хүн ш дээ. Эмч хүний энэрэнгүй сэтгэлийг тэр номноос олж авах юм уу? Бүү мэд. Төрсөн дүү минь болохоор өрөвдөх л юм даа. Миний дүү чинь Дамдинсүрэн гуайн зохиолд гардаг “Гологдсон хүүхэн“ байхгүй юу. Орчин үеийн гологдсон хүүхнүүд гэдэг чинь бид хоёр л байна. Харин би сайхан нэг сайн залуутай танилцсан. Миний урьд нь юу хийж явсныг мэдэх юм бол яахыг бүү мэд гээд ширээний тавцанг гараараа үрчин суулаа. Надад хэлэх үг олдсонгүй. Худлаа сургааль хэлэлтэй нь биш. Надад түүний яриа их юм бодогдуулсан юм. Тэр инээмсэглээд:

-Сэтгэлээ онгойтол ярих сайхан юм аа. Танд л гэж хэлэхэд энэ байшин тан шиг хүний амьдрах газар биш шүү. Нөхрийнхөө явуулсан мөнгийг цуглуулж байгаад энэ оромжноос л

хурдан нүүгээрэй. Энд үлдэх юм бол та бидэн шиг шаарлагдсан хүмүүсийн нэг болно гэчихээд гараад явчихсан юм. Түүнийг муу охин гэж бодож байсандаа би их л ичиж билээ.

Бага хүүгийн маань халуун буугаад хөлс нь бурзайчихсан хөөрхөн унтаж байлаа. Би оюутан байхдаа нэг философийн номноос уншаад одоо ч мартагдаагүй үлдсэн нэг үгийг эргэн санав. “Ажил мэргэжил бол мөнгө олдгоороо сайн зүйл, мөнгө нь завь худалдан авч болдгоороо сайн зүйл, завь нь далай тэнгист аялж болдгоороо сайн зүйл. Тэгвэл аялал нь юунд сайн зүйл вэ? Эрүүл мэндэд сайн зүйл. Тэгвэл эрүүл байх нь юунд сайн юм бэ? Эрүүл биетэй байх нь хүнд өөрт нь л сайн. Тэгэхээр зарим зүйлийн хувьд сайн гэгдэх нь өөрийн тусын тулд л байдаг” гэсэн үг яагаад ч юм санаанд орж ирээд удтал нойр хулжин хэвтэж билээ. Наран миний анх бодсон шиг муу охин биш байсан нь яамай даа. Удалгүй нөхөр утсаар ярьж төмөрлөгийн үйлдвэрт цалин сайтай ажилд орсноо дуулгасан нь үүлний чөлөөгөөр нарны гэрэл гялсхийх шиг сайхан мэдээ байлаа.

Наран хөршийнхөө бүсгүйтэй ийнхүү дотносон танилцаж, сэтгэлдээ хадгалж явсан бүхнээ сэтгэл онгойтол яриад гэртээ орсны дараа нэг л уужраад явчих шиг болжээ. Цогтоод яг ингээд л ярьчихаж болдог сон бол...

Маргааш нь Цогтоо үдийн цайны цагаар уулзангуут “Дарга намайг үерхдэг бүсгүйгээ танилцуул гэсэн. Чимгээ эгч чи бид хоёрыг нөгөөдөр гэртээ урьсан” гэдэг байгаа. Тэр хүний өвөр дээр шалдан сууж байсан, Баясаагийн хатгаасаар мессеж хүртэл бичиж, нэг хөнжилд орохоо дөхсөн байж одоо туслахтай нь үерхдэг бүсгүй гээд ичих ч үгүй гэрт нь очих гэж үү? Үгүй, болохгүй. Наранг царай нь нэг л хувираад явчихыг Цогтбаяр гайхан харж байлаа.

-Хайр аа, д-д-дараа больё, тэгэх үү? Би нөгөөдөр завгүй. Юу л даа, төлөвлөөгүй байсан болохоор...

-Чи надаас нэг л юм нуугаад байх юм аа. Саяхан инээмсэглэн байсан залуугийн нүд хүйтэрч, үл итгэсэн харцаар ширтэхийг хараад Наран бүр ч сандарчихав.

-За, за би ажлаа зохицуулчихъя, тэгэх үү? Хайр аа? Чи ингээд уурлахаараа муухай болчих юм аа гээд үсийг нь илж чихэн дээр нь үнсээд авав. Туршлагагүй охидыг бодвол эрчүүдийн занг гадарладгийн хэрэг юу билээ. Цагаа олж бууж өгч чаддаг байх хэрэгтэй. Тэгээд хүчээр сэтгэлийн зовлонгоо нуун инээмсэглэж:

-Орой уулзах уу? гэж энхрийхэн дуугаар асууж чадлаа.

-Ёстой завдахгүй. Маргааш сайдын зөвлөлийн хуралтай. Сууж юм хийх хэрэгтэй байна. Даргын семинарт тавих илтгэлийг бэлтгэнэ.

-За, за. Чи ч их юм сурч байгаа байх даа.

-Тийм шүү. Анх яаманд орохдоо ёстой түүхий байсан байгаа юм чинь. Чи ч гэсэн сургуулиа төгсөөд төрийн байгууллагад ажиллаж үзэх хэрэгтэй гэж сургаад авахад нь бүсгүйн инээд хүрч байлаа.

Тэр хоёрыг хоолны газраас хөтлөлцөн инээмсэглэн гарцгаахыг нэг хүн машиныхаа хар шилний цаанаас хүйтнээр инээмсэглэн харж суулаа.

-Хаахнуур, юу хийж явсныгаа нуугаад байж болно гэж боддог юм байх даа, энэ хүүхнүүд? Гэнэн байна даа, хонгор минь гэж тэр бодоод Наранг залуугаасаа салж ажил руугаа ормогц гар утас руу нь залгав.

-За хонгор бүсгүй минь үсээ сүлжчихээд даруухан царайлаад нөхөртэй болчих санаатай явна уу?

Бүсгүйн зүрх палхийгээд явчихлаа. Баясаа...

-Сайн уу?

-Хуучин мэргэжлээ мартчихаагүй биз дээ?

-Мартчихсан бол чи яах юм?

-Юуг ч мартаж болдоггүй юм даа, хонгор минь. Мартсан юмыг сануулж бас болно ш дээ.

-Чамд юу хэрэгтэй юм? Би өрөө төлсөн биз дээ?

-Байз, байз. Өнөө орой жаахан мөнгөний ажил санал болгох гэсэн юм. Шинэ гэр бүлд мөнгө хэрэгтэй ш дээ. Хэ, хэ.

Наран утсаа тасалчихав. Гэтэл мөчийн дараа Баясаа гоё үнэртэй усаа сэнгэнүүлсээр ороод ирчихсэн лангууных нь өмнө зогсч байлаа.

Мэдэхгүй хүнд бол ганган дэгжин, хажуугаараа зөрсөн бүсгүйд зам тавьж өгөөд боловсон ч гэж хачин амьтан. Тэр Нарангийн нүүр рүү гилжийн чихэнд нь:

-Зарим зургуудыг чинь аваад ирсэн. Өнгөрснийг чинь сануулах гээд... гэнгүүт түүний бааранд тайчиж байгаа хэдэн гэрэл зураг гарган харуулав.

-Өөдгүй шаар!

-Чи ч гэсэн өөдтэй амьтан байгаагүйгээ санаарай, хонгор минь. Энэ зургууд дээр нэмээд найз залуугийнхаа даргын өвөр дээр маяглаж суугааг чинь мессенжерээр цацчихаж болох л юм.

-Чи надаар яах гээд байгаа юм бэ? Наран уурандаа хүрэмнийх нь энгэрээс зуураад авчээ.

-Тайвшир, тайвшир. Өвөл манайд ирж байсан солонгосууд чамаар вип өрөөнд үйлчлүүлнэ гээд байна. Залуу хосуудад мөнгө илүүдэх биш дээ.

-Чадахгүй ээ! Эсэргүүцээд нэмэргүйг ухаарч байсан ч бүсгүй бууж өгөхийг хүсэхгүй байлаа.

-Тэгвэл энэ зурагнууд чинь мессенжэрээр тарах болж дээ гээд Баясгалан гэмгүй царайлан хаалга руу эргэлээ.

-Хүлээгээч!

Наран нэг л мэдэхэд түүнийг гүйцэж очоод хүрэмнийх нь ханцуйг татан эргүүлж:

-Тэгвэл надад ч бас чиний тухай цагдаа магдаад дуулгах юм байгаа шүү хэмээн хорсолтойгоор ширтлээ.

-За боль доо, Нараа.

-Нэгдүгээр сарын 5-ыг санаж байна уу? 13 настай Баярчимэг гэдэг онгон охиныг 1500 доллараар хэний өвөрт хийлээ, дараа нь тэр охин цус алдаад юу боллоо? Санаарай чи. Онгон охин олж өгдөг дарга, сайд, гишүүдийн чинь нэрийг мэдэхгүй гэж бодоо юу? Жагсаалт гаргасан ч болно.

-Муу гичий!

-Тэр охины гэрийн хаягийг нь ч би мэднэ.

Баясгалан огцом эргэн гарч одлоо.

Өөртөө байгаа хөзрийн тамгыг дэмий л ил гаргачихав уу? Тохиролцож болох л байсан даа хэмээн бүсгүй гэнэт амаа барив.

Сэтгэл санааны тэнцвэр алдагдан тархи толгойд нь элдэв бодол орж ирэх боловч эцсийн гарцыг олж яагаад ч чадахгүй мухардан цөхрөлд автагдана. Цогтоо руу залгах гэснээ болив. Өөрийнх нь булингарт өнгөрсөн амьдралын тухай гадарлаа ч үгүй яваа тэр залууд ариухан амьтны дүр эсгэж эсгэчихээд ямар нүүрээрээ үнэн нүүр царайгаа харуулах гээ вэ? Уг нь шинэ ажилд ороод уулзаж учирдаг залуутай болоод байгааг гадарласан ээж, дүү хоёр нь түүний төлөө хичнээн баяртай байлаа даа.

-Миний охин, цаад залуугаа гэртээ авчирч ээждээ үзүүлэхгүй юм уу? гэж хоёр хоногийн өмнө оройн хоолоо идэж байсан ээжийгээ нэлээд хулгаж байгаад хэлэхэд нь:

-Үзүүлэх ээ? Тэр чинь ямар шинэ гутал биш дээ гээд тас тас хөхөрч байж билээ.

-Би харсаан. Ёстой гоё ах байна лээ гэж тэгэхэд эгчийгээ даган инээж суусан Сараа хэлээд гурвуулаа ямар баяр хөөртэй хооллож байлаа. Амьдралын сайхан нь элэг бүтэн, инээж хөхрөөд, сэтгэл амар амгалан сууж байхад л оршдог юм биш үү?

Тэр өдөр дэлгүүр нь хүн цөөнтэй байсан нь аз. Нэг л мэдэхэд ажил тарж байлаа. Хэдийгээр Цогтоо уулзах завгүй гэсэн ч яагаад ч юм бараагийг нь хармаар санагдаад нарийн

боов аваачиж өгөх нэрээр яаман дээр нь очиж халти уулзаад гарахад долоо өнгөрч байв.

-Чи минь яасан ядруу царайтай харагдах юм бэ? Эртхэн харьж амар даа гэж Цогтоо хэлээд нүдэн дээр нь үнссэнийг мартахын аргагүй. Урьд нь олон эрд үнсүүлж, үнсэлцэж явсаан. Гэхдээ тэдний хэн нь ч ингэж нүдэн дээр нь хайр дүүрэн үнсэж байгаагүй.

Би яасан азгүй амьтан бэ? Ядуу зүдүү гээд заавал нүцгэлж, тайчиж, мөнгөтэй хүний өвөрт оролгүйгээр амьдарч болох л байсан. Амьдралд мөнгөнөөс үнэтэй юм байдаг нь цэвэр ариун нэр төр л байдгийг юунд ухаарсангүй вэ? гэхээс цээж дүүрэн харуусал.

Банкаар орж дансныхаа үлдэгдлийг цөмий нь хаман авч дүүгийнхээ нэр дээр хадгалуулаад гарахад сэтгэл нь түр амсхийх шиг. Уг нь тэр Цасчимэг багшдаа өрөө төлөх мөнгө хурааж байсан сан. Гэтэл одоо нэгэнт бүх юм өнгөрсөн мэт санагдаад тэр нэгэн шөнө үзэгдсэн өнөөх ёрын хий үзэгдэл гар даллан дуудаад байсан нь нүдэнд харагдах шиг нэг л муу совин татах аж..

Банкнаас гарч ирээд замын хажууд зогсон такси барьдаг юм уу гэж бодох зуур бүх юм хоромхон зуурт болоод өнгөрчээ. Жижигхэн хар тэрэг эрчээрээ давхин орж ирээд дайрах шиг болсноо тархиараа нэг хатуу юмыг түгхийтэл мөргөхөд нүд нь эхлээд харанхуйлнаа хашгирах гэтэл дуу нь гарсангүй цээжин дотроо чимээгүйхэн хашгираад, нүд сохлом хурц гэрэл үзэх шиг болох мөчид л төгсгөл ирснийг ухаарав... Унтарч буй ой ухаанд нь орж ирсэн сүүлчийн бодол нь дараагийн төрөлдөө сайн охин байх сан...

Яг энэ үеэр Чинбат сайдад нэр дэвшигчийг хэлэлцэх намын бүлгийнхээ хурлаас нэрээ татаж аваад сэтгэлээсээ нэг том дарамт аваад хаячих шиг болжээ. Гадаа гудамжинд гарч ирээд зуны эхэн сарын оройн бүлээхэн салхинд зогсоод эхнэр рүүгээ залган:

-Хайр нь сайдад нэр дэвшихээс татгалзчихлаа гэж хэлэхдээ утасны цаана Чимгээгийн царай хэрхэн гийгээд явчихаж байгааг төсөөлж байлаа. Цаашид эхнэртээ анхаарал тавьж, гэр бүлдээ, хүүдээ илүү их цаг гарганаа. Алдаагаа давтахгүй бол амьдрал сайхан гэсэн бодол толгойд нь орж ирлээ.

2007 он

Table of Contents

[Чимээгүй хашгираан](#)
[Энхтуяагийн хүүрнэл](#)